



“ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ЖУРАМ”-ЫН ТАЙЛБАР

ТӨЛБӨР ТООЦООНЫ ГАЗАР

2024 ОН

ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ЖУРАМ

АГУУЛГА

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	4
ХОЁР. ХҮСЭЛТ ГАРГАГЧИД ТАВИХ ШААРДЛАГА	8
Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч	8
Систем ажиллуулах хүсэлт гаргагч	12
Хүсэлт гаргагчийн мэдээллийн технологи, тасралтгүй ажиллагаанд тавих шаардлага.....	14
ГУРАВ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИД ТАВИХ НЭМЭЛТ ШААРДЛАГА	16
Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх хүсэлт гаргагч	16
Карт гаргах хүсэлт гаргагч.....	16
Карт хүлээн авах хүсэлт гаргагч.....	17
Цахим мөнгө гаргах хүсэлт гаргагч	18
Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх хүсэлт гаргагч	19
Аутсорсингийн үйлчилгээ авах хүсэлт гаргагч.....	20
Гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч	21
ДӨРӨВ.ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	21
ТАВ.ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА	24
Карт гаргах зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлийн нөхцөл	27
Карт хүлээн авах зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлийн нөхцөл	29
Карт гаргагч, хүлээн авагч, цахим хэтэвчийн нийтлэг эрх, үүрэг.....	30
Цахим мөнгө гаргах зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлийн нөхцөл.....	32
Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрөл	33
эзэмшигчийн зөвшөөрлийн нөхцөл.....	33
ЗУРГАА.СИСТЕМ АЖИЛЛУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН	34
ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА	34
ДОЛОО. ИННОВАЦИЙН ОФФИС	36
НАЙМ.ХЯНАЛТ, ТАЙЛАН МЭДЭЭ, ХАРИУЦЛАГА	37
Хяналт	37
Тайлан мэдээ.....	39
Хариуцлага	41
<i>Хавсралт</i>	42
ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ	42
ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ.....	42
ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДӨЛД ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ	45
АУТСОРСИНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН	65
ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ	65

ТӨЛБӨР ТООЦООНЫ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ	68
ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ	68
ГЭРЭЭТ ТӨЛӨӨЛӨГЧӨӨР ДАМЖУУЛАН ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ	70
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ХАЯГ, БАЙРШИЛ, НЭРИЙН ӨӨРЧЛӨЛТ БҮРТГЭХ МАЯГТ	84
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ ӨӨРЧЛӨГДӨХӨД	85
БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ	85
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НЭР ӨӨРЧЛӨХ ӨРГӨДӨЛД.....	85
ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ	85
БАТАЛГААНЫ МАЯГТ	86
ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ОРОЛЦОГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД	87
ГАЗАР ДЭЭР НЬ ХИЙХ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ.....	87

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэ журмын зорилго нь Монголбанкнаас Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10.1-т заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргагчид тавих шаардлагыг тодорхойлох, хүсэлт гаргагч нь хууль тогтоомжид заасан шаардлага, нөхцөлийг хангасан эсэхийг судалж хяналт тавих, зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлага, зөвшөөрлийн нөхцөлийг тогтоох, зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Тайлбар: Энэхүү баримт бичиг нь “Төлбөрийн системийн журам”-ын тайлбар, тодруулга, хэрхэн мөрдөх заавар юм. Журмын заалт болгоны дор шаардлагатай бол нэмэлт тайлбарыг оруулсан байгаа болно.

1.2 Энэ журам нь Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцтэй байна.

1.3 Энэ журамд заасан нэр томъёог Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид тодорхойлсон утгаар ойлгоно.

Тайлбар: Энэ журамд ашиглагдаж байгаа нийт нэр томъёо, үг хэллэгийг Үндэсний төлбөрийн системийн тухай (ҮТС) хуулийн 5.1.1 - 5.1.36-д заасан байгаа.

1.4 Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10.1 болон 10.2-т заасны дагуу Монголбанк нь энэ журмын шаардлагыг хангасан этгээдэд дараах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг дангаар нь, эсхүл хамтад нь олгоно:

Тайлбар: Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10.1-т заасан Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг авсны үндсэн дээр дараах зөвшөөрлөөс авч болно. Эрхлэх үйл ажиллагаанаас хамаарч хэд хэдэн зөвшөөрөл зэрэг авч болно. Зөвшөөрөл авсан этгээдийг Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч гэнэ.

1.4.1 Систем ажиллуулах;

Тайлбар: Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.5-д заасны дагуу систем гэдэгт төлбөр тооцооны систем (RTGS), клирингийн систем (ACH, картын клиринг) зэрэг хамаарна. Эдгээр системийг ажиллуулах этгээд нь энэхүү зөвшөөрлийг авсан байх шаардлагатай.

1.4.2 Төлбөрийн карт (цаашид “карт” гэх) гаргах зорилгоор төлбөрийн үйлчилгээ үзүүлэх;

Тайлбар: Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10.1.4-т “Төлбөрийн хэрэгсэл гаргах, хүлээн авах” гэж заасны дагуу энэ зөвшөөрлийг олгоно. Төлбөрийн карт гаргах зөвшөөрөл авахдаа гаргах картын брэнд тус бүрийг зөвшөөрлийн хүсэлтэнд дурдсан байх шаардлагатай. Зөвшөөрөл авсны дараа картын брэнд (Mastercard, Visa гэх мэт) нэмэх бол холбогдох мэдээллийг Монголбанканд ирүүлэн дүгнэлт гаргуулна.

1.4.3 Карт хүлээн авах зорилгоор төлбөрийн үйлчилгээ үзүүлэх;

Тайлбар: Төлбөрийн карт хүлээн авах зөвшөөрлийг дангаар авч болох бөгөөд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10.1.4-т “Төлбөрийн хэрэгсэл гаргах, хүлээн авах” гэж заасны дагуу энэ зөвшөөрлийг олгоно. Карт хүлээн авах зөвшөөрөлтэй этгээд нь Монгол Улсын нутаг дэвсгэрт гаргасан бүх төлбөрийн картыг хүлээн авах үүрэгтэй бөгөөд картын брэнд тус бүрт дүгнэлт авах шаардлагагүй.

1.4.4 Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх;

Тайлбар: Банкнаас бусад байгууллагын клирингийн системээр дамжуулсан гүйлгээний settlement-ийг Банксүлжээ (RTGS) системд тухайн байгууллагын төлбөр тооцооны төлөөлөгч банк нь эцэслэн гүйцэтгэнэ. Банкнаас бусад байгууллага нь Монголбанк дээр данстай байж болохгүй, RTGS системд өөрийн гүйлгээний settlement-ийг гүйцэтгэх боломжгүй.

1.4.5 Гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх;

Тайлбар: Гэрээт төлөөлөгч гэж төлбөрийн үйлчилгээн дэх agent буюу төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн нэрийн өмнөөс тухайн үйлчилгээг үзүүлэх эрхтэй иргэн, хуулийн этгээдийг хэлнэ.

1.4.6 Аутсорсингийн үйлчилгээ авах;

Тайлбар: Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн үндсэн үйл ажиллагааг бүхлээр нь эсхүл хэсэгчлэн өөр, бусад хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх гэж байгаа, хүний нөөцийн эсхүл техник технологийн туслалцаа авч байгаа тохиолдолд аутсорсингийн зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Энэ зөвшөөрлийг төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч буюу банк, ББСБ, финтек байгууллага нь авах бөгөөд зөвшөөрөлтэй этгээд нь хэд хэдэн байгууллагаас аутсорсингийн үйлчилгээ авч болно. Харин банк, ББСБ, финтектэй хамтран ажиллаж буй аутсорсингийн үйлчилгээ үзүүлэх байгууллага нь тусгайлсан зөвшөөрөл авах шаардлагагүй.

1.4.7 Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх зорилгоор төлбөрийн үйлчилгээ үзүүлэх;

Тайлбар: Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг гэдэг нь хэрэглэгчийн мөнгийг өөр дээрээ байршуулж татан төвлөрүүлэхгүйгээр, банкны данс, эсхүл цахим мөнгөний дансанд байршсан мөнгөн хөрөнгийг цахим төхөөрөмжийн тусламжтайгаар хэрэглэгчийн нэрийн өмнөөс шилжүүлэх, гүйлгээ хийх, төлбөр төлөх үйл ажиллагааг хэлнэ. Мөнгөн хөрөнгө татан төвлөрүүлэхгүйгээр зээл олгосны үндсэн дээр эсхүл бараа ажил үйлчилгээний төлбөрийг хуваарийн дагуу хуваан төлөх үйлчилгээ нь үүнд хамаарч болно.

1.4.8 Цахим мөнгө гаргах зорилгоор төлбөрийн үйлчилгээ үзүүлэх.

Тайлбар: Цахим мөнгө нь жижиглэнийн, өдөр тутмын төлбөр төлөхөд зориулсан төлбөрийн хэрэгсэл бөгөөд нэг гүйлгээний дүн нь Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан хязгаар (5 сая төгрөг)-аар хязгаарлагдана. Цахим мөнгө нь өндөр дүнтэй хөрөнгө оруулалт хийх, үл хөдлөх хөрөнгө худалдаж авах зорилготой төлбөрийн хэрэгсэл биш юм.

1.5 Хүсэлт гаргагч нь энэ журмын 1.4-т заасан үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл авах, сунгах хүсэлт гаргасан этгээд байна.

Тайлбар: Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10.1, энэ журмын 1.4-т заасан зөвшөөрлийг авахаар Монголбанканд өргөдөл, баримт бичиг ирүүлсэн этгээдийг хүсэлт гаргагч гэнэ.

1.6 *Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.3-т заасны дагуу төлбөр тооцооны системийг зөвхөн Монголбанк ажиллуулах бөгөөд тус систем нь “Банксүлжээ” систем байна.*

Тайлбар: Төлбөр тооцооны буюу RTGS системийг зөвхөн Монголбанк ажиллуулахаар Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасан байгаа. Энэ системийн нэр нь “Банксүлжээ” байна.

1.7 *Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.24-т заасан карт нь ISO/IEC 7810 ID-1 стандартын бэлдэц дээр картын мэдээллийг хэвлэсэн, EMV стандарт хангасан чип болон соронзон тууз бүхий төлбөрийн хэрэгсэл байна.*

Тайлбар: Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.24-т заасан төлбөрийн карт нь эдгээр стандартуудыг хангасан байна.

1.8 *Карт, картын мэдээлэл ашиглан, эсхүл хэрэглэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч хооронд тохирсон аливаа хэлбэрийн мэдээлэл ашиглан гүйлгээ үүсгэж байгаа төхөөрөмж, програм хангамж нь цахим мэдээ үүсгэгч байна.*

Тайлбар: Цахим мэдээ үүсгэгчийн тодорхойлолтыг өргөжүүлсэн. Цахим мэдээ үүсгэгч нь АТМ, ПОС, ПОБ гэх мэт төлбөрийн картын гүйлгээг үүсгэж байгаа төхөөрөмжөөр хязгаарлагдахгүй, бүх төрлийн гүйлгээг анхлан үүсгэж байгаа ухаалаг утсан дахь банкны аппликейшн, интернэт банкны үйлчилгээ гэх мэт төхөөрөмж, програм хангамж орно.

1.9 *Бараа, ажил үйлчилгээний төлбөрийг цахим мөнгө, карт зэрэг Монголбанкны зөвшөөрөлтэй төлбөрийн хэрэгсэл ашиглан банкан дахь, эсхүл цахим мөнгө гаргагч дээрх дансанд хүлээн авахаар гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээд нь мерчант байна.*

1.10 *Карт хүлээн авагчийн системд холбогдсон, карт, картын мэдээллээр идэвхжиж гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгч нь АТМ байна.*

Тайлбар: Төлбөрийн карт ашиглан бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ хийдэг бүх төрлийн автомат төхөөрөмжийг АТМ гэж тодорхойлно. Хийх боломжтой нэмэлт үйлдлээс хамааран АТМ нь CDM, CRM, Киоск гэх мэт төрөл байж болно.

1.11 *Карт хүлээн авагчийн системд холбогдсон, төлбөр хийх зориулалтаар мерчант дээр байршуулсан, карт, картын мэдээллээр идэвхжиж гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгч нь ПОС төхөөрөмж байна.*

1.12 *Карт хүлээн авагч өөрийн салбар, нэгжид байршуулж, системд холбогдсон, картаар идэвхжиж гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгч нь ПОБ төхөөрөмж байна.*

1.13 *Монголбанкнаас тодорхойлсон шаардлагыг хангасан, ₮ картын лого бүхий, дотоодод болон олон улсад төлбөрт ашиглагдах карт нь Үндэсний төлбөрийн карт (цаашид “₮ карт” гэх) байна.*

- 1.14 “₮ карт”-ын оноосон нэр нь “Төгрөг карт” байх бөгөөд олон улсад ашиглах нэр нь “₮ card” байна.
- 1.15 Олон улсын төлбөрийн картын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагатай хамтран гаргасан, тухайн байгууллагын карт хүлээн авах сүлжээнд ашиглах боломжтой ₮ карт нь Хосолсон-брэнд¹ ₮ карт байна.
- 1.16 Карт гаргагчийг бусдаас ялгах зорилгоор олон улсын төлбөрийн картын үйл ажиллагаа эрхлэгч байгууллага, эсхүл Монголбанкнаас олгосон картын дугаарын эхний 6-10 орныг илэрхийлэх тоон дараалал нь БИИН дугаар байна.
- 1.17 Чип уншуулах үйлдэл нь картын чипийг цахим мэдээ үүсгэгч төхөөрөмжид уншуулан картын гүйлгээ үүсгэх үйлдэл байна.

Тайлбар: Төлбөрийн картын Contact EMV chip гүйлгээ хийх.

- 1.18 Зайнаас унших үйлдэл нь картын чип болон бусад хэрэгслийг цахим мэдээ үүсгэгчид зайнаас уншуулан картын гүйлгээ үүсгэх үйлдэл байна.

Тайлбар: Төлбөрийн картын Contactless EMV chip гүйлгээ хийх. Картыг зайнаас уншуулах гүйлгээнд зөвхөн биет картыг уншуулах үйлдлээр хязгаарлагдахгүй, ApplePay гэх мэт гар утас болох бусад цахим төхөөрөмж дэх EMV стандартын чипийг зайнаас уншуулан гүйлгээ үүсгэх хамаарна.

- 1.19 Карт, картын мэдээлэл ашиглаж цахим мэдээ үүсгэгчийн тусламжтайгаар мөнгөн хөрөнгө шилжүүлэх, төлбөр төлөх, худалдан авалт хийх, дансны үлдэгдэл шалгах, бэлэн мөнгөний орлого, зарлага хийх, ПИН код өөрчлөх, баримт авах зэрэг үйлдэл нь картын гүйлгээ байна.
- 1.20 Төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний төлбөр, татвар, торгууль, хураамжийн төлбөр нь төрийн үйлчилгээний төлбөр байна.
- 1.21 Орон сууцны ус, цахилгаан, дулааныг ханган нийлүүлэх байгууллага, СӨХ, конторын төлбөр нь орон сууцны хэрэглээний төлбөр байна.
- 1.22 Картын мэдээллийг токен буюу 16-19 орон бүхий тусгай кодоор орлуулах, тухайн токеныг картын мэдээллээр эргүүлэн солих нь токенжуулах үйлдэл байна.

Тайлбар: Төлбөрийн картын мэдээлэл алдагдаж, залилангийн гүйлгээ гарахаас сэргийлж, төлбөрийн картын мэдээллийг нэг удаагийн тоон цуваагаар орлуулах, орлуулсан мэдээллээр гүйлгээ үүсгэх үйл ажиллагааг токенжуулах гэж тодорхойлсон.

- 1.23 Төлбөрийн картын мэдээллийг токенжуулан, ПОС дээр биет бус төлбөрийн картаар төлбөр тооцоо хийх боломжийг олгож байгаа программ хангамжийг хариуцан ажиллуулж байгаа этгээд нь цахим хэтэвч байна.

Тайлбар: Хэд хэдэн картын токенжуулсан мэдээллийг хадгалж, түүгээрээ төлбөрийн картын гүйлгээ үүсгэх боломжтой ухаалаг гар утасны аппликейшн, программ хангамжийг цахим хэтэвч гэж тодорхойлсон.

¹ Dual brand

1.24 Цахим мэдээ үүсгэгч ашиглан мөнгөн хөрөнгө шилжүүлэх, хүлээн авах, төлбөр, зээл төлөх, худалдан авалт хийх, бэлэн мөнгөний орлого, зарлага хийх гэх мэт үйл ажиллагаа нь санхүүгийн гүйлгээ байна.

1.25 Дансны үлдэгдэл шалгах, гүйлгээний хуулга авах, үйлчилгээний эрх сунгах, хаах, нууц үг, түүнтэй адилтгах мэдээллийг солих гэх мэт энэ журмын 1.24-д зааснаас бусад үйл ажиллагааг цахим мэдээ үүсгэгч ашиглан гүйцэтгэх нь санхүүгийн бус гүйлгээ байна.

ХОЁР. ХҮСЭЛТ ГАРГАГЧИД ТАВИХ ШААРДЛАГА

Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч

2.1 Хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 12 дугаар зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1 Хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.9-т заасан шууд бус оролцогч байх тохиолдолд төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий нэг банкныг өөрийн төлбөр тооцооны төлөөлөгчөөр сонгосон;

Тайлбар: Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь Монголбанк дээр данс байршуулах эрхгүй, банкнаас бусад этгээд байх тохиолдолд RTGS системд өөрийн settlement-ийг гүйцэтгэхийн тулд заавал энэ журмын 1.4.4-д дурдсан төлбөр тооцооны төлөөлөгчтэй байх ёстой. Ийм төрлийн төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийг Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд шууд бус оролцогч гэж тодорхойлсон байгаа бөгөөд шууд бус оролцогч нь өөрийн төлбөр тооцооны төлөөлөгчийг чөлөөтэй сонгох эрхтэй.

2.1.2 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь клирингийн, эсхүл төлбөр тооцооны системийн оролцогч болохоос өмнө тухайн системийн оператортай техникийн хамтарсан туршилт хийж, хоёр талаас баталгаажуулсан;

Тайлбар: Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төв, Худалдаа хөгжлийн банкны картын клирингтэй техникийн туршилт хийж, туршилтын дүгнэлтэд хоёр талаас гарын үсэг зурж баталгаажуулсны дараа тухайн клирингийн системийн оролцогч болох нөхцөл бүрдэнэ.

2.1.3 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь QR код ашиглан гүйлгээ дамжуулах, хүлээн авахдаа Монголбанкнаас баталсан QR кодын цахим мэдээний бүтэц, зааврыг мөрдөж ажилладаг байх;

2.1.4 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу хэрэглэгчийг таньж мэдэх үйл ажиллагааг тодорхой тусгасан дотоод журам, заавар, хяналтын тогтолцоог бий болгосон;

Тайлбар: Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5.2.1-т заасны дагуу хэрэглэгчтэй санхүүгийн харилцаа үүсгэхийн өмнө түүний иргэний үнэмлэх, эсхүл гадаад паспортыг хуулбарлан авах ёстой бөгөөд энэ үйл ажиллагааг тусгасан дотоод журам, заавар боловсруулж, хянах тогтолцоог бүрдүүлсэн байна.

2.1.5 Гадаад болон дотоод хүчин зүйлээс шалтгаалж төлбөрийн үйлчилгээ тасалдах, осол, гэмтэл гарах үед үйл ажиллагааны найдвартай, тасралтгүй байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөтэй;

Тайлбар: Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь системийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангах үүднээс тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөтэй байх ба уг төлөвлөгөөнд гадаад болон дотоод хүчин зүйлээс шалтгаалсан аливаа эрсдэл, осол, гэмтэл гарсан үед нэн чухал үйл ажиллагааг цаг алдалгүй авах арга хэмжээнүүдийг тодорхой тусгасан байна.

2.1.6 Хэрэглэгч, мерчантын мөнгөн хөрөнгийг найдвартай хадгалах, хамгаалах, гүйлгээний нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангахуйц энэ журмын 2.3-т заасан шаардлагыг хангасан мэдээллийн технологийн дэд бүтэцтэй;

2.1.7 Хэрэглэгчийн данснаас зарлагын гүйлгээ хийх бүрд тухайн гүйлгээний мэдээллийг үйлчилгээний төлбөргүйгээр мэдэгдэж байх боломжийг бүрдүүлсэн;

Тайлбар: Энэ гүйлгээний мэдээллийг цахим шуудан, ухаалаг утсан дахь банкны аппликейшнээс мэдэгдэл (notification) өгөх зэрэг зардал багатай сувгаар хүргэж болно. Мессеж гэх мэт зардалтай сувгаар мэдээлэл хүргэж байгаа тохиолдолд шимтгэл, хураамж авч болно. Гэхдээ шимтгэл, хураамж авдаггүй, үнэгүй суваг дор хаяж нэг байх шаардлагатай. Энд интернэт, мобайл банкны үйлчилгээ, салбараас мэдээлэл авах зэрэг үйлдлийг үнэгүй суваг гэж тооцохгүй бөгөөд үнэгүй суваг нь заавал хэрэглэгчид мэдээллийг хүргэдэг байх ёстой. Энэхүү зарлагын гүйлгээний мэдэгдлийг хэрэглэгчийн хүсэлтээр зогсоож болно.

2.1.8 Хэрэглэгчийн хийсэн аливаа гүйлгээний түүх, гүйлгээний үе шат бүрийн талаарх мэдээллийг гаргах боломж бүхий системтэй байх;

Тайлбар: Монголбанк болон бусад эрх бүхий байгууллагаас хийж байгаа хяналт, шалгалтын үед Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн систем нь гүйлгээ тус бүрийн дэлгэрэнгүй мэдээлэл, гүйлгээ үүсэх, боловсруулах, системд дамжуулах, амжилттай болох гэх мэт үйлдлийн дарааллыг үзүүлэх боломжтой байна.

2.1.9 Төлбөрийн үйлчилгээтэй холбоотойгоор хэрэглэгч, мерчант болон бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс гаргасан гомдол, санал, маргаантай гүйлгээг цаг тухайд нь хүлээн авч шийдвэрлэх, тэдгээрт лавлагаа мэдээлэл өгөх үйл ажиллагааны талаар тусгасан дотоод журам, заавартай байх;

Тайлбар: Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон аливаа гомдол маргаан гарсан тохиолдолд түүнийг цаг тухайд нь шийдвэрлэх, хариу мэдээлэл өгөх арга замыг тусгасан дүрэм, журам, заавар боловсруулсан байх шаардлагатай.

2.1.10 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосоноос үүдэн төлбөрийн үйлчилгээг зогсоох үед хэрэглэгч, мерчантын авлагыг барагдуулахтай холбоотой авах арга хэмжээний талаар тусгасан журамтай байх;

2.1.11 Хүсэлт гаргагч нь хэрэглэгчтэй байгуулах гэрээнд дараах зүйлсийг тусгана:

2.1.11.1 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн мэдээллийг нууцлах, хадгалах, ашиглах тухай;

2.1.11.2 Хэрэглэгч нь ПИН код буюу гүйлгээг баталгаажуулахад ашиглагдах, зөвхөн тухайн хэрэглэгч мэдэж байх тоо, үсэг, тэмдэгтийн дараалал, түүнтэй адилтгах бусад мэдээллийг нууцлах, түүнийг хаяж үрэгдүүлсэн, гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид нэн даруй мэдэгдэх тухай;

2.1.11.3 Хэрэглэгч нь өөрийн данснаас түүний зөвшөөрөлгүй хийгдсэн аливаа ишлжүүлэг болон бүртгэлийн алдаа, зөрчил дутагдлыг илрүүлсэн тохиолдолд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид нэн даруй мэдэгдэх тухай;

2.1.11.4 Хэрэглэгчийг таньж баталгаажуулах арга, хэрэгсэл болон баталгаажуулсан гэж үзэх нөхцөл;

2.1.11.5 Хэрэглэгч тухайн гүйлгээг илгээхийг зөвшөөрсөн, баталгаажуулсан гэж үзэх нөхцөл;

Тайлбар: Хэрэглэгч нь интернэт, мобайл банк, картаар төлбөр гүйцэтгэх зэрэг цахим сувгаар гүйлгээ хийх үед тухайн гүйлгээг баталгаажуулах гүйлгээний нууц үг, биометрик зэрэг нь төлбөрийн даалгаврыг орлох тухай зохицуулалтыг хэрэглэгчтэй байгуулах гэрээнд заавал тусгана.

2.1.11.6 Хэрэглэгч гомдол, маргаан үүсгэх нөхцөл, шийдвэрлэх арга зам, хугацаа;

Тайлбар: Журмын 2.1.9-д заасан зохицуулалтыг хэрэглэгчид мэдэгдэх зорилгоор заавал гэрээнд тусгана.

2.1.11.7 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос үүдэн төлбөрийн үйлчилгээг зогсоох үед хэрэглэгчийн авлагыг барагдуулахтай холбоотой авах арга хэмжээ, эрх, үүрэг.

2.1.12 Хүсэлт гаргагч нь мерчанттай байгуулах гэрээнд дараах зүйлсийг тусгана:

2.1.12.1 Монголбанкны зөвшөөрөлтэй төлбөрийн хэрэгслийг бараа, ажил, үйлчилгээний төлбөрт хүлээн авах тухай;

2.1.12.2 Төрийн үйлчилгээний төлбөр, орон сууцны хэрэглээний төлбөр төлөхөөс бусад картын гүйлгээ хийх тохиолдолд мерчант нь карт эзэмшигчээс шимтгэл авахгүй байх тухай;

Тайлбар: Энэ журмын 1.20-д заасан төрийн үйлчилгээний болон 1.21-д заасан ус, цахилгаан, дулаан, СӨХ, конторын төлбөр төлж буй тохиолдолд карт эзэмшигчээс үйлчилгээний шимтгэл авч болно, харин бусад картын гүйлгээнээс үйлчилгээний шимтгэл авахгүй байна. Мерчант нь энэхүү гүйлгээний төлбөрийг банк дахь өөрийн дансанд хүлээн авч болно.

2.1.12.3 Мерчант нь Монгол Улсын нутаг дэвсгэрт төлбөр хүлээн авах тухай;

Тайлбар: ПОС гэх мэт төлбөрийн хэрэгсэл хүлээн авах төхөөрөмж нь тухайн мерчанттай байгуулсан гэрээнд заасан хаяг байршлаас өөр газарт ашиглаж болохгүй. Хүргэлтийн болон хөдөлгөөнт үйлчилгээний хувьд төхөөрөмжийг ашиглах хот, аймаг гэх мэт үйлчилгээний хүрээг тодорхойлсон нутаг дэвсгэрийн нэг нэгжийг гэрээнд зааж өгнө. Үйлчилгээ үзүүлэх хаяг байршил, нутаг дэвсгэр өөрчлөгдөх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулах тухай гэрээнд заах нь зүйтэй.

2.1.12.4 Мерчантаас гомдол, маргаан үүсгэх нөхцөл, шийдвэрлэх арга зам, хугацаа;

2.1.12.5 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосоноос үүдэн төлбөрийн үйлчилгээг зогсоох үед мерчантын авлагыг барагдуулахтай холбоотой авах арга хэмжээ, эрх, үүрэг.

Тайлбар: Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд Мерчантын мөнгөн хөрөнгийг буцаан олгох эсэх, хэд хоногийн дотор буцаан олгох, зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд Мерчантын гэрээг цуцалж, мөнгөн хөрөнгийг тэр дор нь буцаан олгох тухай зохицуулалтыг Мерчанттай байгуулах гэрээнд заавал зааж, тусгасан байна.

2.1.13 Хүсэлт гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байх;

2.1.14 Хүсэлт гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өрийн үлдэгдэлгүй, шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй байх;

Тайлбар: Зээлийн мэдээллийн санд бүртгэгдсэн хугацаа хэтэрсэн өр, татварын өр, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй гэдгээ нотлох сүүлийн 3 сарын дотор баталгаажуулсан баримт бичиг бүрдүүлэх шаардлагатай.

2.1.15 Монголбанкнаас тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бүрдүүлсэн байх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгө нь гуравдагч этгээдийн шаардлагаас ангид, тухайн этгээдийн санхүүгийн тайлан, татвар төлөлтийн тайлангаар батлагдсан хууль ёсны үйл ажиллагааны орлого байна.

Тайлбар: Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл хүсэгчийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь зээлийн эх үүсвэрээс бүрдээгүй, мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг зөрчөөгүй, гэмт хэргийн болон хууль бус эх үүсвэрээр бүрдүүлээгүй байх шаардлагатай. Энэ шаардлагыг нотлохдоо Улсын бүртгэлийн ерөнхий газар дахь тухайн байгууллагын түүхчилсэн лавлагаатай тулгаж шалгана. Зөвшөөрлийн шаардлага хангах зорилгоор өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлсэн тохиолдолд тухайн хөрөнгө оруулалтын эцсийн өмчлөгч нь тодорхой байх ёстой. Мөн өөрийн хөрөнгө нэмэгдүүлснийг нотлох төлбөрийн даалгавар, гүйлгээний баримт байх шаардлагатай.

Систем ажиллуулах хүсэлт гаргагч

2.2 *Хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:*

2.2.1 *Санхүүгийн мэдээний олон улсын ISO20022, эсхүл ISO8583, мэдээллийн технологийн нууцлал, аюулгүй байдлын ISO27001 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн;*

Тайлбар: Аливаа клирингийн систем ажиллуулах зөвшөөрөл хүсэгчийн санхүүгийн гүйлгээний мессеж нь ISO20022 эсхүл ISO8583 стандартын дагуу бүтэцтэй байх ёстой.

2.2.2 *Энэ журмын 2.3-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хөндлөнгийн аудитаар баталгаажуулсан;*

2.2.3 *Алдаатай, эсхүл нэр, данс зөрсөн гүйлгээ дамжихгүй байх нөхцөлийг хангаж, үүссэн маргааныг шийдвэрлэх тогтолцоотой;*

Тайлбар: Клирингийн систем нь гүйлгээг илгээхийн өмнө хүлээн авагч санхүүгийн байгууллагаас тухай гүйлгээний мэдээлэл нь үнэн зөв болохыг тодруулж, нэр данс гэх мэт мэдээлэл таарч байгаа эсэхийг заавал шалгадаг байх ёстой.

2.2.4 *Монголбанкны Банксүлжээ системийн үйл ажиллагаа хариуцсан нэгжтэй техникийн туршилт хийж, хоёр талаас баталгаажуулсан;*

Тайлбар: Клирингийн систем дэх гүйлгээний эцсийн settlement-ийг заавал Банксүлжээ (RTGS) систем дээр гүйцэтгэнэ. Клирингийн систем нь зөвшөөрөл авахын өмнө энэ settlement-ийг гүйцэтгэх зорилгоор RTGS системд холбогдож, техникийн туршилтыг гүйцэтгэж, туршилтын дүгнэлтэд хоёр талаас гарын үсэг зурж баталгаажуулсан байх ёстой.

2.2.5 *Хүсэлт гаргагч нь төлбөр тооцооны эрсдэлээс сэргийлэх зорилгоор Монголбанкны шаардлагын дагуу оролцогчийн үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг тухайн оролцогчийн төлбөр тооцооны данс дахь мөнгөн хөрөнгийн боломжит дүнгээс илүүгүй байхаар хязгаарлах техник технологийн боломжийг бүрдүүлсэн;*

Тайлбар: Клирингийн систем нь өөрийн системд оролцож байгаа банк, санхүүгийн байгууллагын гүйлгээний settlement-ийг RTGS системд саадгүй хийх нөхцөлийг хангаж ажиллана. Ингэхдээ оролцогч бүрийн Монголбанк дахь дансанд тухайн settlement-ийн хийх зорилгоор нөөц байршуулна. Оролцогч нь энэ нөөцийг settlement-ийн бус зорилгоор ашиглах боломжгүй байна. Оролцогчийн тухайн өдрийн гүйлгээний settlement-ийн зарлагын дүн нь RTGS системд байршуулсан нөөцөөс хэтэрсэн тохиолдолд клирингийн систем нь автоматаар тухайн оролцогчийн илгээх гүйлгээ буюу гарах урсгалыг зогсоох техникийн боломжтой байх шаардлагатай.

2.2.6 *Системийн дүрэмтэй байх бөгөөд дүрэмд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 23 дугаар зүйлд зааснаас гадна дараах зүйлсийг тусгаж, Монголбанканд хянуулсан байна:*

Тайлбар: Клирингийн систем ажиллуулах байгууллага нь системийн дүрэм буюу тухайн системд оролцох банк, санхүүгийн байгууллага (оролцогч) хэрхэн ажиллах, ямар гүйлгээ

дамжуулах, үүнийг клирингийн систем хэрхэн дамжуулах тухай дэлгэрэнгүй зохицуулсан баримт бичгийг Монголбанканд бүртгүүлсэн байх ёстой. Энэ системийн дүрэмд хамгийн багадаа дараах шаардлага, зохицуулалтыг заавал тусгасан байна.

2.2.6.1 Оролцогчид тавих шаардлага, мэдээллийн технологи болон бусад техникийн шаардлага;

2.2.6.2 Оролцогчийг системд бүртгэх, хязгаарлах буюу түр хугацаагаар идэвхгүй болгох, бүртгэлээс хасах үйл ажиллагаа;

Тайлбар: Оролцогчийн буруутай үйл ажиллагаанаас хамааран тухайн оролцогчийн гүйлгээ илгээх, хүлээн авах эрхийг хязгаарлах, зогсоох, оролцогчийг системээс хасах зохицуулалтыг системийн дүрэмд тодорхой зааж оруулсан байх шаардлагатай. Монголбанкнаас оролцогчийн төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тохиолдолд тухайн оролцогчийн гүйлгээг зогсоох, системээс хасах зохицуулалтыг мөн дүрэмд заасан байна.

2.2.6.3 Гүйлгээ дамжуулах, баталгаажуулах, үр дүнгийн тооцоолол хийх, үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг Монголбанканд дамжуулах хуваарь, зарчим, буцаан дуудах, гүйлгээг эцсийн, үл буцаагдах гэж үзэх нөхцөл;

2.2.6.4 Оролцогч төлбөр түргэн гүйцэтгэх чадваргүй болсны улмаас системд учруулах эрсдэлийг хязгаарлах, удирдах арга хэмжээ;

2.2.6.5 Тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах тухай (системд өөрчлөлт, шинэчлэлт хийх, төлөвлөгөөт зогсолт болон гэнэтийн саатал гарсан үед авах арга хэмжээний талаар дэлгэрэнгүй тусгасан байх);

2.2.6.6 Маргаан шийдвэрлэх зарчим, хугацаа;

2.2.6.7 Үйлчилгээний хөлс, шимтгэл, хураамжийн хэмжээ, түүнийг тооцох, суутгах зарчим.

Тайлбар: Клирингийн систем ажиллуулж буй этгээд нь оролцогчоос авах нэг удаагийн болон тогтмол хугацаатай хураамж, системээр дамжих гүйлгээ тутмаас авах шимтгэлийн хэмжээ, эдгээрийн хэзээ, хэрхэн суутгаж авах зарчмыг системийн дүрэмд дэлгэрэнгүй тусгасан байна.

2.2.7 Хүсэлт гаргагч нь системийн дүрмийг боловсруулахдаа оролцогчдын эрх тэгш байдлыг хангах, ижил нөхцөлөөр үйлчилгээ үзүүлэх зарчмыг баримталдаг байх;

2.2.8 Хүсэлт гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авилга, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байх;

2.2.9 Хүсэлт гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өрийн үлдэгдэлгүй, шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй байх.

Тайлбар: Зээлийн мэдээллийн санд бүртгэгдсэн хугацаа хэтэрсэн өр, татварын өр, шүүхийн шүүдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй гэдгээ нотлох сүүлийн 3 сарын дотор баталгаажуулсан баримт, бичиг бүрдүүлэх шаардлагатай.

Хүсэлт гаргагчийн мэдээллийн технологи, тасралтгүй ажиллагаанд тавих шаардлага

2.3 *Хүсэлт гаргагч нь мэдээллийн технологи, тасралтгүй ажиллагаанд дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:*

2.3.1 *Дотоод сүлжээ, вэбсайт, сервер, бусад тоног төхөөрөмж рүү гаднаас халдах боломжгүй байх нөхцөлийг бүрдүүлж, байгууллагын мэдээллийн системийг аливаа сээжиг бүхий, эсхүл зөвшөөрөгдөөгүй хандалтаас хамгаалах галт хана суурилуулсан байх бөгөөд энэ нь интернэт болон бусад сүлжээгээр дамжин байгууллагын мэдээллийн системд хандах эрсдэлийг авч үзсэн байх;*

2.3.2 *Хэрэглэгчийн болон гүйлгээний мэдээлэлд хандаж байгаа бүх хандалтыг хянаж, бүртгэлжүүлэх тогтолцоог бий болгосон байх;*

Тайлбар: Банк, санхүүгийн байгууллага дээрх хэрэглэгчийн хувийн мэдээлэлд хандах ажилтныг тогтоож, ямар мэдээлэлд хэрхэн хандах эрхийг зохицуулсан байна. Хандалт хийх бүрт лог файлыг хадгалах шаардлагатай.

2.3.3 *Гүйлгээ хийх, нууц мэдээлэл дамжих үед тухайн мэдээллийг дамжуулах эхний цэгээс хүлээн авах эцсийн цэг хүртэл өндөр нууцлалтай шифрлэх, гүйлгээний бүх үе шатанд (шифрлэх, мэдээлэл дамжуулах, хадгалах) хэрэглэгчийн гүйлгээ үүсгэх, дансанд хандахад ашиглагдах нууц үг, түүнтэй адилтгах бусад мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангасан байх;*

2.3.4 *Мэдээллийн технологийн үндсэн систем, техник, тоног төхөөрөмж (цаашид үндсэн төв гэх) гэмтэх, аливаа саатал гарах үед үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлэн хэвийн үргэлжлүүлэх хүчин чадал бүхий нөөц систем, мэдээллийн сан, дэд бүтэцтэй байх (цаашид нөөц төв гэх);*

Тайлбар: Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 4.1.2-т заасны дагуу Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч болон систем ажиллуулах хүсэлт гаргагч нь гүйлгээний тасралтгүй найдвартай ажиллагааг хангах зорилгоор өөрийн үндсэн систем, техник, програм хангамжийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах, тус системд гэмтэл саатал гарсан тохиолдолд нөөц төв рүү шилжин ажиллах нөхцлийг бүрдүүлсэн байх шаардлагатай.

2.3.5 *Мэдээллийн технологийн нууцлал аюулгүй байдлын талаар авч хэрэгжүүлэх бодлого, журам, заавартай байх бөгөөд үүнд мэдээллийг шифрлэх, шифрлэсэн нууц мэдээллийг тайлж уншихтай холбогдсон түлхүүр, алгоритмыг зөвшөөрөлгүй этгээд олж мэдэхээс хэрхэн сэргийлэх, үндсэн төв болон нөөц төвийн сервер, серверийн өрөөний аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар тусгасан байх;*

2.3.6 *Нөөц төвийг үндсэн систем байршиж буй газар нутагт тохиолдож болох эрсдэлийг харгалзан үзэж, ижил эрсдэл зэрэг үүсэхээргүй зайд байршуулсан байх;*

2.3.7 *Үндсэн төв болон нөөц төвийг шууд холбосон байх;*

2.3.8 Хүсэлт гаргагчийн үндсэн төвийг операторын үндсэн төвтэй үндсэн ба нөөц шугамаар шууд холбосон байх;

Тайлбар: Энэ нь төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагчийн үндсэн шугамд аливаа гэмтэл, саатал гарсан тохиолдолд нөөц шугам руу шилжин ажилладаг байхаар хоёр шугамыг хамтад холбосон байх шаардлагатай.

2.3.9 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч, операторын нөөц төвүүдийг шууд холбосон байх;

Тайлбар: Онцгой байдлын үед төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч этгээд болон клирингийн системийн операторын мэдээллийн технологийн үндсэн төв дэх сервер, техник тоног төхөөрөмж, программ хангамжид саатал гарч үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон тохиолдолд ашиглах зорилгоор шууд сүлжээний холболтоор нөөц төвүүдийг хооронд нь холбосон байх ёстой.

2.3.10 Үндсэн болон нөөц систем байршиж буй барилга байгууламжид агаарын чийгшил тохируулагч систем, гал унтраах систем, аваар осол мэдрэгч төхөөрөмж, тог баригч байршуулсан байхаас гадна цахилгааны нэмэлт эх үүсвэртэй холбосон байх;

2.3.11 Энэ журмын 2.3.10-т заасан цахилгааны нэмэлт эх үүсвэрээр үйл ажиллагааг хамгийн багадаа 24 цаг явуулах боломжтой байх;

2.3.12 Үндсэн болон нөөц системд хандах эрх бүхий ажилтнуудын тухайн системд хандан хийж болох үйлдэл, хандалтын эрхийн хязгаарлалт, хандалт бүрийг тухайн ажилтан тус бүрээр тодорхойлж, баримтжуулдаг байх;

2.4 Монголбанкны ажиллуулж байгаа клирингийн систем, Монголбанкнаас систем ажиллуулах зөвшөөрөл авсан этгээд, тэдгээрийн оролцогчдын гэнэтийн саатлын хугацаа нэг сард тухайн системийн нийт ажиллах цагийн 0.1 хувиас илүүгүй, төлөвлөгөөт зогсолтын хугацаа нэг сард 4 цагаас илүүгүй байна.

Тайлбар: Төлөвлөгөөт зогсолт гэж засвар, үйлчилгээ хийх зорилгоор оператор, оролцогчдод урьдчилан мэдэгдэж системийн үйл ажиллагааг хэсэгчлэн болон бүрэн зогсоохыг хэлнэ. Оролцогчийн төлөвлөгөөт зогсолт нь нэг сард 4 цагаас илүү байж болохгүй тул оролцогч нь аливаа системийн шинэчлэл, засвар үйлчилгээг энэ хугацаанд багтаан гүйцэтгэх ёстой.

2.5 Зайлигүй шаардлагаар үндсэн болон нөөц төвийн үйл ажиллагааг зэрэг хамарсан программ, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх тохиолдолд энэ журмын 2.4-т заасан төлөвлөгөөт зогсолтын хугацааг Монголбанканд албан бичгээр мэдэгдэж тохиролцсоны үндсэн дээр сунгаж болно.

Тайлбар: Банкны суурь бүртгэлийн системийг бүтэн шинэчлэх, төлбөрийн картын системийг бүтэн солих гэх мэт системийн хэмжээний томоохон өөрчлөлт хийх тохиолдолд оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь Монголбанканд урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авсны үндсэн дээр 4 цагаас илүү хугацаатай төлөвлөгөөт зогсолт хийж болно.

2.6 Төлбөрийн системийн үйл ажиллагаа 2 минутаас дээш хугацаагаар, төлөвлөгөөт бусаар хэсэгчлэн болон бүрэн зогсох нь гэнэтийн саатал байна.

ГУРАВ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИД ТАВИХ НЭМЭЛТ ШААРДЛАГА

Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх хүсэлт гаргагч

3.1 *Төлбөр тооцооны төлөөлөгч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 36.5 - т заасны дагуу дараах шаардлагыг хангасан байна:*

Тайлбар: Банкнаас бусад Монголбанканд данс байршуулах боломжгүй, финтек, ББСБ гэх мэт этгээд нь аливаа клирингийн системд холбогдож гүйлгээ дамжуулах үед тус этгээдийн төлбөр тооцоо буюу settlement-ийг Монголбанк дахь өөрийн дансаараа дамжуулан гүйцэтгэх зөвшөөрөл бүхий банкныг төлбөр тооцооны төлөөлөгч гэнэ.

3.1.1 *Монголбанкнаас олгосон банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх;*

3.1.2 *Сүүлийн хоёр жилийн хугацаанд Банксүлжээ систем дэх клирингийн системийн үр дүнгийн төлбөр тооцоог цаг тухайд нь найдвартай гүйцэтгэж, заавал байлгах нөөцийн шаардлагыг бүрэн хангасан байх;*

Тайлбар: Төлбөр тооцооны төлөөлөгчийн зөвшөөрөл авах банк нь Монголбанк дахь өөрийн харилцах дансандаа хангалттай мөнгөн хөрөнгөтэй, сүүлийн хоёр жилийн хугацаанд өөрийн болон төлөөлж байгаа оролцогчийн settlement-ийг нэг ч удаа саатуулж байгаагүй байх шаардлагатай.

3.1.3 *Шууд бус оролцогчийн төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэх зорилгоор Монголбанк дахь өөрийн харилцах дансны мөнгөн хөрөнгөөс тодорхой дүнг нөөцлөх буюу тусгаарлахыг зөвшөөрсөн.*

Карт гаргах хүсэлт гаргагч

3.2 *Хүсэлт гаргагч нь энэ журмын 2.1 болон 2.3-2.5-т зааснаас гадна дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:*

3.2.1 *Карт нь олон улсын EMV стандартын шаардлагыг хангасан байх;*

Тайлбар: Биет төлбөрийн карт нь заавал олон улсын EMV стандартын чиптэй байх шаардлагатай.

3.2.2 *Карт нь карт хүлээн авах зөвшөөрөл бүхий бүх оролцогчийн ПОС төхөөрөмж дээр уншигдаж худалдан авалт, буцаалт, төрийн үйлчилгээний төлбөр, орон сууцны хэрэглээний төлбөрийн гүйлгээ хийх боломжтой байх;*

Тайлбар: Аливаа карт гаргагч этгээдийн гаргаж байгаа төлбөрийн карт нь бусад бүх карт хүлээн авагчийн ПОС төхөөрөмж дээр уншигдаж байх ёстой ба дор хаяж дээр дурдсан гүйлгээг хийх боломжтой байна. Төлбөрийн карт нь ямар нэг шалтгаанаар аль нэг ПОС төхөөрөмж дээр уншигдахгүй тохиргоотой байж болохгүй.

3.2.3 *Карт нь карт хүлээн авах зөвшөөрөл бүхий бүх оролцогчийн АТМ, ПОБ төхөөрөмж дээр уншигдаж бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ, дансны үлдэгдэл шалгах гүйлгээ хийх боломжтой байх;*

Тайлбар: Аливаа карт гаргагч этгээдийн гаргаж байгаа төлбөрийн карт нь бусад бүх карт хүлээн авагчийн АТМ, ПОБ төхөөрөмж дээр уншигдаж байх ёстой ба дор хаяж дээр дурдсан гүйлгээг хийх боломжтой байна. Төлбөрийн карт нь ямар нэг шалтгаанаар аль нэг АТМ, ПОБ төхөөрөмж дээр уншигдахгүй тохиргоотой байж болохгүй.

3.2.4 Цахим худалдаа хийх буюу карт ашиглан интернэтээр бараа, ажил үйлчилгээний төлбөр төлөх, худалдан авалт хийх боломжтой байх;

3.2.5 Карт гаргагч нь хэрэглэгчийн зан төлөв, хэрэглээнд суурилсан сээжигтэй гүйлгээг илрүүлэх чадамж бүхий программ хангамжтай байх;

3.2.6 Ухаалаг гар утас болон бусад цахим төхөөрөмжид картын мэдээллийг суулгаж гүйлгээ үүсгэх тохиолдолд тухайн мэдээллийг олон улсын стандартын дагуу токенжуулдаг байх;

Тайлбар: Төлбөрийн картыг цахим төхөөрөмжид суулгаж биет бус гүйлгээ хийх оролцогч нь олон улсын стандартын TSP (Token Service Provider) системтэй, эсхүл TSP системд холбогдсон, картын биет бус гүйлгээ бүрт TSP системээс олгосон картын дугаарыг орлох тоон цувааг ашигладаг байна.

3.2.7 ₮ картыг Монголбанкнаас баталсан загвар, шаардлагын дагуу гаргах;

Тайлбар: Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А-322 дугаар тушаалаар баталсан “Үндэсний ₮ төлбөрийн картын загвар”-ыг баримтлан ₮ карт гаргана.

3.2.8 ₮ картын загвар дээрх холограмыг зөвхөн Монголбанк хэвлүүлж, карт гаргагч, картын бэлдэгч нийлүүлэгч нарт хүргүүлнэ.

Карт хүлээн авах хүсэлт гаргагч

3.3 Хүсэлт гаргагч нь энэ журмын 2.1 болон 2.3-2.5-т зааснаас гадна дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:

3.3.1 ПОС төхөөрөмжөөр карт хүлээн авах тохиолдолд олон улсын “EMV (contact level 1, level 2 type approval) стандарт”-ын сертификат бүхий ПОС төхөөрөмжтэй байх;

Тайлбар: Хэрэв ПОС төхөөрөмж нь зайнаас унших буюу contactless гүйлгээ дэмждэг бол EMV contactless level 1, level 2 type approval-тай байна.

3.3.2 ПОС төхөөрөмжөөр карт хүлээн авах тохиолдолд карт гаргах зөвшөөрөлтэй бүх оролцогчийн гаргасан картыг өөрийн ПОС төхөөрөмж дээр хүлээн авч, худалдан авалт болон буцаалтын гүйлгээ хийх боломжтой байхаас гадна бүх төрлийн баталгаажуулалттай картын гүйлгээг хүлээн авах чадамжтай байх;

Тайлбар: Төлбөрийн карт хүлээн авагч нь бүх төлбөрийн карт гаргагчийн гаргасан төлбөрийн картыг уншиж, төлбөрт хүлээн авах боломжтой байх шаардлагатай. Аливаа оролцогчийн, эсхүл аль нэг брэндийн картыг хүлээн авахгүй тохиргоо хийж болохгүй.

3.3.3 АТМ, ПОБ төхөөрөмжөөр карт хүлээн авах тохиолдолд карт гаргах зөвшөөрөлтэй бүх оролцогчийн гаргасан биет картыг өөрийн АТМ, ПОБ төхөөрөмж дээр хүлээн авч, бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ, дансны үлдэгдэл шалгах гүйлгээ хийх боломжтой байх;

Тайлбар: Төлбөрийн карт хүлээн авагч нь бүх төлбөрийн карт гаргагчийн гаргасан төлбөрийн картыг уншиж, төлбөрт хүлээн авах боломжтой байх шаардлагатай. Аливаа оролцогчийн, эсвэл аль нэг брэндийн картыг хүлээн авахгүй тохиргоо хийж болохгүй.

3.3.4 Цахим худалдааны гүйлгээг хүлээн авах тохиолдолд карт гаргах зөвшөөрөлтэй бүх оролцогчийн картыг хүлээн авч, цахим худалдааны гүйлгээ хийх боломжтой байх;

Тайлбар: Төлбөрийн карт хүлээн авагч нь бүх төлбөрийн карт гаргагчийн гаргасан төлбөрийн картыг уншиж, төлбөрт хүлээн авах боломжтой байх шаардлагатай. Аливаа оролцогчийн, эсхүл аль нэг брэндийн картыг хүлээн авахгүй тохиргоо хийж болохгүй.

3.3.5 АТМ болон хэрэглэгч өөртөө үйлчилж, гүйлгээ үүсгэх боломж бүхий цахим мэдээ үүсгэгч төхөөрөмж байршиж байгаа газарт хэрэглэгчийн нүүр царай харагдахуйц хяналтын камер суурилуулсан байх;

3.3.6 Картын систем нь ухаалаг гар утас болон бусад цахим төхөөрөмжид суурилсан, олон улсын стандартын дагуу токеноор орлуулсан картын мэдээлэл бүхий гүйлгээг хүлээн авч, дамжуулах боломжтой байх.

Тайлбар: Журмын 3.2.6-д дурдсан токенжуулсан гүйлгээг хүлээн авах боломжтой байх ёстой.

Цахим мөнгө гаргах хүсэлт гаргагч

3.4 Хүсэлт гаргагч нь энэ журмын 2.1 болон 2.3-2.5-т зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

3.4.1 Банкнаас бусад цахим мөнгө гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 2,500,000,000 (хоёр тэрбум таван зуун сая) төгрөгөөс доошгүй байх;

3.4.2 Цахим мөнгө нь мөнгөн хөрөнгөөр баталгаажиж, мөнгөн дүн нь цахим хэлбэрээр хадгалагддаг байх;

Тайлбар: Зөвшөөрөлтэй этгээд нь зах зээлд гаргасан цахим мөнгөнөөс багагүй хэмжээний мөнгөн хөрөнгийг тухайн цахим мөнгөний баталгаа болгон банкн дахь өөрийн дансанд байршуулсан байх шаардлагатай.

3.4.3 Цахим мөнгөний үйлчилгээ нь бусдаас ялгарах өөрийн гэсэн оноосон нэртэй байх;

3.4.4 Цахим мөнгө нь мөнгөн хөрөнгөнд, мөнгөн хөрөнгө нь цахим мөнгөнд чөлөөтэй хөрвөдөг байх;

3.4.5 Цахим мөнгө гаргах, түүнийг мөнгөн хөрөнгөнд хөрвүүлэх, гүйлгээ хийх болон төлбөр төлөх үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журамтай байх;

3.4.6 Хэрэглэгчийн болон дансны бүрэн мэдээллийг агуулсан, нарийвчилж хөтлөх боломж бүхий бүртгэлийн системтэй байх бөгөөд тус систем нь:

3.4.6.1 Цахим мөнгөний хөдөлгөөнийг хянах;

3.4.6.2 Нийт цахим мөнгө болон хэрэглэгчийн данс дахь цахим мөнгөний тоо хэмжээг хянах;

3.4.6.3 Хэрэглэгчийн зөвшөөрсөн хэмжээнээс илүү гүйлгээ хийх, данс андуурсан зэрэг санамсаргүй үйлдэл, луйврын болон сэжигтэй гүйлгээг илрүүлэх, гүйлгээг зогсоох, буцаах, түүнээс үүсэх маргааныг шийдвэрлэх боломжтой байх.

3.4.7 Хүсэлт гаргагч нь өөрийн гаргах цахим мөнгөнд баталгаа болгож мөнгөн хөрөнгө байршуулах зорилгоор баталгааны данс нээсэн байх;

3.4.8 Цахим мөнгө гаргагч нь банк бол баталгааны дансыг Монголбанканд, банкнаас бусад хуулийн этгээд бол Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг сүүлийн дөрвөн улирлын турш тогтмол хангаж ажилласан банканд байршуулах;

3.4.9 Хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 35.4-т заасан нөхцөлийг хангасан байх;

Тайлбар: Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 35.4-т заасны дагуу цахим мөнгө нь зээлийн эх үүсвэр болж болохгүй бөгөөд цахим мөнгөний баталгаа болох мөнгөн хөрөнгийг бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

3.4.10 Бүртгэлгүй хэрэглэгч нь цахим мөнгө гаргагчтай гэрээ байгуулахгүйгээр цахим мөнгөний үйлчилгээ авах иргэн, хуулийн этгээд байх.

Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх хүсэлт гаргагч

3.5 Хүсэлт гаргагч нь энэ журмын 2.1 болон 2.3-2.5-т зааснаас гадна дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:

Тайлбар: Өөр дээрээ хэрэглэгчийн мөнгөн хөрөнгийг байршуулахгүйгээр, банкны болон цахим мөнгөний дансандаа зайнаас, цахимаар хандаж төлбөр тооцоо хийх боломжийг хэрэглэгчид олгож байгаа, мэдээллийн технологид суурилсан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх байгууллага нь энэ зөвшөөрлийг авна.

3.5.1 Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх этгээд нь “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль”-ийн 5.1.5-т заасан харилцах данс нээх эрх бүхий этгээдээс бусад этгээд байх тохиолдолд хэрэглэгчийн мөнгөн хөрөнгийг өөр дээрээ байршуулахгүй байх;

Тайлбар: Хуулийн дагуу зөвхөн банк болон цахим мөнгө гаргах үйлчилгээ үзүүлж байгаа этгээд нь хэрэглэгчид мөнгөн хадгаламжийн эсхүл харилцах данс нээж, мөнгөн хөрөнгийг өөр дээрээ байршуулах эрхтэй. Иймд мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх этгээд гэх

мэт бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэх байгууллага нь хэрэглэгчийн мөнгөн хөрөнгийг өөр дээрээ болон банк дахь өөрийн дансандаа байршуулж болохгүй.

3.5.2 Энэ журмын 3.5.1-т заасан этгээд нь банк, цахим мөнгө гаргагч дээрх хэрэглэгчийн дансанд хандаж мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх бол тухайн хэрэглэгчээс бусад этгээд дансанд хандах, гүйлгээ үүсгэх боломжгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байх;

Тайлбар: Хэрэглэгчийн дансанд хандах, гүйлгээ үүсгэх нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангасан, үйлчилгээ үзүүлэхийн өмнө тухайн хэрэглэгч мөн гэдгийг баталгаатай таньдаг байх шаардлагатай.

3.5.3 Дараах үйл ажиллагааг тусгасан гэрээ болон бусад баримт бичигтэй байна:

3.5.3.1 Банк, цахим мөнгө гаргагч, хэрэглэгч, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг, тэдгээрийн хооронд үүсэх маргаан шийдвэрлэх зохицуулалт;

3.5.3.2 Банк, цахим мөнгө гаргагчтай холбогдон ажиллах мэдээллийн технологийн шийдэл, ажиллах зарчим, мэдээллийн нууцлал, хадгалалт, дамжуулалт, боловсруулалтын талаарх дэлгэрэнгүй зохицуулалт;

3.5.3.3 Хэрэглэгч тухайн үйлчилгээг авахыг зөвшөөрөх нөхцөл.

Аутсорсингийн үйлчилгээ авах хүсэлт гаргагч

3.6 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь гүйлгээ дамжуулах, хүлээн авах, боловсруулах, гүйлгээний нууцлал, аюулгүй байдал, мэдээллийн сангийн үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх буюу аутсорсингийн үйлчилгээ авах тохиолдолд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамтран ажиллана.

Тайлбар: Аливаа төлбөрийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь энэ үйлчилгээний тодорхой нэг хэсгийг бусад гуравдагч байгууллагаар гүйцэтгүүлэх, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхдээ мэдээллийн технологийн, хүний нөөцийн болон бусад тусламж дэмжлэг авах гэж байгаа бол Монголбанкнаас Аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрлийг түрүүлж авсан байх шаардлагатай.

Гэхдээ, энд цахилгаан, дулаан хангамж, интернэтийн үйлчилгээ авах, программ хангамж худалдаж авсан вендор байгууллагаас үзүүлэх байнгын засвар үйлчилгээ зэрэг төлбөрийн үйлчилгээнд шууд нөлөөлөхгүй үйл ажиллагааг аутсорсингийн үйлчилгээ гэж тооцохгүй, эдгээр төрлийн үйлчилгээнд зөвшөөрөл авах шаардлагагүй.

3.7 Оператор нь аутсорсингийн үйлчилгээ авах тохиолдолд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамтран ажиллана.

3.8 Монголбанк нь тухайн этгээдэд аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэхдээ дараах нөхцөлийг гэрээнд тусгасан байхыг шаардана:

3.8.1 Хүсэлт гаргагч нь аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээдэд энэ журамд заасан мэдээллийн аюулгүй байдлын холбогдох шаардлагыг тавьж, хэрэгжилтийг

хянадаг байх, шаардлагатай мэдээлэлд цаг алдалгүй хандах боломжтой байх тухай;

3.8.2 Хүсэлт гаргагч болон хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, төлбөрийн үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай байдал алдагдахгүй байх тухай;

3.8.3 Хүсэлт гаргагчийн удирдлагын үүрэг хариуцлага шилжихгүй байх тухай;

3.8.4 Хүсэлт гаргагчийн хэрэглэгчийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлага, тэдгээрийн хоорондын харилцаанд нөлөөлөхгүй байх тухай;

3.9 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, оператор нь аутсорсингийн үйлчилгээ авснаар энэ журмын нөхцөл, шаардлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

Тайлбар: Төлбөрийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд нь өөрийн үйлчилгээг хэсэгчлэн болон бүтнээр нь аутсорс хийж гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх нь хууль, журмын хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй, бүх эрсдэл, хариуцлагыг тухайн төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч өөрөө хариуцах бөгөөд хариуцлага нь гуравдагч этгээд рүү ямар нэгэн байдлаар шилжихгүй.

3.10 Хүсэлт гаргагч нь аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээдийн найдвартай ажиллагаа, мэдээллийн технологийн нууцлал, аюулгүй байдал болон аутсорсингоор дамжуулан үзүүлсэн төлбөрийн үйлчилгээний хариуцлагыг хүлээнэ.

Гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч

3.11 Гэрээт төлөөлөгч нь төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн системийг ашиглан хэрэглэгчийн шилжүүлгийг хийх, төлбөр төлөх, хэрэглэгчээс бэлэн мөнгө хүлээн авах, бэлэн мөнгө олгох зэрэг үйл ажиллагааг эрхэлж болно.

Тайлбар: Гэрээт төлөөлөгч гэж төлбөрийн үйлчилгээн дэх agent буюу төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн нэрийн өмнөөс үйлчилгээ үзүүлэх эрхтэй иргэн, хуулийн этгээдийг хэлнэ.

3.12 Гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл авсан этгээд нь үйл ажиллагааг эхэлснээс хойш ажлын 5 өдрийн дотор тухайн гэрээт төлөөлөгчийг Монголбанканд бүртгүүлнэ.

3.13 Гэрээт төлөөлөгчийн мэдээллийн технологийн нууцлал, аюулгүй байдал болон гэрээт төлөөлөгчөөр дамжуулан үзүүлсэн төлбөрийн үйлчилгээний хариуцлагыг төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч хариуцна.

ДӨРӨВ.ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1 Хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 11.1.12 болон 11.3.12-т заасан шаардлагын дагуу энэ журмын хавсралт 2-т заасан баримт бичгийг, хавсралт 1-т заасан өргөдлийн хамт Монголбанкны төлбөрийн систем хариуцсан нэгжид албан бичгээр өгнө.

4.2 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээд бусад төрлийн төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл хүсэх бол энэ журмын хавсралт 2-т заасан (

зөвхөн шинээр эрхлэх гэж байгаа үйл ажиллагаатай холбогдон үүсэх өөрчлөлтийг тусгасан) баримт бичгийг, хавсралт 1-т заасан өргөдлийн хамт Монголбанкны төлбөрийн систем хариуцсан нэгжид албан бичгээр өгнө.

- 4.3 *Аутсорсингийн үйлчилгээ авах хүсэлт гаргагч нь энэ журмын хавсралт 3-т заасан баримт бичгийг, хавсралт 1-т заасан өргөдлийн хамт Монголбанкны төлбөрийн систем хариуцсан нэгжид албан бичгээр өгнө.*
- 4.4 *Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргагч банк нь энэ журмын хавсралт 4-т заасан баримт бичгийг, хавсралт 1-т заасан өргөдлийн хамт Монголбанкны төлбөрийн систем хариуцсан нэгжид албан бичгээр өгнө.*
- 4.5 *Гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч нь энэ журмын хавсралт 5-д заасан баримт бичгийг, хавсралт 1-т заасан өргөдлийн хамт Монголбанкны төлбөрийн систем хариуцсан нэгжид албан бичгээр өгнө.*
- 4.6 *Хүсэлт гаргагч нь энэ журмын 4.1-4.5-д заасан баримт бичгийг өгөхдөө Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон энэ журамд заасан шаардлагыг хэрхэн хангаж байгаа тухай тайлбарыг хавсаргана.*

Тайлбар: Хууль журмын шаардлага бүрийг ямар баримт бичгийн хэд дэх заалтаар хэрхэн хангасан байгааг тайлбарлаж хүснэгтээр ирүүлнэ. Шаардлагатай бол Монголбанкны Төлбөр тооцооны газраас энэхүү шаардлагуудыг жагсаасан, загвар хүснэгт авч болно.

- 4.7 *Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 33.1-т заасны дагуу хүсэлт гаргагч нь материал өгөхөөс өмнө зөвшөөрлийн материал хүлээж авах, хянах үйлчилгээний хураамжийг төлнө.*

Тайлбар: Төлбөрийн үйлчилгээ авахаар хүсэлт гаргаж байгаа этгээд нь тухайн зөвшөөрлийн материалыг Монголбанканд шалгуулахтай холбоотой, зөвшөөрлийн материал хүлээж авах хураамж болох 500 мянган төгрөгийг Монголбанканд урьдчилан тушааж, төлбөрийн баримтыг зөвшөөрлийн материалын хамт ирүүлнэ. Энэхүү зөвшөөрлийн материалын хураамжийг зөвшөөрөл олгосон эсэхээс үл хамааран буцаан олгохгүй.

- 4.8 *Зөвшөөрөл авах хүсэлтийг судлах, зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, татгалзахтай холбоотой харилцааг Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 11.4, 11.5, 11.6, 15.1, 15.2, 15.3, 15.5, 15.6, 15.7, 33.1-д, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 2, 11-т, 5.3 дугаар зүйлийн 3-т заасны дагуу зохицуулна.*

Тайлбар: ҮТСТ хуулийн 11.4-т заасны дагуу зөвшөөрөл авах хүсэлтийн материалыг шалгах явцад баримт бичиг дэх мэдээлэл дутуу, тодорхой бус тохиолдолд Монголбанк нь зөвшөөрлийн хүсэлт гаргагчид энэ тухай мэдэгдэж, материалд өөрчлөлт оруулан засуулж болно. Зөвшөөрлийн материалыг засах шаардлагатай тухай мэдэгдсэн тохиолдолд ҮТСТ хуулийн 11.5-т заасны дагуу зөвшөөрлийн хүсэлт гаргагч нь зөвхөн шаардсан нэмэлт, өөрчлөлтийг 60 хоногийн дотор бэлдэж Монголбанканд ирүүлнэ. Зөвшөөрлийн хүсэлт гаргагч нь шаардсан нэмэлт, өөрчлөлтийг 60 хоногийн дотор амжиж ирүүлээгүй тохиолдолд тухайн зөвшөөрлийг олгохоос татгалзах үндэслэл болно.

ҮТСТ хуулийн 11.6-д заасны дагуу Монголбанк нь зөвшөөрлийн хүсэлтийг бүртгэж авснаас эхлэн ажлын 10 өдрийн хугацаанд тухайн хүсэлтийн бүрэн байгаа эсэхийг шалгана. Энэ хугацаанд хүсэлтийн материал дахь агуулгыг шалгахгүй.

ҮТСТ хуулийн 15.2-т заасны дагуу зөвшөөрлийн хүсэлтийн материал бүрэн ирснээс хойш Монголбанк нь 60 хоногийн дотор материалын агуулгыг шалгана. Агуулга шалгах явцад хуулийн 11.4-т заасны дагуу засвар орсон тохиолдолд тухайн засварыг Монголбанканд ирүүлсэн өдрөөс эхлэн энэхүү 60 хоногийг дахин тоолно.

ҮТСТ хуулийн 15.2-т заасны дагуу зөвшөөрөл сунгах хүсэлт гаргагч нь тухайн зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг бүгдийг нь дахин бүрдүүлж Монголбанканд ирүүлэх бөгөөд зөвшөөрөл сунгах нь зөвшөөрөл шинээр авахтай ижил байна.

Зөвшөөрлийн материал шаардлага хангаагүй байгаа шалтгаанаар зөвшөөрөл олгох үйл явц ҮТСТ хуулийн 15.3-т заасан 180 хоног дотор багтахааргүй болсон тохиолдолд Монголбанк нь тухайн зөвшөөрлийг олгохоос татгалзана.

ҮТСТ хуулийн 15.5-д заасны дагуу зөвшөөрөл эзэмшигч нь тухайн зөвшөөрлийн хугацаа дуусахаас 180-аас багагүй хоногийн өмнө зөвшөөрөл сунгах хүсэлтээ Монголбанканд ирүүлсэн байх ёстой. Энэ хугацаанд амжиж зөвшөөрөл сунгах хүсэлт ирүүлээгүй тохиолдолд тухай зөвшөөрлийг сунгахаас татгалзаж, зөвшөөрлийн хугацаа дууссанаар хүчингүйд тооцно.

ҮТСТ хуулийн 15.7-д заасны дагуу зөвшөөрлийн материал нь шаардлага хангахгүй байгаа тохиолдолд Монголбанк нь тухайн зөвшөөрлийг олгох, сунгахаас татгалзаж болно.

Магадлан шалгах 60 хоног, зөвшөөрөл олгох 180 хоногийн хугацаа дууссан, энгийн зөвшөөрөл хүсэгч нь тухайн зөвшөөрлийн шаардлагыг хангаж байгаа тохиолдолд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3.5-д заасны дагуу тухайн зөвшөөрлийг олгосонд тооцно. Тусгай зөвшөөрлийн хувьд энэхүү зохицуулалт нь хамаархгүй.

ҮТСТ хуулийн 33.1-т заасны дагуу тухайн зөвшөөрөл гарах нь тодорхой болсон тохиолдолд Монголбанкны зөвшөөрлийн хураамжийн ерөнхий нөхцөлд заасан хураамжийг зөвшөөрлийн хүсэлт гаргагч нь Монголбанкны 6112001 дугаар дансанд төлж, төлбөрийн баримтыг Монголбанканд ирүүлнэ.

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2.11-т заасны дагуу Монголбанк нь аливаа тусгай зөвшөөрлийг олгохоос татгалзсан тохиолдолд тухайн зөвшөөрлийн материалыг 6 сарын турш дахин хүлээж авахгүй.

4.9 *Монголбанкны хянан шалгагч нь зөвшөөрлийн материал шалгах явцад тухайн хүсэлт гаргагчийн үйл ажиллагаа явуулах барилга байгууламж, систем, мэдээллийн санд нэвтэрч тоног төхөөрөмж, программ хангамж, баримт бичиг, үйл ажиллагаатай танилцаж болно.*

4.10 *Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, түдгэлзүүлсэн зөвшөөрлийг сэргээхтэй холбоотой харилцааг Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.*

4.11 *Зөвшөөрлийг сэргээхдээ түдгэлзүүлсэн хугацааг нөхөн олгохгүй.*

Тайлбар: Хугацаатай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд Монголбанк нь тухайн зөвшөөрлийг сэргээхдээ алдагдсан хугацааг нөхөн олгохгүй бөгөөд зөвшөөрлийн хугацаанд өөрчлөлт оруулахгүй.

ТАВ.ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 5.1 *Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч хоорондын бага дүнтэй бодит цагийн гүйлгээ, багцын гүйлгээ болон картын гүйлгээг Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийн ажиллуулж байгаа Автомат клиринг хаус систем, Төлбөрийн картын клирингийн систем, эсхүл Монголбанкны зөвшөөрөл бүхий клирингийн системээр дамжуулах бөгөөд төлбөр тооцоог шууд оролцогчийн Монголбанкнаа дахь дансаар гүйцэтгэнэ.*

Тайлбар: Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч (цахим мөнгө гаргагч г.м.) байгууллага нь хэрэглэгчийн гүйлгээг бусад банк, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч руу илгээхдээ заавал АСН+, төлбөрийн картын клирингийн системээр дамжуулна. Өөрөөр хэлбэл төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь банк дээр байршуулсан өөрийн дансаар дамжуулан хэрэглэгчийн төлбөрийг шууд гүйцэтгэж болохгүй, заавал клирингийн системээр дамжуулна. Мерчант байгууллагын settlement, төлбөр тооцооны төлөөлөгч банкны үйл ажиллагаа, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын өөрийн гүйлгээ нь энэ заалтад хамаарахгүй.

- 5.2 *Монгол Улсын Сангийн яам, Монголын үнэт цаасны клирингийн төв, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, банк, банкны эрх хүлээн авагчаас бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.9-д заасны дагуу Банксүлжээ системд шууд бусаар оролцох буюу төлбөр тооцооны төлөөлөгчийн Монголбанкнаа дахь дансаар дамжуулан төлбөр тооцоог гүйцэтгэнэ.*

Тайлбар: Монголбанк дээр данс байршуулах эрхгүй төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь заавал төлбөр тооцооны төлөөлөгч банктай байх шаардлагатай бөгөөд settlement-ийг Монголбанк дахь төлбөр тооцооны төлөөлөгчийн дансаар дамжуулан гүйцэтгэнэ.

- 5.3 *Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгч (энэ журмын 3.4.10-т зааснаас бусад), клирингийн төв, гэрээт төлөөлөгч, аутсорсингийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөр тооцооны төлөөлөгч, мерчанттай хамтран ажиллахдаа талуудын эрх үүргийг тодорхой тусгасан гэрээ байгуулна.*

- 5.4 *Хэрэглэгч, мерчанттай гэрээ байгуулахаас өмнө “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-д заасны дагуу түүнийг таниж мэдэх үйл ажиллагааг гүйцэтгэнэ.*

- 5.5 *Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн оролцож байгаа системийн дүрэм, стандартыг дагаж мөрдөнө.*

Тайлбар: Энэ журмын 2.2.7-т зааснаар төлбөр тооцооны болон клирингийн систем нь заавал үйл ажиллагааны дүрэмтэй байна. Тухайн клирингийн системд оролцож, гүйлгээ дамжуулж байгаа этгээд нь түүний үйл ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллана. Жишээ нь: АСН системийн оролцогч нь Монголбанкнаас баталсан Автомат клиринг хаус системийн дүрмийг мөрдөнө.

- 5.6 *Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний нөхцөл, түүний ил тод байдлыг хангах, хэрэглэгчийг хамгаалах талаар Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлнэ.*

Тайлбар: ҮТСТ хуулийн 26.1-д заасны дагуу төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчтэй байгуулах гэрээг түүнд танилцуулж, дэлгэрэнгүй тайлбарлаж ойлгуулна. Жишээ нь: Хэрэглэгчтэй гэрээ байгуулах ажилтан нь данснаас зарлагын гүйлгээ гаргах

нөхцөл, маргаан шийдвэрлэх зарчим, шимтгэл хураамжийн хэмжээ зэрэг гэрээний зохицуулалтыг тухайн хэрэглэгчид чухалчлан хэлж ойлгуулах үүрэгтэй.

ҮТСТ хуулийн 26.2.8-д заасны дагуу алдаатай гүйлгээг залруулах, хэрэглэгчээс мөнгөн хөрөнгийг буцаан авах зохицуулалтыг хэрэглэгчтэй байгуулах гэрээнд заавал тусгах бөгөөд үүнийг тухайн хэрэглэгчид тайлбарлаж ойлгуулсан байх шаардлагатай. Хэрэглэгчийн зөвшөөрөлгүй данснаас хасалт хийх, алдаатай гүйлгээний мэдээллийг хуулганаас хасах зэрэг гэрээгээр зохицуулаагүй залруулга хийхийг хориглоно.

5.7 *Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь хуульд зааснаас бусад тохиолдолд хэрэглэгч, мерчантаас төлбөр тооцоо хийх зорилгоор байршуулсан мөнгөн хөрөнгийг тухайн этгээдийн анхны шаардлагаар гаргаж өгнө.*

5.8 *Хэрэглэгчийн интернэт болон мобайл төхөөрөмж ашиглан эхлүүлсэн мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлгийг гүйцэтгэхээс өмнө тухайн хэрэглэгчид гүйлгээ хүлээн авагчийн мэдээллийг харуулж, баталгаажуулна.*

5.9 *Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх, системийн дүрэмд өөрөөр зааснаас бусад тохиолдолд:*

5.9.1 *Хэрэглэгчийн төлбөрийг саатуулж үл болно;*

5.9.2 *Гүйлгээг хүлээн авсан даруй төлбөр хүлээн авагчийн дансанд тусгана;*

Тайлбар: Бодит цагийн горимоор гүйлгээ дамжуулдаг клирингийн системийн оролцогч нь хэрэглэгчийн гүйлгээг хүлээн авсан мөчид мөнгөн хөрөнгийг тухайн хэрэглэгчийн дансанд тусгана. Жишээ нь: АСН системээр бодит цагийн гүйлгээ хүлээн авсан даруйд хэрэглэгчийн дансанд бичилтийг хийж, тухайн мөнгөн хөрөнгийг ашиглах боломжтой болгох ёстой.

5.9.3 *Хэрэглэгчийн хувийн болон гүйлгээний мэдээллийг түүний зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд дамжуулахгүй, хууль тогтоомжид зааснаас бусад зориулалтаар ашиглахгүй.*

5.10 *Хэрэглэгчээс гаргасан гомдол, маргаан, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн тухай бүртгэл, хэрэглэгчийн гүйлгээний цахим мэдээг тухайн гүйлгээ үүссэн өдрөөс эхлэн хамгийн багадаа таваас доошгүй жил тус тус хадгална.*

5.11 *Гэрээ болон хуульд өөрөөр заагаагүй бол хэрэглэгчийн зөвшөөрөлгүйгээр данснаас зарлагын гүйлгээ хийхийг хориглоно.*

5.12 *Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, түүний гэрээт төлөөлөгч нь тухайн гүйлгээг эрх олгогдоогүй этгээд үүсгэсэн, хууль бус гэж сэжиглэх үндэслэлтэй болон энэ журмын 2.1.11.2, 2.1.11.3-д заасан нөхцөл байдал үүссэн даруй гүйлгээний эрхийг тухайн нөхцөл байдал арилах хүртэлх хугацаагаар хааж, цаашид гарч болох эрсдэлээс хамгаална.*

5.13 *Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн системд гэмтэл, саатал үүсэж, эсхүл төлөвлөгөөт зогсолтын улмаас хэрэглэгчийн төлбөр саатах тохиолдолд нөхцөл байдлын талаар тухай бүр хэрэглэгчдэд мэдэгдэж, зогсолт, саатлыг хурдан хугацаанд засаж, үйл ажиллагааг хэвийн байдалд оруулах арга хэмжээг авна.*

Тайлбар: Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь саатлын талаар хэрэглэгчид мэдэгдэхдээ дор хаяж өөрийн веб хуудас болон facebook дээр мэдээлэл байршуулна, бүх хэрэглэгчид цахим шуудан хүргүүлнэ.

5.14 *Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний нөхцөл, хөлс, шимтгэл, хураамжид өөрчлөлт оруулах бол хэрэглэгчид урьдчилан мэдэгдэнэ.*

5.15 *Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч хэрэглэгчийн хийж байгаа санхүүгийн болон санхүүгийн бус аливаа гүйлгээнээс шимтгэл авах тохиолдолд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 26.4-т заасны дагуу гүйлгээ хийгдэхээс өмнө шимтгэлийн дүн, тайлбарыг тодорхой харуулна.*

5.16 *Хэрэглэгчид олгох нууц үг, бусад нууцлах шаардлагатай мэдээллийг битүүмжилсэн байдлаар хүлээлгэн өгөх, эсхүл хэрэглэгчээс бусад этгээд олж мэдэх боломжгүй байх нөхцөлийг хангасан байна.*

5.17 *Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгч тухайн төлбөрийн хэрэгсэл, түүнтэй холбоотой нууц үг, гүйлгээ үүсгэхэд ашиглагдах бусад мэдээллийг гээж үрэгдүүлэх, бусдад алдах тохиолдолд гарч болох эрсдэлийн талаар болон хууран мэхлэх, залилангийн шинжтэй гүйлгээнээс хэрхэн сэргийлэх талаар хэрэглэгчийг мэдээллээр хангана.*

5.18 *Системд саатал, гэмтэл гарах үед арга хэмжээ авах зорилгоор мэдээллийн технологи болон төлбөр тооцоо хариуцсан албан тушаалтан, тэдгээрийг орлох албан тушаалтны нэрсийн жагсаалт, холбоо барих утас болон бусад мэдээллийг төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, оператор нь солилцох бөгөөд нэрсийн жагсаалтад өөрчлөлт орох бүрт харилцан мэдэгдэнэ.*

5.19 *Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг жилд нэг болон түүнээс дээш удаа турших бөгөөд ингэхдээ төлбөрийн үйлчилгээний мэдээллийн технологийн үйл ажиллагааг хамгийн багадаа 12 цагийн турш нөөц төв рүү бүрэн шилжүүлнэ.*

Тайлбар: Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч мэдээллийн технологийн нөөц төвийн найдвартай байдлыг жилд нэгээс доошгүй удаа туршиж, шалгана. Туршихдаа өөрийн бүх төлбөрийн үйлчилгээг нөөц төвийн тоног төхөөрөмж рүү шилжүүлж, 12 цагийн турш төлбөр тооцооны бүх үйл ажиллагааг зөвхөн нөөц төвөөс явуулна.

5.20 *Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн систем, бүтэц зохион байгуулалтад дараах өөрчлөлт хийхээс 30 хоногийн өмнө тухайн өөрчлөлттэй холбоотой саналаа Монголбанканд танилцуулж, шаардлагатай тохиолдолд дүгнэлт гаргуулна:*

5.20.1 *Зөвшөөрөлтэй эрхэлж байгаа үйл ажиллагааны хүрээнд шинэ технологи дээр суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхийн өмнө тухайн шинэчлэлттэй холбоотой үүссэн, анх зөвшөөрөл авахад бүрдүүлсэн баримт бичиг, гэрээ хэлцэл, техник технологи, программ хангамжид өөрчлөлт орох;*

Тайлбар: Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн шинэ технологи нэвтрүүлэхийн өмнө Монголбанканд мэдэгдэх шаардлагатай. Жишээ: Төлбөрийн карт гаргадаг этгээд ApplePay гэх мэт картын гүйлгээний шинэ суваг нэвтрүүлэхдээ урьдчилан мэдэгдсэн байна, харин картын загвар өөрчлөх (rebranding), байгууллагын нэр дээр карт гаргах гэх мэт өөрчлөлтийг мэдэгдэх шаардлагагүй.

5.20.2 Гүйцэтгэх удирдлага өөрчлөгдөх;

5.20.3 Аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд болон төлбөр тооцооны төлөөлөгч өөрчлөгдөх, клирингийн болон төлбөр тооцооны системд холбогдох;

5.20.4 Карт гаргагч нь зөвшөөрөлд заагдаагүй брэндийн карт шинээр гаргах;

Тайлбар: Жишээ нь: ₮ карт гаргадаг этгээд шинээр олон улсын VISA, MasterCard гэх мэт брэндийн карт гаргахаар төлөвлөж байвал Монголбанканд энэ тухай 30 хоногийн өмнө мэдэгдэж дүгнэлт авсан байх шаардлагатай. Дүгнэлт гарснаар тухайн этгээдийн зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтанд энэ тухай бүртгэнэ.

5.20.5 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийн нэр, үйлчилгээний нэр, албан ёсны хаяг өөрчлөгдөхөөс өмнө Монголбанканд энэ тухайгаа хавсралт 8-д заасан маягтын дагуу мэдэгдэх бөгөөд Монголбанк дүгнэлт гаргасны дараа нэрийг солино.

5.21 Аутсорсингийн үйлчилгээ авснаар төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, операторын дотоод хяналтын үйл ажиллагаа хязгаарлагдахгүй байна.

Тайлбар: Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн дотоод хяналт болох нягтлан бодох, эрсдэлийн үнэлгээ, удирдлага, аливаа зөрчлийн хяналт зэрэг үйл ажиллагаанд аутсорсингийн үйлчилгээ авснаар ямар нэгэн хязгаарлалт бий болох ёсгүй.

5.22 Аутсорсингийн үйлчилгээ авснаар төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, операторын энэ журамд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд Монголбанкны тавих хяналт хязгаарлагдахгүй байна.

5.23 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь энэ журмын 2.1 болон 2.3-2.5-т заасан бүх шаардлага, мөн 3.1-3.13-т заасан өөрийн үйл ажиллагаанд хамаарах хэсгийн шаардлагыг зөвшөөрөл эзэмших хугацаандаа тогтмол хангана.

Тайлбар: Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь зөвхөн энэ бүлэгт заасан үүргээс гадна анх зөвшөөрөл авахаар бүрдүүлсэн баримт бичигт заасан шаардлагыг байнга хангаж байх ёстой.

5.24 Энэ журмыг зөрчсөнөөс үүдэн гарсан хохирлыг төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч хариуцна.

Карт гаргах зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлийн нөхцөл

5.25 Карт гаргагч нь энэ журмын 5.1-5.24-т заасан үүргээс гадна дараах үүргийг хүлээнэ:

5.25.1 “₮ карт” гаргах тохиолдолд дотоодын цахим худалдааны эрхийг нээсэн байна;

Тайлбар: ₮ картын цахим худалдаа буюу e-commerce дотоодын гүйлгээний эрхийг анхнаас нь нээсэн байх шаардлагатай. Жишээ нь: ₮ карт эзэмшигч нь эрх нээлгэх, онлайн ПИН код шинээр авах гэх мэт ямар нэгэн нэмэлт үйлдэл хийхгүйгээр шууд e-commerce-ийн худалдан авалт хийх боломжтой.

5.25.2 *Цахим худалдааны ПИН кодоор баталгаажуулсан гүйлгээнээс гарах эрсдэлийг хариуцана;*

Тайлбар: Картын системийн оролцогчдын хооронд хийгдсэн e-commerce-ийн ПИН кодоор баталгаажсан гүйлгээнээс үүсэх маргаан, хохирлыг карт гаргагч хариуцна.

5.25.3 *Цахим худалдааны CVV код, эсхүл токеноор баталгаажуулсан гүйлгээг зөвшөөрнө;*

Тайлбар: Харин картын системийн оролцогчдын хооронд хийгдсэн e-commerce-ийн CVV код болон токен (картын дугаарыг орлох тоон цуваа) - оор баталгаажсан гүйлгээнээс үүсэх маргаан, хохирлыг карт хүлээн авагч хариуцана. Карт гаргагч нь CVV, эсхүл токеноор баталгаажсан e-commerce-ийн гүйлгээ заавал хүлээн зөвшөөрч, гүйцэтгэх үүрэгтэй.

5.25.4 *Өөрийн гаргах бүх чиптэй картын тохиргоог энэ журмын 5.36-д заасны дагуу тохируулна;*

5.25.5 *Картын чип уншуулж ПИН кодоор баталгаажуулсан, эсхүл алдаатай тохируулга хийгдсэнээс үүдэн баталгаажуулалт хийгдээгүй гүйлгээнээс гарах эрсдэлийг хариуцна;*

Тайлбар: Журмын 5.36-т заасны дагуу картын чип уншуулсан гүйлгээг заавал ПИН кодоор баталгаажуулсан байх ёстой бөгөөд ПИН кодоор баталгаажуулсан гүйлгээнээс үүсэх маргаан, хохирлыг карт гаргагч хариуцна. Ямар нэгэн алдаа гарч чип уншуулсан гүйлгээг ПИН кодоор баталгаажуулаагүй тохиолдолд үүсэх маргаан, хохиролыг мөн карт гаргагч хариуцна.

5.25.6 *Чиптэй картыг зайнаас уншуулж, ПИН кодоор баталгаажуулсан гүйлгээнээс гарах эрсдэлийг хариуцна;*

Тайлбар: Картын системийн оролцогчдын хооронд хийгдсэн гүйлгээг ПИН кодоор баталгаажуулсан, эсхүл баталгаажуулах ёстой гүйлгээг алдаа гарган баталгаажуулаагүйгээс үүсэх маргаан, хохиролыг карт гаргагч хариуцна.

5.25.7 *Чип технологид шилжээгүй, соронзон тууз бүхий картын мэдээллийг хуулбарлаж хуурамч карт уншуулснаас үүдэн гарах эрсдэлийг хариуцна;*

5.25.8 *Энэ журмын 5.32-т заасан гүйлгээг QR код үүсгэж хийх үед Монголбанкнаас баталсан QR мессэж бүтэц дэх “төлбөр” ангиллаар, бусад гүйлгээг “худалдан авалт”-аар тус тус ангилж, дамжуулна.*

Тайлбар: QR-аар үүсэх мерчант дээрх төлбөрийн картын гүйлгээнд хэрэглэгчээс шимтгэл авч болохгүй. Зөвхөн QR-аар төрийн үйлчилгээ, СӨХ, Контор, Цахилгааны гэсэн орон сууцны хэрэглээний төлбөр төлөх үед хэрэглэгчээс тогтмол 300 хүртэлх төгрөгийн шимтгэл авахыг зөвшөөрнө. Бусад бүх тохиолдолд дэлгүүр үйлчилгээний байгууллага дээр хийгдэх картын гүйлгээнд хэрэглэгчээс ямар нэгэн нэмэлт шимтгэл авахыг хориглоно.

5.26 *Карт гаргагч нь Монголбанкнаас дүгнэлт авснаар олон улсын картын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагатай хамтран “Хосолсон брэнд ₮ карт” гаргаж болно.*

Тайлбар: Карт гаргагч нь олон улсын сүлжээний VISA, Mastercard, UnionPay гэх мэт картын байгууллагатай хамтран журмын 1.20-т заасан “Хосолсон брэнд ₮ карт”-ыг гаргах гэж

байгаа тохиолдолд эхлээд энэ тухай Монголбанканд урьдчилан мэдэгдэж, дүгнэлт гаргуулсан байх ёстой.

5.27 “Хосолсон брэнд ₮ карт”-д олон улсын картын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагаас олгосон БИН дугаарыг Монголбанканд бүртгүүлснээр ашиглаж болно.

5.28 Монголбанк нь “Хосолсон брэнд ₮ карт”-аар хийсэн гүйлгээнээс нэмэлт шимтгэл авч болно.

Тайлбар: Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төв нь дамжуулсан картын гүйлгээ тус бүрээс 5-50 төгрөгийн шимтгэл авдаг. ₮ картын брэнд, зах зээлийн байр суурийг хадгалах зорилгоор Монголбанк нь VISA, Mastercard гэх мэт олон улсын брэндийн картын гүйлгээнээс нэмэлт шимтгэл авч болно.

Карт хүлээн авах зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлийн нөхцөл

5.29 Бараа, үйлчилгээний төлбөрийг картаар хүлээн авсан тохиолдолд карт хүлээн авагчийн авах гүйлгээний шимтгэлийн дээд хязгаар нь гүйлгээний үнийн дүнгийн 3 хувь байна.

5.30 АТМ төхөөрөмж ашиглан бэлэн мөнгө авах гүйлгээний шимтгэлийн хэмжээг 500 (таван зуун) төгрөгөөс дээшгүй байхаар тогтоох ба шимтгэлийг карт эзэмшигч төлнө.

5.31 ПОБ болон ПОС төхөөрөмж ашиглан 1,000,000 (нэг сая) төгрөг хүртэлх дүнтэй бэлэн мөнгө авахад (cashback) шимтгэлийн хэмжээ нь 500 (таван зуун) төгрөгөөс дээшгүй байх ба шимтгэлийг карт эзэмшигч төлнө.

Тайлбар: Картын 1 сая хүртэл бэлэн мөнгө авах гүйлгээний шимтгэлийн дээд хязгаар 500 төгрөг байна. Харин 1 саяаас дээш бэлэн мөнгө авсан тохиолдолд тухайн карт хүлээн авагч нь өөрөө шимтгэлийн хэмжээг тогтооно.

5.32 Төрийн үйлчилгээний төлбөр, орон сууцны хэрэглээний төлбөрийг картаар хүлээн авсны шимтгэл нь 300 (гурван зуун) төгрөгөөс дээшгүй байх ба шимтгэлийг карт эзэмшигч төлнө.

5.33 Карт хүлээн авагч нь энэ журмын 5.32-д заасан төлбөрийг картаар хүлээн авах үйл ажиллагааг гуравдагч этгээдтэй хамтарч гүйцэтгэх эсэхээс үл хамаарч хэрэглэгчээс илүү шимтгэл авахгүй.

Тайлбар: Жишээ нь: Карт хүлээн авагч нь КИОСК төхөөрөмж ажиллуулж байгаа этгээд гэх мэт гуравдагч этгээдээр дамжуулан төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхдээ картын гүйлгээний шимтгэлийг 300 төгрөгөөс хэтрүүлж болохгүй, гуравдагч этгээд нь хэрэглэгчээс нэмэлт шимтгэл авч болохгүй. Хэрэглэгчээс авсан 300 төгрөгийг карт хүлээн авагч болон гуравдагч этгээд нь харилцан тохиролцож хувааж авна.

5.34 Карт хүлээн авагч нь энэ журмын 5.1-5.24-т заасан үүргээс гадна дараах үүргийг хүлээнэ:

5.34.1 Карт хүлээн авах төхөөрөмжийн тохиргоог энэ журмын 5.36-т заасны дагуу тохируулна;

5.34.2 *Цахим худалдааны CVV кодоор баталгаажуулсан гүйлгээнээс гарах эрсдэлийг хариуцна;*

Тайлбар: Журмын 5.25.3-т заасны дагуу карт гаргагч нь CVV-ээр баталгаажуулсан e-commerce-ийн гүйлгээг заавал төлбөрт хүлээн авах үүрэгтэй. Карт хүлээн авагч нь цахим худалдааны CVV баталгаажуулалт сонгосон тохиолдолд энэ гүйлгээнээс гарах эрсдэлийг хариуцна. Эрсдэл багасгах зорилгоор ПИН кодоор баталгаажуулалт шаардаж болно.

5.34.3 *Чиптэй картыг зайнаас уншуулж 100,000 (нэг зуун мянга) төгрөг болон түүнээс доош дүнтэй ПИН кодоор баталгаажуулаагүй гүйлгээ хийсэн тохиолдолд гарах эрсдэлийг хариуцна;*

5.34.4 *Чиптэй картыг соронзон тууз уншуулж гүйлгээ хийх буюу картын соронзон туузыг цахим мэдээ үүсгэгчид уншуулан картын гүйлгээ хийснээс үүдэн гарах эрсдэлийг хариуцна;*

5.34.5 *Худалдаа, үйлчилгээ эрхэлдэг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагыг мерчантаар элсүүлэн, гэрээ байгуулна;*

5.34.6 *Энэ журмын 5.32-т зааснаас бусад тохиолдолд 5.29-д заасан шимтгэлийг карт эзэмшигч буюу хэрэглэгчээс авахыг хориглоно;*

Тайлбар: Төлбөрийн картын худалдан авалтын (purchase) гүйлгээнд карт хүлээн авагч болон түүнтэй хамтран ажиллаж байгаа гуравдагч этгээд, мерчант нь карт эзэмшигчээс шимтгэл авч болохгүй. Тухайн бараа, ажил, үйлчилгээг хэрэглэгч бэлэн мөнгөөр худалдан авах дүн нь картаар худалдан авахад төлөх дүнтэй ижилхэн байх шаардлагатай.

5.34.7 *ПОС төхөөрөмжийг карт уншуулснаас хойш жаран секундйн дотор автоматаар анхны төлөвт шилжиж, дараагийн картыг хүлээн авахад бэлэн байхаар тохируулна;*

5.34.8 *ПОС төхөөрөмжийн тусламжтайгаар бэлэн мөнгө авах гүйлгээг[2] зөвхөн худалдан авалттай цуг хийнэ;*

5.34.9 *ПОС төхөөрөмжийн тохиргоонд тухайн мерчантын үйл ажиллагааны ангиллын кодыг[3] Монголбанкнаас гаргасан “Мерчантын үйл ажиллагааны ангиллын код”-ын дагуу бүртгэнэ;*

5.34.10 *Энэ журмын 5.32-т заасан гүйлгээг QR код үүсгэж хийх үед Монголбанкнаас баталсан QR мессэж бүтэц дэх “төлбөр” ангиллаар, бусад гүйлгээг “худалдан авалт”-аар тус тус ангилж, дамжуулна.*

Карт гаргагч, хүлээн авагч, цахим хэтэвчийн нийтлэг эрх, үүрэг

5.35 *Картаар хийх дараах төрлийн гүйлгээнд баталгаажуулалт шаардахгүй байж болно:*

5.35.1 *Картын соронзон туузыг уншуулсан 10,000 (арван мянган) төгрөг хүртэлх дүнтэй гүйлгээ;*

5.35.2 *Картын чипийг зайнаас уншуулсан 100,000 (нэг зуун мянган) төгрөг хүртэлх дүнтэй гүйлгээ.*

5.36 *Карт гаргагч, хүлээн авагч нь гүйлгээнд дараах байдлаар баталгаажуулалт шаардана:*

5.36.1 *Картын соронзон туузыг уншуулсан 10,000 (арван мянган) төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээг ПИН кодоор;*

5.36.2 *Цахим худалдааны токенжуулаагүй гүйлгээг ПИН код, эсхүл CVV кодоор;*

5.36.3 *Цахим худалдааны токенжуулсан гүйлгээнд энэ журмын 5.36.2-т заасан баталгаажуулалтыг шаардахгүй*

5.36.4 *Ухаалаг гар утасны тусламжтайгаар, картаар идэвхжиж, гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгч буюу МПОС төхөөрөмжийн гүйлгээг гарын үсгээр;*

5.36.5 *Картын чип уншуулсан гүйлгээг ПИН кодоор;*

5.36.6 *Картын чипийг зайнаас уншуулсан 100,000 (нэг зуун мянган) төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээг ПИН кодоор,*

5.36.7 *Картын чипийг дээд тал нь хорин удаа дараалан зайнаас уншуулж баталгаажуулалтгүй гүйлгээ хийсний дараа чип уншуулж ПИН кодоор.*

Тайлбар: Чиптэй картыг зайнаас буюу contactless байдлаар уншуулсан 100,000 төгрөг хүртэлх дүнтэй гүйлгээг ПИН кодоор баталгаажуулахгүй байж болно. Ингэхдээ баталгаажуулалт хийгдээгүй гүйлгээ бүрийг төлбөрийн картын чип нь тоолох бөгөөд дараалан 20 удаа баталгаажуулалтгүй гүйлгээ хийгдсэний дараа төлбөрийн карт нь 21 дэх гүйлгээг хийхдээ чип (contact) уншуулж ПИН кодоо баталгаажуулах тохиргоотой байна.

5.37 *Карт гаргагч, хүлээн авагч нь шимтгэлийг дараах байдлаар хуваана:*

5.37.1 *Карт хүлээн авагч нь мерчант дээр хийгдсэн гүйлгээний үнийн дүнгийн 0.3 хувиас доошгүй хэмжээтэй шимтгэлийг карт гаргагчид төлнө (Төрийн үйлчилгээ, орон сууцны хэрэглээний төлбөр төлөх гүйлгээнээс бусад);*

5.37.2 *Карт хүлээн авагч нь энэ журмын 5.32-т заасан шимтгэлийн 30 хувиас доошгүй хэмжээтэй шимтгэлийг, эсхүл хамгийн багадаа 30 (гуч) төгрөгийн шимтгэлийг карт гаргагчид төлнө.*

5.38 *Картын мэдээллийг токенжуулахад картын дугаар, эзэмшигчийн нэр, хүчинтэй хугацааг карт гаргагч нь заавал баталгаажуулсан байна.*

Тайлбар: Картын мэдээллийг токенжуулахад картын дугаар, эзэмшигчийн нэр, хүчинтэй хугацааны мэдээллийг цахим хэтэвчээс ирсэн хүсэлтийн дагуу карт гаргагч нь ҮЦГТ рүү илгээж түүнийг токенжүүлэх хүсэлт гаргасан цахим хэтэвч рүү баталгаажуулалт болгон өгнө.

5.39 *Картын токенжуулсан мэдээллийг хадгалах дээд хугацаа нэг жил байна.*

Тайлбар: Карт хүлээн авагч эсхүл төлбөрийн картын хэтэвч ажиллуулж байгаа этгээд нь төлбөрийн картын токенжуулсан мэдээллийг хамгийн дээд тал нь нэг жил ашиглаж болно. Нэг жилийн хугацаа дууссан токеныг устгаж тухайн картыг дахин токенжуулах шаардлагатай.

Цахим мөнгө гаргах зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлийн нөхцөл

5.40 Цахим мөнгө гаргагч нь энэ журмын 5.1-5.24-т зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ:

5.40.1 Хэрэглэгчийн анхны шаардлагаар цахим мөнгө болон төгрөгийг харилцан хөрвүүлнэ;

5.40.2 Хэрэглэгчийн 100,000 (нэг зуун мянга) төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээг ПИН код, эсхүл биометрик нууцлал, түүнтэй адилтгах бусад арга хэрэгслээр баталгаажуулна;

5.40.3 Цахим мөнгө гаргахад хэрэглэгчээс хүлээн авсан мөнгөн хөрөнгийг 100 хувь баталгааны дансанд байршуулах, баталгааны дансан дахь мөнгөн хөрөнгийг эргэлтэд гарсан нийт цахим мөнгөнөөс дутаахгүй байна

Тайлбар: Цахим мөнгө гаргагч нь өөрийн гаргасан цахим мөнгөний баталгаа болгож мөнгөн хөрөнгийг банкны дансанд хөдөлгөөнгүй байршуулсан байна. Нэмэлтээр цахим мөнгө эргэлтэд гарч цахим мөнгөний баталгаа хангалтгүй болохоос сэргийлэх зорилгоор цахим мөнгө гаргагч этгээд нь баталгааны дансанд хангалттай хэмжээний мөнгөн хөрөнгө байршуулсан байх шаардлагатай. Баталгааны дансан дахь мөнгөн хөрөнгийн хэмжээ нь эргэлтэд гарсан цахим мөнгөний хэмжээнээс ямагт их байх шаардлагатай.

5.40.4 Баталгааны данс өөрчлөгдөх бүрт Монголбанканд ажлын 3 хоногт багтаан мэдэгдэнэ;

5.40.5 Баталгааны дансанд зөвхөн цахим мөнгө болон төгрөгийг харилцан хөрвүүлэхтэй холбоотой гүйлгээ болон түүний шимтгэлийн гүйлгээг хийнэ;

5.40.6 Баталгааны дансан дахь мөнгөн хөрөнгийг зээлийн эх үүсвэр, хөрөнгө оруулах зэрэг өөр зорилгоор ашиглах, барьцаа хөрөнгө болгохыг хориглоно;

Тайлбар: Баталгааны дансан дахь мөнгөн хөрөнгө нь тухайн цахим мөнгийг эрсдэлээс хамгаалах зорилготой бөгөөд цахим мөнгийг буцаан мөнгөн хөрөнгөд хөрвүүлэх зорилгоор ашиглана. Баталгааны дансыг бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

5.40.7 Цахим мөнгө гаргагч нь дампуурсан буюу төлбөрийн чадваргүй болсон, эсхүл татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан тохиолдолд баталгааны дансан дахь мөнгөн хөрөнгийг зөвхөн хэрэглэгчийн цахим мөнгийг мөнгөн хөрөнгөд хөрвүүлэх зорилгоор ашиглана;

Тайлбар: Баталгааны дансан дахь төгрөг нь тухай цахим мөнгөнөөс үүсэх эрсдэлийг хаах зорилготой учир, цахим мөнгө гаргагч нь эрсдэлд орсон тохиолдолд баталгааны дансан дахь мөнгөн хөрөнгийг өөр зорилгоор ашиглаж болохгүй, зөвхөн хэрэглэгчийн хохиролыг барагдуулах зорилгоор ашиглана.

5.40.8 *Цахим мөнгө гаргах зөвшөөрөлтэй этгээд нь энэ журмын 3.4-т заасан шаардлагыг тогтмол хангаж ажиллана;*

5.40.9 *Нэг цахим мөнгө нь нэг төгрөгтэй тэнцүү байна;*

Тайлбар: Бутархай цахим мөнгөний хувьд мөн адил хэмжээний төгрөгтэй тэнцэнэ.

5.40.10 *Цахим мөнгөнд хүү тооцохгүй;*

Тайлбар: Цахим мөнгөний данс нь хадгаламж биш, цахим мөнгө нь зээлийн эх үүсвэр байж болохгүй. Ийм цахим мөнгөнд ямар нэгэн хадгаламжийн болон зээлийн хүү тооцож, үлдэгдлийг нэмэгдүүлж, хорогдуулж болохгүй.

5.40.11 *Хэрэглэгчийн нэг удаад хийх зарлагын гүйлгээний дээд хэмжээ нь Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан бага дүнтэй гүйлгээний мөнгөн дүнгийн дээд хязгаартай тэнцүү байна;*

Тайлбар: Бүртгэлтэй цахим мөнгөний хэрэглэгчийн нэг удаад хийх зарлагын гүйлгээний дүн нь Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан бага дүнтэй гүйлгээний дээд хязгаар болох 5,000,000 төгрөгөөр хязгаарлагдана. Энэ хязгаар нь зөвхөн хэрэглэгчийн гүйлгээнд хамаатай бөгөөд цахим мөнгө гаргагчтай хамтран ажиллаж байгаа гэрээт төлөөлөгч, мерчант байгууллагын гүйлгээнд энэ хязгаар хамаарахгүй.

5.40.12 *Нэг хэрэглэгчийн дансан дахь цахим мөнгөний дээд хэмжээ 20,000,000.00 (хорин сая) төгрөгөөс хэтрэхгүй;*

5.40.13 *Бүртгэлгүй хэрэглэгчийн дансан дахь цахим мөнгөний дээд хэмжээ 100,000.00 (нэг зуун мянга) төгрөг байна.*

5.40.14 *Бүртгэлгүй хэрэглэгчийн нэг өдөрт хийх гүйлгээний дээд хязгаар 40,000.00 (дөчин мянга) төгрөг байна.*

Тайлбар: Бүртгэлтэй хэрэглэгчийн хувьд энэ гүйлгээний хязгаар хамаарахгүй бөгөөд тухайн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу гүйлгээ хийгдэнэ. Харин зөвхөн бүртгэлгүй хэрэглэгчийн нэг өдөрт хийх зарлагын гүйлгээний дээд хязгаар нь 40,000.00 төгрөг байна.

Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлийн нөхцөл

5.41 *Төлбөр тооцооны төлөөлөгч нь энэ журмын 5.1-5.24-т зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ:*

5.41.1 *Монголбанк болон шууд бус оролцогчтой төлбөр тооцоо гүйцэтгэх гэрээ байгуулна;*

Тайлбар: Монголбанк дээр данс байршуулах эрхгүй буюу ҮТСТ хуулийн 5.1.9-д заасан шууд бус оролцогч нь заавал төлбөр тооцооны төлөөлөгчөөр дамжуулан өөрийн гүйлгээний settlement-ийг гүйцэтгүүлэхдээ гэрээ байгуулсан байх шаардлагатай ба уг гэрээ нь зөвхөн төлбөр тооцоо гүйцэтгэх зорилготой байна.

5.41.2 *Шууд бус оролцогчийн төлбөр тооцоог өөрийн Монголбанкна дахь дансаар гүйцэтгэнэ;*

5.41.3 *Шууд бус оролцогчоос төлбөр тооцооны зорилгоор байршуулсан мөнгөн хөрөнгийг зөвхөн төлбөр тооцоог гүйцэтгэх зорилгоор ашиглана;*

5.41.4 *Төлбөр тооцооны төлөөлөгч нь шууд бус оролцогчийн төлбөр тооцоог найдвартай гүйцэтгэх нөхцөлийг хангаж ажиллана;*

5.41.5 *Шууд бус оролцогч нарт ижил хөлс, шимтгэл, хураамж ногдуулж, үйлчилгээ авах эрх тэгш боломжоор хангана.*

ЗУРГАА.СИСТЕМ АЖИЛЛУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

6.1 *Монголбанкны ажиллуулж байгаа клирингийн болон төлбөр тооцооны системийг хариуцаж байгаа нэгж, Монголбанкнаас систем ажиллуулах зөвшөөрөл авсан этгээд нь дараах үүргийг хүлээнэ:*

6.1.1 *Оператор нь тухайн системийн оролцогч болон Монголбанкт хамтран ажиллах гэрээ байгуулна;*

Тайлбар: Оператор нь өөрийн системд холбогдсон буюу төлбөрийн системийн оролцогч тус бүртэй хамтран ажиллах гэрээг байгуулсан байх шаардлагатай.

6.1.2 *Оператор нь системийн дүрэмд заасны дагуу гүйлгээний боловсруулалт, дамжуулалтыг тасралтгүй хийж, гүйцэтгэх ба гэрээнд заасны дагуу тухайн системийн оролцогчоос үйлчилгээний хөлс, шимтгэл авч болно;*

Тайлбар: Клирингийн систем ажиллуулж байгаа оператор нь өөрийн оролцогчоос авах хөлс, шимтгэлийн хэмжээг түүнтэй байгуулах хамтран ажиллах гэрээнд заавал тусгасан байна.

6.1.3 *Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагчтай техникийн туршилт хийж, холбогдох дүгнэлтийг зөвшөөрөл хянан шийдвэрлэх хугацаанд багтаан гаргана;*

6.1.4 *Оролцогч хоорондын гүйлгээний үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг “Банксүлжээ” системд ажлын өдөр бүр нэг болон түүнээс дээш удаа боловсруулж, илгээнэ;*

Тайлбар: Банксүлжээ систем нь зөвхөн тухайн ажлын өдрийн гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэх бөгөөд өөр өдрийн төлбөр тооцоог гүйцэтгэхгүй.

6.1.5 *Оператор нь системийн нууцлал, аюулгүй байдал, тасралтгүй найдвартай ажиллагааг хангаж ажиллана;*

6.1.6 *Энэ журмын 2.3-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хөндлөнгийн аудитаар жилд нэг удаа баталгаажуулна;*

Тайлбар: Монголбанкнаас хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор Монголбанканд бүртгэлтэй аудитын үйлчилгээ үзүүлэх байгууллагаар оператор, оролцогч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх

эрх бүхий этгээдэд аудит хийлгүүлнэ. Энэ аудит нь тухайн байгууллагын жил тутам хийлгэдэг санхүүгийн аудитад хамааралгүй бөгөөд зөвхөн тухайн байгууллагын үйл ажиллагаанд хийгдэх аудит юм.

6.1.7 *Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу аутсорсингоор дамжуулан үзүүлсэн үйлчилгээний хариуцлагыг оператор хүлээнэ;*

6.1.8 *Оператор нь тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг жилд нэг болон түүнээс дээш удаа бүх оролцогчдыг хамруулан турших бөгөөд ингэхдээ клирингийн системийн мэдээллийн технологийн үйл ажиллагааг хамгийн багадаа 12 цагийн турш нөөц төв рүү бүрэн шилжүүлнэ;*

Тайлбар: Оператор нь мэдээллийн технологийн нөөц төвийн найдвартай байдлыг жилд нэгээс доошгүй удаа туршиж, шалгана. Туршихдаа өөрийн төлбөрийн үйлчилгээг нөөц төвийн тоног төхөөрөмж рүү шилжүүлж, оролцогчдыг нөөц төв рүү холбож, 12 цагийн турш төлбөр тооцооны бүх үйл ажиллагааг зөвхөн нөөц төвөөс явуулна.

6.1.9 *Гэнэтийн саатал гарч оролцогч хоорондын гүйлгээ, үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг Банксүлжээ системд дамжуулах үйл явц тус тус саатах тохиолдолд Монголбанкны хянан шалгагчид нэн даруй мэдэгдэнэ;*

Тайлбар: Журмын 2.3.14-т “Төлбөрийн системийн үйл ажиллагаа 2 минутаас дээш хугацаагаар, төлөвлөгөөт бусаар хэсэгчлэн болон бүрэн зогсох нь гэнэтийн саатал байна.” гэж заасны дагуу гэнэтийн саатал гарсан тохиолдолд Монголбанканд мэдэгдэж, саатлыг яаралтай арилгах арга хэмжээ авч ажиллана.

6.1.10 *Операторын системд гэнэтийн саатал гарсан тохиолдолд саатлын талаар системийн оролцогчдод нэн даруй мэдэгдэж, засварлах хугацаа, авах арга хэмжээний талаар мэдээлэл өгч, саатлыг богино хугацаанд арилгах, системийг хэвийн байдалд оруулах бүх арга хэмжээг авна. Шаардлагатай тохиолдолд оролцогчтой хамтран ажиллана;*

6.1.11 *Системд саатал, гэмтэл гарах үед мэдээлэл солилцох зорилгоор дундын цахим групп үүсгэсэн байх бөгөөд оролцогч болон операторын холбогдох албан тушаалтан солигдсон эсэхээс үл хамааран мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлнэ;*

6.1.12 *Мэдээллийн технологи болон төлбөр тооцоо хариуцсан албан тушаалтан, тэдгээрийг орлох албан тушаалтны нэрсийн жагсаалт, холбоо барих утас зэрэг мэдээллийг оператор болон оролцогч нь харилцан солилцох бөгөөд нэрсийн жагсаалтад өөрчлөлт орох бүр харилцан мэдэгдэнэ;*

6.1.13 *Оператор нь өөрийн хариуцан ажиллуулж байгаа систем болон системийн дүрэмд өөрчлөлт оруулахаас ажлын 20-оос доошгүй өдрийн өмнө нийт оролцогч нарт болон Монголбанкны төлбөрийн систем хариуцсан нэгжид албан ёсоор мэдэгдэж, холбогдох зааврыг хүргүүлнэ;*

Тайлбар: Монголбанкнаас зөвшөөрөлтэй клирингийн системийн оператор болон Монголбанкны ажиллуулж буй системийн оператор нь өөрчлөлт орсон, шинэчлэн батлагдсан дүрмийг оролцогчдод албан бичгээр хүргүүлсэн өдрөөс дор хаяж ажлын 20-н өдрийн дараа албан ёсоор мөрдөж эхэлнэ.

6.1.14 Оператор нь энэ журмын 6.1.13-т заасан өөрчлөлтийг хэрэгжүүлэхээс өмнө оролцогчид ба харилцан холболт бүхий операторуудтай хамтарсан туршилт хийж, хяналт тавина. Шаардлагатай гэж үзвэл туршилтын явцад операторын зүгээс оролцогч болон харилцан холболт бүхий оператор нарт тусалцаа үзүүлнэ;

6.1.15 Системийн дүрэм, үйлчилгээний хөлс, шимтгэл, хураамжийн нөхцөлийг өөрийн цахим хуудсанд нийтэд ил тод байршуулна;

6.1.16 Монголбанкнаас шийдвэр гарсан тохиолдолд өөрийн системийн оролцогчийн гүйлгээнд хязгаарлалт тогтоох, гүйлгээг нь дамжуулахгүй байх арга хэмжээг авна;

Тайлбар: Монголбанк болон клирингийн систем ажиллуулж байгаа оператор нь оролцогчийн зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, цуцалсан гэх мэт Монголбанкны шийдвэрийн дагуу тухайн оролцогчийн гүйлгээнд хэсэгчлэн болон бүрэн хязгаарлалт тавих үүрэгтэй.

6.1.17 Оператор нь өөрийн системээс оролцогчийг хасах буюу оролцогчтой хамтын ажиллагааг зогсоохоор шийдсэн тохиолдолд Монголбанкны төлбөрийн систем хариуцсан нэгжид болон тухайн оролцогчид энэ талаар зургаан сарын өмнө мэдэгдэнэ.

Тайлбар: Монголбанк болон клирингийн систем ажиллуулж байгаа оператор нь өөрийн оролцогчийг шууд системээс хасч, гүйлгээг зогсоож болохгүй. Оролцогчийг системээс хасах шийдвэрийг урьдчилан гаргаж тухайн оролцогч болон Монголбанканд дор хаяж 6 сарын өмнө мэдэгдэнэ, шаардлагатай тохиолдолд гурвалсан уулзалт зохион байгуулж, нөхцөл байдлыг хэлэлцэнэ.

6.2 Оператор нь энэ журмын 2.1 болон 2.3-2.5-т заасан шаардлагыг зөвшөөрөл эзэмших хугацаандаа тогтмол хангана.

6.3 Оператор нь “Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчим”-ын дагуу өөрийн үнэлгээг жилд нэгээс доошгүй удаа хийж гүйцэтгэнэ.

Тайлбар: Дэлхийн банкнаас боловсруулан гаргадаг Санхүүгийн дэд бүтцийн 24 зарчим (<https://www.bis.org/cpmi/publ/d101a.pdf>)-д заасны дагуу оператор нь өөрийн системийн үйл ажиллагааг жил бүр үнэлэх үүрэгтэй.

ДОЛОО. ИННОВАЦИЙН ОФФИС

7.1 Төлбөрийн системийн үйл ажиллагааг зохицуулах зорилгоор баталсан журам, заавар, дүрмийн талаар хуулийн этгээдэд мэдээлэл өгөх, санал хүсэлтийг хүлээн авах үүрэг бүхий инновацийн оффисыг Монголбанкны төлбөрийн систем хариуцсан газар, нэгжээс хариуцан ажиллуулна.

7.2 Инновацийн оффис нь дараах чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өгнө:

7.2.1 Шинэлэг санаа, инновац шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгож байгаа хуулийн этгээдийн үйл ажиллагаанд Монголбанкнаас баталсан журам, зааврыг хэрхэн хамааруулж ойлгох, ашиглах, мөрдөх;

7.2.2 Тухайн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэхэд журам, зааврын хүрээнд тулгарч байгаа бэрхшээл, хязгаарлалт тогтоож байгаа зүйл заалтын талаар мэдээлэл солилцох.

7.3 Инновацийн оффис нь Монголбанкнаас зөвшөөрөл авсан эсэхээс үл хамааран бүх хуулийн этгээд, тэдгээрийн төлөөлөгч нарт нээлттэй бөгөөд санал болгож байгаа бүтээгдэхүүн үйлчилгээ нь шинэлэг санаа, инновац дээр суурилсан байх үндсэн шаардлагыг тавина.

7.4 Инновацийн оффист хандах этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

7.4.1 Санал болгож байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээ нь шинэлэг санаа, инновац дээр суурилсан байх, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн;

7.4.2 Үйлчилгээ нь санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөхгүй, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх чиглэлд ашиглагдах зорилго агуулаагүй;

7.4.3 Ижил төстэй бүтээгдэхүүн, үйлчилгээтэй харьцуулахад хэрэглэгчдийн хүртэх үр ашиг, өрсөлдөх чадвараар илүү байх;

7.4.4 Хүсэлт гаргагч нь төлбөрийн системд хамаарах хууль, Монголбанкнаас баталсан журам, зааврын талаар уншиж судалсан;

7.4.5 Үйл ажиллагаа явуулахад үүсэж болзошгүй эрсдэлийг үнэлж, сэргийлэх арга хэрэгслийг бий болгосон байх.

7.5 Технологийн шийдэл нь зах зээлд нэвтэрсэн, эсхүл хэрэглэгчдэд хүргэх үр ашиг багатай, энэ журмын 7.4-т заасан шаардлагыг хангахгүй гэж Монголбанкнаас үзвэл тухайн этгээдийг инновацийн оффист хүлээн авахгүй.

НАЙМ.ХЯНАЛТ, ТАЙЛАН МЭДЭЭ, ХАРИУЦЛАГА

Хяналт

8.1 Монголбанк нь төлбөрийн системийн үйл ажиллагаанд зайнаас болон газар дээрх хяналт, шалгалтыг хэрэгжүүлнэ.

8.2 Монголбанк нь төлбөрийн системд дараах үндсэн чиглэлээр хяналт тавина:

8.2.1 Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10.1-т заасан зөвшөөрөл бүхий этгээдийн үйл ажиллагаа нь холбогдох хууль, дүрэм, журам, тушаал, заавар, гэрээ, Монголбанкнаас тавьсан шаардлагын дагуу явагдаж байгаа эсэх;

8.2.2 Иргэн, хуулийн этгээд нь Монголбанкны зөвшөөрөлгүйгээр Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10.1-т заасан үйл ажиллагааг эрхэлж байгаа эсэх;

8.2.3 Монголбанкнаас үүсгэн байгуулж, ажиллуулж байгаа системийн оператор нь энэ журам, оролцогчтой байгуулсан гэрээ болон Монголбанкнаас баталсан төлбөрийн системд мөрдөх бусад эрх зүйн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байгаа эсэх.

- 8.3 *Хяналт, шалгалтын явцад зөрчил илэрсэн тохиолдолд, эсхүл гомдол, мэдээллийн дагуу Монголбанкны хянан шалгагч нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.*
- 8.4 *Монголбанк нь энэ журамд заасан зөвшөөрөл бүхий этгээдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийхдээ хянан зохицуулах чиг үүрэг бүхий байгууллагатай хамтарч болно.*
- 8.5 *Монголбанк нь газар дээрх хяналт, шалгалтыг урьдчилан төлөвлөсний дагуу (төлөвлөгөөт) болон гэнэтийн хэлбэрээр хэрэгжүүлнэ.*

Тайлбар: Шалгалтын төлөвлөгөө нь Монголбанкны дотоод мэдээлэл бөгөөд төлөвлөгөөт шалгалтын талаар шалгуулж байгаа зөвшөөрөл бүхий этгээдэд урьдчилан мэдэгдэх шаардлагагүй. Төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалтын тухай мэдэгдээгүй байх нь шалгуулахгүй байх үндэслэл болохгүй.

- 8.6 *Төлөвлөгөөт шалгалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамжийн хүрээнд (Хавсралт 10) оператор, оролцогчид хийнэ.*
- 8.7 *Монголбанкны хянан шалгагч нь тодорхой мэдээлэлд үндэслэн Монголбанкны холбогдох удирдлагад танилцуулсны үндсэн дээр, эсхүл удирдлага, газрын захирлын өгсөн үүрэг даалгавар, удирдамжийн дагуу гэнэтийн шалгалтыг оператор, оролцогч нарт урьдчилан мэдэгдэлгүйгээр хийж болно.*
- 8.8 *Шалгалтыг хамрах хүрээгээр нь иж бүрэн ба хэсэгчилсэн гэж ангилна:*
- 8.8.1 *Иж бүрэн шалгалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан хуваарь, удирдамжийн хүрээнд хийх ба оператор, оролцогчийн төлбөрийн системтэй холбоотой үйл ажиллагааг бүхэлд нь шалгаж, дүгнэлт өгнө.*
- 8.8.2 *Хэсэгчилсэн шалгалтыг оролцогч, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн мөрөөр, эсхүл Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тухайн оператор, оролцогчийн үйл ажиллагааны тодорхой хэсгийг шалгаж, дүгнэлт өгөх зорилгоор хийнэ.*
- 8.9 *Монголбанкны хянан шалгагч нь тухайн хяналт, шалгалтыг хийж дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор шалгалтын тайланг бэлтгэж, цаашид хийх шаардлагатай ажил, авах арга хэмжээний талаарх саналын хамт Монголбанкны удирдлагад танилцуулах бөгөөд шалгалтын тайлан нь дараах мэдээллийг агуулсан байна:*
- 8.9.1 *Шалгалтын зорилго, хэлбэр, хамрах хүрээ, чиглэл, шалгалт хийсэн огноо;*
- 8.9.2 *Шалгалтын явцад илэрсэн зөрчилтэй үйл ажиллагаа, зөрчил гаргасан этгээдийн нэр, албан тушаал, зөрчигдсөн хууль тогтоомжийн заалт;*
- 8.9.3 *Шалгалтын ажлын хэсгээс гаргасан дүгнэлт, авах арга хэмжээний талаарх санал, зөвлөмж;*
- 8.9.4 *Хууль тогтоомж зөрчсөнийг нотлох баримт материалд үндэслэн ногдуулсан Улсын байцаагчийн акт, мэдэгдэл, шийтгэл;*

8.9.5 Шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, засаж залруулах талаар шуурхай арга хэмжээ авсан бол тайлбар;

8.9.6 Шалгалтын явцад санал, гомдол хүлээн авсан бол түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх тайлбар;

8.9.7 Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн талаарх нотлох баримт бүхий тайлбар, дүгнэлт.

8.10 Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчилд Монголбанкны ахлах хянан шалгагч, хянан шалгагч нь улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд холбогдох арга хэмжээ авна.

8.11 Иргэн, хуулийн этгээд, төлбөрийн системийн оролцогч нь төлбөрийн систем, төлбөрийн үйлчилгээтэй холбоотой санал, гомдлыг Монголбанканд гаргаж болно.

8.12 Монголбанкны хянан шалгагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10.1-т заасан зөвшөөрөл бүхий этгээдийн барилга байгууламж, систем, мэдээллийн санд нэвтрэн данс, гүйлгээ, бүртгэлтэй танилцах, бусад баримт бичиг, төлбөрийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, программ хангамжийг шалгах эрхтэй бөгөөд тухайн байгууллагын ажилтнаас мэдээлэл авч болно.

8.13 Монголбанкнаас шаардлагатай гэж үзвэл хяналт, шалгалтын үр дүнг олон нийтэд мэдээлнэ.

8.14 Зөвшөөрөл бүхий этгээд нь Монголбанкнаас шаардсан тохиолдолд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 28.5-д заасны дагуу Монголбанканд бүртгэлтэй хүлээн зөвшөөрөгдсөн аудитын байгууллагаар аудит хийлгэнэ. Энэ нь тухайн байгууллагын жил тутам хийлгэдэг санхүүгийн аудитад хамааралгүй бөгөөд зөвхөн Монголбанкнаас хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор тухайн байгууллагын үйл ажиллагаанд хийгдэх аудитыг ойлгоно.

8.15 Журмын 8.14-д заасан аудит хийлгэхтэй холбогдон гарах бүх зардлыг тухайн этгээд бүрэн хариуцна.

Тайлан мэдээ

8.16 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, системийн оператор нь өөрийн үйл ажиллагааны чиглэлээс хамаарч “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-т заасны дагуу тайлан мэдээг үнэн зөв гаргаж, Монголбанкны тайлангийн цахим системд оруулж, тайлангийн баталгааны маягт (Хавсралт 9)-ыг Монголбанканд албан бичгээр өгнө.

8.17 Цахим мөнгө гаргах зөвшөөрөл бүхий этгээд нь дараах тайлан мэдээг “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-т заасны дагуу боловсруулж, Монголбанканд өгнө:

Тайлбар: Тухайн сард хэрэглэгч өөрөө цахим мөнгөний данснаас зарлага гаргасан буюу мерчант дээрх худалдан авалт, цахим мөнгөний данс хооронд шилжүүлэг, бусад оролцогчийн данс руу шилжүүлэг зэрэг үйлдэл хийсэн тохиолдолд тухайн хэрэглэгчийн идэвхтэй гэж тооцно. Үйлчилгээний хураамж суутгах, хүү тооцогдож орох гэх автомат үйлдэл нь идэвхтэй хэрэглэгчийн үйлдэл болж тоологдохгүй.

8.17.1 *Баталгааны дансны мэдээллийг тус зааврын хүснэгт 17-д заасны дагуу 7 хоног бүр гаргаж, дараагийн Лхагва гарагт;*

8.17.2 *Хэрэглэгч болон гүйлгээний тайланг тус зааврын хүснэгт 18, 19-т заасны дагуу сар тутам гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор Монголбанкны тайлангийн цахим системд оруулж, тайлангийн баталгааны маягтыг (Хавсралт 9) дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор албан бичгээр;*

Тайлбар: Хариуцсан этгээд нь тайланг системд амжилттай баталгаажуулах бүрд баталгааны маягт гарч ирнэ. Баталгааны маягтыг холбогдох этгээдүүд гарын үсэг зуран баталгаажуулж хадгалах бөгөөд тухайн улирлын сар бүрийн 3 ширхэг баталгааны маягтыг цуглуулж дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор албан бичгээр Монголбанканд хүргүүлнэ.

8.17.3 *Цахим мөнгөний баталгааны дансны өдөр тутмын үлдэгдлийг улирал бүр банкаар баталгаажуулж, дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор албан бичгээр.*

8.18 *Картын үйл ажиллагаа эрхлэх этгээд нь “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ын хүснэгт 1, 2, 3, 4, 6-д заасан тайланг сар тутам гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор Монголбанкны тайлангийн цахим системд оруулж, тайлангийн баталгааны маягтыг (Хавсралт 9) дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор Монголбанканд албан бичгээр өгнө.*

Тайлбар: Хариуцсан этгээд нь тайланг системд амжилттай баталгаажуулах бүрд баталгааны маягт гарч ирнэ. Баталгааны маягтыг холбогдох этгээдүүд гарын үсэг зуран баталгаажуулж хадгалах бөгөөд тухайн улирлын сар бүрийн 3 ширхэг баталгааны маягтыг цуглуулж дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор албан бичгээр Монголбанканд хүргүүлнэ.

8.19 *Банк, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ын хүснэгт 5, 7, 8, 9, 10-т заасан тайланг сар тутам гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор, хүснэгт 20, 21-т заасан тайланг сар тутамд гаргаж, дараа сарын 15-ны өдрийн дотор Монголбанкны тайлангийн системд оруулж, тайлангийн баталгааны маягтыг (Хавсралт 9) дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор Монголбанканд албан бичгээр өгнө.*

Тайлбар: Хариуцсан этгээд нь тайланг системд амжилттай баталгаажуулах бүрд баталгааны маягт гарч ирнэ. Баталгааны маягтыг холбогдох этгээдүүд гарын үсэг зуран баталгаажуулж хадгалах бөгөөд тухайн улирлын сар бүрийн 3 ширхэг баталгааны маягтыг цуглуулж дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор албан бичгээр Монголбанканд хүргүүлнэ.

8.20 *Оператор нь “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ын хүснэгт 11, 12, 13, 14-т заасан тайланг сар тутамд гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор Монголбанканд цахимаар ирүүлж, тайлангийн баталгааны маягтыг (Хавсралт 9) дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор Монголбанканд албан бичгээр өгнө.*

Тайлбар: Хариуцсан этгээд нь тайланг системд амжилттай баталгаажуулах бүрд баталгааны маягт гарч ирнэ. Баталгааны маягтыг холбогдох этгээдүүд гарын үсэг зуран баталгаажуулж хадгалах бөгөөд тухайн улирлын сар бүрийн 3 ширхэг баталгааны маягтыг цуглуулж дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор албан бичгээр Монголбанканд хүргүүлнэ.

- 8.21 Төлбөр тооцооны төлөөлөгч нь “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ын хүснэгт 15, 16-д заасан тайланг сар бүр гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор Монголбанканд цахимаар өгнө.
- 8.22 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн үйлчилгээтэй холбоотой үүссэн аливаа гомдол, маргааны талаарх үнэн зөв бүртгэл, тайлан хөтөлж, Монголбанкнаас шаардсан тохиолдолд тухайн мэдээллийг өгнө.
- 8.23 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч болон оператор нь энэ журмын 8.16-8.22-т заасан тайлан мэдээнээс гадна өөрийн үйл ажиллагаанд хамаарах Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээллийг тухай бүр өгнө.
- 8.24 Монголбанк нь дээрх тайлан мэдээг нэгтгэж, дараа улиралд багтаан олон нийтэд мэдээлнэ.

Хариуцлага

- 8.25 Энэ журмыг зөрчсөн, Монголбанкнаас гаргасан шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй ажилтан, албан тушаалтан, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Монголбанкны улсын байцаагч акт, мэдэгдэл хүргүүлэх болон Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

_____ооо_____

**ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ**

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн оноосон нэр	Монгол					
	Англи /Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ/					
Улсын бүртгэлийн дугаар						
Регистрийн дугаар						
Зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны төрлийг сонгоно уу.						
☐ Систем ажиллуулах ☐ Төлбөрийн карт гаргах /Картын нэрийг бичнэ/ ☐ Төлбөрийн карт хүлээн авах ☐ Төлбөр тооцооны төлөөлөгч ☐ Гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх ☐ Аутсорсингийн үйлчилгээ авах ☐ Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх ☐ Цахим мөнгө гаргах						
Хуулийн этгээдийн хэлбэр	☐ Хувьцаат компани ☐ Хязгаарлагдмал хариуцлагатай компани					
Хөрөнгө оруулалтын хэлбэр	☐ Дотоодын хөрөнгө оруулалттай ☐ Гадаадын хөрөнгө оруулалттай					
Хаяг, байршил	Аймаг/Хот					
	Сум/Дүүрэг					
	Баг/Хороо					
	Гудамж/байр					
	Тоот					
	Холбоо барих утас					
	Цахим хуудас					
	Цахим хаяг					
Хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл						
Хувьцаа эзэмшигчдийн овог нэр/хуулийн этгээдийн нэр	Хувьцааны тоо ширхэг	Хувьцааны төрөл	Хувь нийлүүлсэн хөрөнгийн	ХНХ-д эзлэх хувь (%)		

			/ХНХ/ хэмжээ		
		☐	☐		
		ДЭХ	ЭХ		
		☐	☐		
		ДЭХ	ЭХ		
		☐	☐		
		ДЭХ	ЭХ		
Тэмдэглэл: ДЭХ-Давуу эрхийн хувьцаа, ЭХ-энгийн хувьцаа. /Хувьцаа эзэмшигч тус бүрээр бичнэ./					
Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол дараах мэдээллийг үнэн зөв бөглөнө үү.					
Хуулийн этгээдийн нэр	Монгол				
	Англи				
Улсын бүртгэлийн дугаар					
Регистрийн дугаар					
Бизнесийн болон үйл ажиллагааны чиглэл					
Хаяг, байршил	Аймаг / Хот				
	Сум / Дүүрэг				
	Баг / Хороо				
	Гудамж / байр				
	Тоот				
	Холбоо барих утас				
	Цахим хуудас				
	Цахим хаяг				
Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь иргэн бол доорх мэдээллийг үнэн зөв бөглөнө үү.					
Овог нэр					
Регистрийн дугаар					
Албан ёсны хаяг, байршил					

Эрхэлж байгаа ажил, албан тушаал							
Ажлын хаяг							
Удирдлага боловсон хүчинтэй холбоотой мэдээлэл							
ТУЗ-тай байх эсэх	☐ Тийм	☐ Үгүй	Бүрэлдэхүүний тоо				
Хяналтын зөвлөлтэй эсэх	☐ Тийм	☐ Үгүй					
Нийт ажилтан албан хаагчдын тоо							
Албан тушаал	Овог	Нэр	Харьяалал	РД	Утасны дугаар	Мэргэжил	Боловсролын зэрэг
ТУЗ-ын дарга							
ТУЗ-ын гишүүн							
Хяналтын зөвлөл болон хяналтын нэгжгийн гишүүн							
Гүйцэтгэх захирал							
Ерөнхий нягтлан бодогч							
Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг удирдах ажилтан тус бүрээр бичнэ.)							
Дээрх үйл ажиллагааг эрхлэн явуулснаар Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн Монголбанкнаас баталсан эрх зүйн баримт бичгийн холбогдох заалт, шаардлагыг биелүүлэх үүрэг хариуцлага ногдож байгааг ухамсарлан ойлгосон бөгөөд эдгээрийг үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллах болно. Зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Төлбөрийн системийн журам”-ын шаардлагад нийцүүлэн үнэн зөв бүрдүүлж, хүргүүлж байна. Бүрдүүлсэн баримт бичигт худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно. Өргөдөл, материалыг хүлээн авч, хянан шийдвэрлэж холбогдох зөвшөөрлийг олгож өгнө үү. Зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг эрхэлж эхэлснээс хойш Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монголбанкнаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах болно.							

Өргөдөл гаргасан:

Гүйцэтгэх захирал

Гарын үсэг

Огноо

ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДӨЛД ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, эсхүл систем ажиллуулах тухай компани үүсгэн байгуулагчдын хурлын тэмдэглэл, шийдвэр (Нэг үүсгэн байгуулагчтай бол тухайн этгээдийн шийдвэр)	
2	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ (нотариатаар баталгаажуулсан хуулбар)	
3	Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хувьд гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээ	
4	Хуулийн этгээдийн дүрмийн баталгаажсан хуулбар	
5	Хувьцаа эзэмшигчдээс хувь нийлүүлсэн хөрөнгийн гарал үүслийг нотлох баримт бичиг: ✓ Хөрөнгө шилжүүлэхийг зөвшөөрсөн хурлын тэмдэглэл, харилцагч банкны дансны хуулга; ✓ Хувьцаа эзэмшигч болох этгээд, тэдгээрийн холбогдох этгээд нь хуулийн этгээд бол үйл ажиллагааны сүүлийн гурван жилээс багагүй хугацааны аудитаар баталгаажуулсан санхүүгийн дэлгэрэнгүй тайлан, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан; ✓ Иргэн бол сүүлийн гурван жилээс багагүй хугацааны цалин, орлогын тодорхойлолт, харилцагч банкны дансны хуулга, Хувь хүний орлогын албан татварын тайлан; ✓ Хувьцаа эзэмшигч болох этгээд, тэдгээрийн холбогдох этгээд нь гааль, татварын өртэй эсэх талаарх эрх бүхий байгууллагын тодорхойлолт; ✓ Хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр, гарал үүслийг нотлоход шаардлагатай гэж Монголбанкнаас үзсэн бусад баримт бичиг.	
6	Үйл ажиллагаа эрхлэх эхний таван жилийн бизнес төлөвлөгөө (зорилтот зах зээл, ижил төстэй үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдээс ялгарах онцлог давуу тал, үйл ажиллагаанаас олох орлого/зардлын таамаглал тайлбарын хамт, өөрийн хөрөнгө болон өрийн харьцаа, ирээдүйн таван жилийн мөнгөн урсгалын төсөөлөл)	
7	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын тогтолцоо бүрдүүлснийг нотлох баримт бичиг, тухайн баримт бичиг нь холбогдох хууль тогтоомжийн шаардлагатай хэрхэн нийцэж байгаа тухай тайлбар	
8	Эрсдэлийн удирдлага, нягтлан бодох бүртгэлийн аргачлал, үйл ажиллагаа, дотоод хяналт зэргийг зохицуулсан баримт бичиг, байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаарх мэдээлэл	

9	<i>Гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл:</i> ✓ <i>Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлагын иргэний үнэмлэхний цахим лавлагаа, ажлын туршилага, боловсролын гэрчилгээ, дипломыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;</i> ✓ <i>Нийт хувьцааны 5 хувь буюу түүнээс дээш тооны хувьцаа эзэмшигчийн иргэний үнэмлэхний цахим лавлагаа;</i> ✓ <i>Гүйцэтгэх удирдлага, шийдвэр гаргах түвшний ажилтнууд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авилга, хээл хахууль, эдийн засгийн эсрэг эрүүгийн хариуцлага хүлээгээгүй болохыг нотлох холбогдох байгууллагын тодорхойлолт;</i> ✓ <i>Гүйцэтгэх удирдлага, шийдвэр гаргах түвшний ажилтнууд нь зээл, батлан даалт, гааль, татвар, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өрийн үлдэгдэлгүй, шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй болохыг нотлох холбогдох байгууллагын тодорхойлолт.</i> <i>Гүйцэтгэх удирдлагын албан тушаалд томилогдох этгээд нь гадаадын харьяалалтай иргэн бол:</i> ✓ <i>Харьяалах улс, оронд зээл, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өртэй эсэх, шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй болохыг нотлох баримт бичиг;</i> ✓ <i>Харьяалах улс оронд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, эрүүгийн хариуцлага хүлээгээгүй болохыг нотлох баримт бичиг.</i>	
10	<i>Хуулийн этгээд үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч хүртэлх хэлхээ холбоог нотлох баримт бичиг</i>	
11	<i>Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн хувьд системийн оператор, хэрэглэгч, мерчант, аутсорсингийн үйлчилгээ үзүүлэгч, гэрээт төлөөлөгч, төлбөр тооцооны төлөөлөгчтэй байгуулах гэрээ, эсхүл гэрээний баталгаажсан загвар</i> <i>Систем ажиллуулах хүсэлт гаргагчийн хувьд системийн оролцогч, аутсорсингийн үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулах гэрээ, эсхүл гэрээний баталгаажсан загвар</i>	

12	<i>Тухайн үйл ажиллагаанд ашиглагдах орон байр, систем, тоног төхөөрөмж, программ хангамжийн мэдээлэл:</i> ✓ Байрших байр, барилгыг худалдаж авсан бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, эсхүл цахим лавлагаа, түрээсэлж байгаа бол түрээсийн гэрээ; ✓ Ажлын байр нь хэрэглэгчийн мөнгөн хөрөнгийн найдвартай байдлыг хангасан эсэхийг нотолсон баримт; ✓ Ашиглаж байгаа программын жагсаалт болон тэдгээрийн танилцуулга; ✓ Сүлжээ болон программ хангамжийн бүтэц схем (хэрэглэгч болон сервер тал орсон); ✓ Мэдээлэл технологийн хэлтсийн танилцуулга, ажилтнуудын чиг үүргийн хамт; ✓ Өгөгдлийн сангийн дэлгэрэнгүй мэдээлэл; ✓ Дата төв (үндсэн болон нөөц төв)-ийн дэлгэрэнгүй мэдээлэл; ✓ Системүүдийн хоорондоо харьцаж байгаа хэсгийн интерфэйсийн жагсаалт; ✓ Системийн ачаалал даах чадварын тайлан; ✓ Тасралтгүй ажиллагааг хангасан байдал; ✓ Нууцлал, аюулгүй байдал хангасан байдал; ✓ Системийг худалдсан, программ хангамж нийлүүлэх, мэдээлэл технологийн үйлчилгээ үзүүлэх, түрээслүүлсэн, засвар үйлчилгээ үзүүлэх компанитай байгуулсан гэрээ.	
13	<i>Дараах үйл ажиллагааг тусгасан баримт бичиг:</i> ✓ Гүйлгээ хийгдэх, гүйлгээ дамжуулах дараалал; ✓ Мөнгөн хөрөнгө, мэдээллийн урсгалын схемийг агуулсан үйл ажиллагааны зураглал; ✓ Төлбөр гүйцэтгэх хугацаа; ✓ Хэрэглэгчийн мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлэх эсэх, зээлийн үйлчилгээ үзүүлэх эсэх; ✓ Улс хоорондын гүйлгээнд оролцох эсэх. <i>(Гүйлгээний мэдээллийг боловсруулах, хадгалах явцад мэдээллийг задруулах, буруугаар ашиглах, устгах, өөрчлөх, хулгайлах, мэдээлэл алдагдахаас хамгаалсан арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлнэ)</i>	
14	<i>Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө (үйл ажиллагаа тасалдахад авч хэрэгжүүлэх арга хэмжээ, буцаж хэвийн ажиллагаанд орох хугацаа, нөөц төвийн талаарх мэдээлэл, ажиллах зарчим)</i>	
15	<i>Хэрэглэгч, оролцогчийн гомдол, санал, маргааныг хэрхэн шийдэх талаар тусгасан баримт бичиг, дүрэм, журам</i>	
16	<i>Оператортай туршилт хийж, бусад оролцогч хооронд гүйлгээ дамжуулах боломжтойг нотолсон дүгнэлт</i>	
17	<i>“Зөвшөөрлийн хураамжийн ерөнхий нөхцөл”-д заасан зөвшөөрлийн материал хүлээн авах хураамжийг төлсөн баримт</i>	

18	<i>Хараат компани, охин компани, зэргэлдээ компани, толгой компанийн талаарх мэдээлэл</i>	
19	<i>Систем ажиллуулах этгээдийн хувьд системийн дүрэм</i>	
20	<i>Карт гаргах, эсхүл хүлээн авах хүсэлт гаргагчийн хувьд олон улсын картын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын сүлжээнд гишүүнээр элссэн бол тухайн гишүүнчлэлийн гэрээ, холбогдох бусад баримт бичиг</i>	
21	<i>Гаргахаар төлөвлөж буй карт, эсхүл карт хүлээн авах төхөөрөмж нь олон улсын стандарт, шаардлагын дагуу туршилт хийж баталгаажуулсныг нотлох баримт бичиг буюу туршилт хийсэн байгууллагаас ирүүлсэн тайлан</i>	
22	<i>Цахим мөнгө гаргах хүсэлт гаргагчийн хувьд цахим мөнгийг бүртгэх нягтлан бодох бүртгэл, цахим мөнгийг мөнгөн хөрөнгөнд харилцан хөрвүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа, гүйлгээний лимитийг хэрхэн хангаж буйг тусгасан дүрэм, журам</i>	
23	<i>Цахим мөнгө гаргах хүсэлт гаргагч нь баталгааны данс нээснийг нотлох баримт бичиг буюу банкны дансны тодорхойлолт</i>	
24	<i>Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл</i>	

Тайлбар: Систем ажиллуулах хүсэлт гаргагч нь хууль, энэхүү журмаар тавигдах шаардлагыг хэрхэн хангасан тайлбарыг дараах хүснэгтэд заасан жагсаалтын дагуу зөвшөөрлийн материалын хамт ирүүлнэ. Тайлбар хэсэгт тухайн шаардлагыг өөрийн журам, заавар, холбогдох баримт бичгийн аль хэсэгт, ямар заалтаар хангаж байгааг тодорхой тэмдэглэсэн байна.

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль		
<u>Заалт</u>	<u>14 дүгээр зүйл. Систем ажиллуулах хүсэлт гаргагчид тавих шаардлага</u>	<u>Тайлбар</u>
14.1	Систем ажиллуулах хүсэлт гаргагч дараахь шаардлагыг хангасан байна:	
14.1.1	Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан;	
14.1.2	Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгө, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангасан;	
14.1.3	Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын зохистой арга хэрэгсэл бүхий систем ажиллуулахад шаардлага хангахуйц техникийн болон зохион байгуулалтын ур чадвартай;	
14.1.4	Үндэсний төлбөрийн системийн нэгдмэл байдал, системийн тасралтгүй, найдвартай, үр ашигтай ажиллагааг хангах;	
14.1.5	Төлбөр тооцоог үл саатуулах, төлбөр тооцоог эцэслэх, төлбөрийн үл буцаагдах байдлыг хангах чадвартай;	
14.1.6	Систем ажиллуулахад шаардлагатай мэдлэг, туршлага, мэргэжлийн ёс зүй, мэргэшлийн ур чадвар бүхий хүний нөөцтэй;	
14.1.7	Өөрийн системийн оролцогчид эрх тэгш оролцох боломжийг хангасан;	
14.1.8	Зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, төлбөр тооцооны эрсдэлийг хянах эрсдэлийн удирдлагын тогтолцоотой;	
14.1.9	Үндсэн системийн үйл ажиллагаа доголдсон нөхцөлд авч хэрэгжүүлэх онцгой байдлын болон тасралтгүй, найдвартай ажиллагааны төлөвлөгөөтэй;	
14.1.10	Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөлийг хангах.	
14.2	Монголбанк энэ хуулийн 14.1.2-т заасан өөрийн хөрөнгийн хэмжээ, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг доор дурдсан хүчин зүйлсийг харгалзан үзэж тогтоох ба зөвшөөрөл авч байгаа этгээдийн зөвшөөрлийн нөхцөлд тодорхой тусгана:	
14.2.1	Ажиллуулах системийн төрөл;	
14.2.2	Тус системээр боловсруулах төлбөрийн тоо ба дүнгийн урьдчилсан тооцоо;	
14.2.3	Холбогдох бусад хүчин зүйлс.	

Төлбөрийн системийн журам		
Заалт	Хоёр. Систем ажиллуулах хүсэлт гаргагчид тавих шаардлага	Тайлбар
2.2	Энэ журмын 1.4.8-д заасан систем ажиллуулах хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:	
2.2.1	Санхүүгийн мэдээний олон улсын ISO20022, ISO8583, ISO27001 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байх;	
2.2.2	Энэ журмын 2.3-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хөндлөнгийн аудитаар баталгаажуулсан байх;	
2.2.3	Алдаатай, эсхүл нэр, данс зөрсөн гүйлгээ дамжихгүй байх нөхцөлийг хангаж, үүссэн маргааныг шийдвэрлэх тогтолцоотой байх;	
2.2.4	Монголбанкны Банксүлжээ системийн үйл ажиллагаа хариуцсан нэгжтэй техникийн туршилт хийж, хоёр талаас баталгаажуулсан;	
2.2.5	Хүсэлт гаргагч нь төлбөр тооцооны эрсдэлээс сэргийлэх зорилгоор Монголбанкны шаардлагын дагуу оролцогчийн үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг тухайн оролцогчийн төлбөр тооцооны данс дахь мөнгөн хөрөнгийн боломжит дүнгээс илүүгүй байхаар хязгаарлах техник технологийн боломжийг бүрдүүлсэн;	
2.2.6	Системийн дүрэмтэй байх бөгөөд дүрэмд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 23 дугаар зүйлд зааснаас гадна дараах зүйлсийг тусгаж, Монголбанканд хянуулсан байна:	
2.2.6.1	Оролцогчид тавигдах шаардлага, мэдээллийн технологи болон бусад техникийн шаардлага;	
2.2.6.2	Оролцогчийг системд бүртгэх, хязгаарлах буюу түр хугацаагаар идэвхгүй болгох, бүртгэлээс хасах үйл ажиллагаа;	
2.2.6.3	Гүйлгээ дамжуулах, баталгаажуулах, үр дүнгийн тооцоолол хийх, үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг Монголбанканд дамжуулах хуваарь, зарчим, буцаан дуудах, гүйлгээг эцсийн, үл буцаагдах гэж үзэх нөхцөл;	
2.2.6.4	Оролцогч төлбөр түргэн гүйцэтгэх чадваргүй болсны улмаас системд учруулах эрсдэлийг хязгаарлах, удирдах арга хэмжээ;	
2.2.6.5	Тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах тухай (системд өөрчлөлт, шинэчлэлт хийх, төлөвлөгөөт зогсолт болон гэнэтийн саатал гарсан үед авах арга хэмжээний талаар дэлгэрэнгүй тусгасан байх);	
2.2.6.6	Маргаан шийдвэрлэх зарчим, хугацаа;	
2.2.6.7	Шимтгэл, хураамжийн хэмжээ, түүнийг тооцох, суутгах зарчим.	

2.2.7	Хүсэлт гаргагч нь системийн дүрмийг боловсруулахдаа оролцогчдын эрх тэгш байдлыг хангах, ижил нөхцөлөөр үйлчилгээ үзүүлэх зарчмыг баримталдаг байх;	
2.2.8	Хүсэлт гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байх;	
2.2.9	Хүсэлт гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өрийн үлдэгдэлгүй, шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй байх.	
<u>Заалт</u>	<u>Систем ажиллуулах зөвшөөрөл авах хүсэлт гаргагчийн мэдээллийн аюулгүй байдалд тавигдах нийтлэг шаардлага</u>	<u>Тайлбар</u>
2.3	Хүсэлт гаргагч нь мэдээллийн технологи, тасралтгүй ажиллагаанд дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:	
2.3.1	Дотоод сүлжээ, вэбсайт, сервер, бусад тоног төхөөрөмж рүү гаднаас халдах боломжгүй байх нөхцөлийг бүрдүүлж, байгууллагын мэдээллийн системийг аливаа сэжиг бүхий, эсхүл зөвшөөрөгдөөгүй хандалтаас хамгаалах галт хана суурилуулсан байх бөгөөд энэ нь интернэт болон бусад сүлжээгээр дамжин байгууллагын мэдээллийн системд хандах эрсдэлийг авч үзсэн байх;	
2.3.2	Хэрэглэгчийн болон гүйлгээний мэдээлэлд хандаж байгаа бүх хандалтыг хянаж, бүртгэлжүүлэх тогтолцоог бий болгосон байх;	
2.3.3	Гүйлгээ хийх, нууц мэдээлэл дамжих үед тухайн мэдээллийг дамжуулах эхний цэгээс хүлээн авах эцсийн цэг хүртэл өндөр нууцлалтай шифрлэх, гүйлгээний бүх үе шатанд (шифрлэх, мэдээлэл дамжуулах, хадгалах) хэрэглэгчийн гүйлгээ үүсгэх, дансанд хандахад ашиглагдах нууц үг, түүнтэй адилтгах бусад мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангасан байх;	
2.3.4	Мэдээллийн технологийн үндсэн систем, техник, тоног төхөөрөмж (цаашид үндсэн төв гэх) гэмтэх, аливаа саатал гарах үед үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлэн хэвийн үргэлжлүүлэх хүчин чадал бүхий нөөц систем, мэдээллийн сан, дэд бүтэцтэй байх (цаашид нөөц төв гэх);	

2.3.5	Мэдээллийн технологийн нууцлал аюулгүй байдлын талаар авч хэрэгжүүлэх бодлого, журам, заавартай байх бөгөөд үүнд мэдээллийг шифрлэх, шифрлэсэн нууц мэдээллийг тайлж уншихтай холбогдсон түлхүүр, алгоритмыг зөвшөөрөлгүй этгээд олж мэдэхээс хэрхэн сэргийлэх, үндсэн төв болон нөөц төвийн сервер, серверийн өрөөний аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар тусгасан байх;	
2.3.6	Нөөц төвийг үндсэн систем байршиж байгаа газар нутагт тохиолдож болох эрсдэлийг харгалзан үзэж, ижил эрсдэл зэрэг үүсэхээргүй зайд байршуулсан байх;	
2.3.7	Үндсэн төв болон нөөц төвийг шууд холбосон байх;	
2.3.8	Хүсэлт гаргагчийн үндсэн төвийг операторын үндсэн төвтэй үндсэн ба нөөц шугамаар шууд холбосон байх;	
2.3.9	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч, операторын нөөц төвүүдийг шууд холбосон байх;	
2.3.10	Үндсэн болон нөөц систем байршиж байгаа барилга байгууламжид агаарын чийгшил тохируулагч систем, гал унтраах систем, аваар осол мэдрэгч төхөөрөмж, тог баригч байршуулсан байхаас гадна цахилгааны нэмэлт эх үүсвэртэй холбосон байх;	
2.3.11	Энэ журмын 2.3.10-т заасан цахилгааны нэмэлт эх үүсвэрээр үйл ажиллагааг хамгийн багадаа 24 цаг явуулах боломжтой байх;	
2.3.12	Үндсэн болон нөөц системд хандах эрх бүхий ажилтнуудын тухайн системд хандан хийж болох үйлдэл, хандалтын эрхийн хязгаарлалт, хандалт бүрийг тухайн ажилтан тус бүрээр тодорхойлж, баримтжуулдаг байх;	
2.4	Монголбанкны ажиллуулж байгаа клирингийн систем, Монголбанкнаас систем ажиллуулах зөвшөөрөл авсан этгээд, тэдгээрийн оролцогчдын гэнэтийн саатлын хугацаа нэг сард тухайн системийн нийт ажиллах цагийн 0.1 хувиас илүүгүй, төлөвлөгөөт зогсолтын хугацаа нэг сард 4 цагаас илүүгүй байна.	
2.5	Зайлшгүй шаардлагаар үндсэн болон нөөц төвийн үйл ажиллагааг зэрэг хамарсан программ, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх тохиолдолд энэ журмын 2.4-т заасан төлөвлөгөөт зогсолтын хугацааг Монголбанканд албан бичгээр мэдэгдэж тохиролцсоны үндсэн дээр сунгаж болно.	
2.6	Төлбөрийн системийн үйл ажиллагаа 2 минутаас дээш хугацаагаар, төлөвлөгөөт бусаар хэсэгчлэн болон бүрэн зогсох нь гэнэтийн саатал байна.	
<u>Заалт</u>	<u>Дөрөв. Зөвшөөрөл авах хүсэлт гаргах</u>	<u>Тайлбар</u>

4.1	Хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 11.1.12 болон 11.3.12-т заасан шаардлагын дагуу энэ журмын хавсралт 2-т заасан баримт бичгийг, хавсралт 1-т заасан өргөдлийн хамт Монголбанкны төлбөрийн систем хариуцсан нэгжид албан бичгээр өгнө.	
4.7	Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 33.1-т заасны дагуу хүсэлт гаргагч нь материал өгөхөөс өмнө зөвшөөрлийн материал хүлээж авах, хянах үйлчилгээний хураамжийг төлнө.	

Тайлбар: Төлбөрийн карт гаргах хүсэлт гаргагч нь хууль, энэхүү журмаар тавигдах шаардлагыг хэрхэн хангасан тайлбарыг дараах хүснэгтэд заасан жагсаалтын дагуу зөвшөөрлийн материалын хамт ирүүлнэ. Тайлбар хэсэгт тухайн шаардлагыг өөрийн журам, заавар, холбогдох баримт бичгийн аль хэсэгт, ямар заалтаар хангаж байгааг тодорхой тэмдэглэсэн байна.

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль		
<u>Заалт</u>	<u>12 дугаар зүйл. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагчид тавих шаардлага</u>	<u>Тайлбар</u>
12.1	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч дараахь шаардлагыг хангасан байна:	
12.1.1	Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан;	
12.1.2	Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгө, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангасан;	
12.1.3	Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын зохистой тогтолцоо бүхий төлбөрийн үйлчилгээ үзүүлэх шаардлагыг хангахуйц техникийн болон зохион байгуулалтын чадвартай;	
12.1.4	Хэрэглэгчээс, эсхүл бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээс төлбөр гүйцэтгэхийн тулд хүлээж авсан мөнгөн хөрөнгийг өөр зорилгоор ашиглах, гуравдагч этгээдийн мөнгөн хөрөнгөтэй нийлүүлэх зэргээс хамгаалсан, төлбөрийн чадваргүй болсон үед үйлчилгээ үзүүлэгчийн бусад үүрэг гүйцэтгүүлэгчийн нэхэмжлэлээс тусгаарлах боломж бүхий тогтолцоотой;	
12.1.5	Таван жилийн стратеги болон бизнес төлөвлөгөөтэй;	
12.1.6	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдлэг, туршлага, мэргэжлийн ёс зүй, мэргэшлийн ур чадвар бүхий хүний нөөцтэй;	
12.1.7	Тухайн системд зөвшөөрөгдсөн гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэхэд шаардлагатай төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг баталгаажуулах, зээлийн эрсдэлээс хамгаалсан;	
12.1.8	Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөлийг хангах.	
12.2	Монголбанк энэ хуулийн 12.1.2-т заасан өөрийн хөрөнгийн хэмжээ, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг доор дурдсан хүчин зүйлсийг харгалзан үзэж тогтоох ба зөвшөөрөл авч байгаа этгээдийн зөвшөөрлийн нөхцөлд тодорхой тусгана:	

12.2.1	Үзүүлэх төлбөрийн үйлчилгээний төрөл;	
12.2.2	Төлбөрийн дундаж дүн;	
12.2.3	Холбогдох бусад хүчин зүйлс.	
12.3	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдэд тавих нэмэлт шаардлагыг Монголбанкнаас баталсан журмаар тогтооно.	

Төлбөрийн системийн журам		
<u>Заалт</u>	<u>Хоёр. Зөвшөөрөл авах хүсэлт гаргагчид тавих шаардлага</u>	<u>Тайлбар</u>
2.1	Хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 12 дугаар зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:	
2.1.1	Хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.9-т заасан шууд бус оролцогч байх тохиолдолд төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий нэг банкныг өөрийн төлбөр тооцооны төлөөлөгчөөр сонгосон;	
2.1.2	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь клирингийн, эсхүл төлбөр тооцооны системийн оролцогч болохоос өмнө тухайн системийн оператортай техникийн хамтарсан туршилт хийж, хоёр талаас баталгаажуулсан;	
2.1.3	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь QR код ашиглан гүйлгээ дамжуулах, хүлээн авахдаа Монголбанкнаас баталсан QR кодын цахим мэдээний бүтэц, зааврыг мөрдөж ажилладаг байх;	
2.1.4	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу хэрэглэгчийг таньж мэдэх үйл ажиллагааг тодорхой тусгасан дотоод журам, заавар, хяналтын тогтолцоог бий болгосон;	
2.1.5	Гадаад болон дотоод хүчин зүйлээс шалтгаалж төлбөрийн үйлчилгээ тасалдах, осол, гэмтэл гарах үед үйл ажиллагааны найдвартай, тасралтгүй байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөтэй;	
2.1.6	Хэрэглэгч, мерчантын мөнгөн хөрөнгийг найдвартай хадгалах, хамгаалах, гүйлгээний нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангахуйц энэ журмын 2.3-т заасан шаардлагыг хангасан мэдээллийн технологийн дэд бүтэцтэй;	
2.1.7	Хэрэглэгчийн данснаас зарлагын гүйлгээ хийх бүрд тухайн гүйлгээний мэдээллийг үйлчилгээний төлбөргүйгээр мэдэгдэж байх боломжийг бүрдүүлсэн;	
2.1.8	Хэрэглэгчийн хийсэн аливаа гүйлгээний түүх, гүйлгээний үе шат бүрийн талаарх мэдээллийг гаргах боломж бүхий системтэй байх;	

2.1.9	Төлбөрийн үйлчилгээтэй холбоотойгоор хэрэглэгч, мерчант болон бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс гаргасан гомдол, санал, маргаантай гүйлгээг цаг тухайд нь хүлээн авч шийдвэрлэх, тэдгээрт лавлагаа мэдээлэл өгөх үйл ажиллагааны талаар тусгасан дотоод журам, заавартай байх;	
2.1.10	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос үүдэн төлбөрийн үйлчилгээг зогсоох үед хэрэглэгч, мерчантын авлагыг барагдуулахтай холбоотой авах арга хэмжээний талаар тусгасан журамтай байх;	
2.1.11	Хүсэлт гаргагч нь хэрэглэгчтэй байгуулах гэрээнд дараах зүйлсийг тусгана:	
2.1.11.1	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн мэдээллийг нууцлах, хадгалах, ашиглах тухай;	
2.1.11.2	Хэрэглэгч нь ПИН код буюу гүйлгээг баталгаажуулахад ашиглагдах, зөвхөн тухайн хэрэглэгч мэдэж байх тоо, үсэг, тэмдэгтийн дараалал, түүнтэй адилтгах бусад мэдээллийг нууцлах, түүнийг хаяж үрэгдүүлсэн, гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид нэн даруй мэдэгдэх тухай;	
2.1.11.3	Хэрэглэгч нь өөрийн данснаас түүний зөвшөөрөлгүй хийгдсэн аливаа шилжүүлэг болон бүртгэлийн алдаа, зөрчил дутагдлыг илрүүлсэн тохиолдолд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид нэн даруй мэдэгдэх тухай;	
2.1.11.4	Хэрэглэгчийг таньж баталгаажуулах арга, хэрэгсэл болон баталгаажуулсан гэж үзэх нөхцөл;	
2.1.11.5	Хэрэглэгч тухайн гүйлгээг илгээхийг зөвшөөрсөн, баталгаажуулсан гэж үзэх нөхцөл;	
2.1.11.6	Хэрэглэгч гомдол, маргаан үүсгэх нөхцөл, шийдвэрлэх арга зам, хугацаа;	
2.1.11.7	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос үүдэн төлбөрийн үйлчилгээг зогсоох үед хэрэглэгчийн авлагыг барагдуулахтай холбоотой авах арга хэмжээ, эрх, үүрэг.	
2.1.12	Хүсэлт гаргагч нь мерчанттай байгуулах гэрээнд дараах зүйлсийг тусгана:	
2.1.12.1	Монголбанкны зөвшөөрөлтэй төлбөрийн хэрэгслийг бараа, ажил, үйлчилгээний төлбөрт хүлээн авах тухай;	
2.1.12.2	Төрийн үйлчилгээний төлбөр, орон сууцны хэрэглээний төлбөр төлөхөөс бусад картын гүйлгээ хийх тохиолдолд мерчант нь карт эзэмшигчээс шимтгэл авахгүй байх тухай;	
2.1.12.3	Мерчант нь Монгол Улсын нутаг дэвсгэрт төлбөр хүлээн авах тухай;	
2.1.12.4	Мерчантаас гомдол, маргаан үүсгэх нөхцөл, шийдвэрлэх арга зам, хугацаа;	
2.1.12.5	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос үүдэн төлбөрийн үйлчилгээг зогсоох үед мерчантын авлагыг барагдуулахтай холбоотой авах арга хэмжээ, эрх, үүрэг.	

2.1.13	Хүсэлт гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байх;	
2.1.14	Хүсэлт гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өрийн үлдэгдэлгүй, шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй байх;	
2.1.15	Монголбанкнаас тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бүрдүүлсэн байх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгө нь гуравдагч этгээдийн шаардлагаас ангид, тухайн этгээдийн санхүүгийн тайлан, татвар төлөлтийн тайлангаар батлагдсан хууль ёсны үйл ажиллагааны орлого байна.	
<u>Заалт</u>	<u>Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагчийн мэдээллийн аюулгүй байдалд тавигдах нийтлэг шаардлага</u>	<u>Тайлбар</u>
2.3	Хүсэлт гаргагч нь мэдээллийн технологи, тасралтгүй ажиллагаанд дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:	
2.3.1	Дотоод сүлжээ, вэбсайт, сервер, бусад тоног төхөөрөмж рүү гаднаас халдах боломжгүй байх нөхцөлийг бүрдүүлж, байгууллагын мэдээллийн системийг аливаа сэжиг бүхий, эсхүл зөвшөөрөгдөөгүй хандалтаас хамгаалах галт хана суурилуулсан байх бөгөөд энэ нь интернэт болон бусад сүлжээгээр дамжин байгууллагын мэдээллийн системд хандах эрсдэлийг авч үзсэн байх;	
2.3.2	Хэрэглэгчийн болон гүйлгээний мэдээлэлд хандаж байгаа бүх хандалтыг хянаж, бүртгэлжүүлэх тогтолцоог бий болгосон байх;	
2.3.3	Гүйлгээ хийх, нууц мэдээлэл дамжих үед тухайн мэдээллийг дамжуулах эхний цэгээс хүлээн авах эцсийн цэг хүртэл өндөр нууцлалтай шифрлэх, гүйлгээний бүх үе шатанд (шифрлэх, мэдээлэл дамжуулах, хадгалах) хэрэглэгчийн гүйлгээ үүсгэх, дансанд хандахад ашиглагдах нууц үг, түүнтэй адилтгах бусад мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангасан байх;	
2.3.4	Мэдээллийн технологийн үндсэн систем, техник, тоног төхөөрөмж (цаашид үндсэн төв гэх) гэмтэх, аливаа саатал гарах үед үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлэн хэвийн үргэлжлүүлэх хүчин чадал бүхий нөөц систем, мэдээллийн сан, дэд бүтэцтэй байх (цаашид нөөц төв гэх);	
2.3.5	Мэдээллийн технологийн нууцлал аюулгүй байдлын талаар авч хэрэгжүүлэх бодлого, журам, заавартай байх бөгөөд үүнд мэдээллийг шифрлэх, шифрлэсэн нууц мэдээллийг тайлж уншихтай холбогдсон түлхүүр, алгоритмыг зөвшөөрөлгүй этгээд олж мэдэхээс хэрхэн сэргийлэх, үндсэн төв болон нөөц төвийн сервер,	

	серверийн өрөөний аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар тусгасан байх;	
2.3.6	Нөөц төвийг үндсэн систем байршиж байгаа газар нутагт тохиолдож болох эрсдэлийг харгалзан үзэж, ижил эрсдэл зэрэг үүсэхээргүй зайд байршуулсан байх;	
2.3.7	Үндсэн төв болон нөөц төвийг шууд холбосон байх;	
2.3.8	Хүсэлт гаргагчийн үндсэн төвийг операторын үндсэн төвтэй үндсэн ба нөөц шугамаар шууд холбосон байх;	
2.3.9	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч, операторын нөөц төвүүдийг шууд холбосон байх;	
2.3.10	Үндсэн болон нөөц систем байршиж байгаа барилга байгууламжид агаарын чийгшил тохируулагч систем, гал унтраах систем, аваар осол мэдрэгч төхөөрөмж, тог баригч байршуулсан байхаас гадна цахилгааны нэмэлт эх үүсвэртэй холбосон байх;	
2.3.11	Энэ журмын 2.3.10-т заасан цахилгааны нэмэлт эх үүсвэрээр үйл ажиллагааг хамгийн багадаа 24 цаг явуулах боломжтой байх;	
2.3.12	Үндсэн болон нөөц системд хандах эрх бүхий ажилтнуудын тухайн системд хандан хийж болох үйлдэл, хандалтын эрхийн хязгаарлалт, хандалт бүрийг тухайн ажилтан тус бүрээр тодорхойлж, баримтжуулдаг байх;	
2.4	Монголбанкны ажиллуулж байгаа клирингийн систем, Монголбанкнаас систем ажиллуулах зөвшөөрөл авсан этгээд, тэдгээрийн оролцогчдын гэнэтийн саатлын хугацаа нэг сард тухайн системийн нийт ажиллах цагийн 0.1 хувиас илүүгүй, төлөвлөгөөт зогсолтын хугацаа нэг сард 4 цагаас илүүгүй байна.	
2.5	Зайлшгүй шаардлагаар үндсэн болон нөөц төвийн үйл ажиллагааг зэрэг хамарсан программ, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх тохиолдолд энэ журмын 2.4-т заасан төлөвлөгөөт зогсолтын хугацааг Монголбанканд албан бичгээр мэдэгдэж тохиролцсоны үндсэн дээр сунгаж болно.	
2.6	Төлбөрийн системийн үйл ажиллагаа 2 минутаас дээш хугацаагаар, төлөвлөгөөт бусаар хэсэгчлэн болон бүрэн зогсох нь гэнэтийн саатал байна.	
<u>Заалт</u>	<u>Гурав. Хүсэлт гаргагчид тавих нэмэлт шаардлага - Карт гаргах</u>	<u>Тайлбар</u>
3.2	Хүсэлт гаргагч нь энэ журмын 2.1 болон 2.3-2.5-т зааснаас гадна дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:	
3.2.1	Карт нь олон улсын EMV стандартын шаардлагыг хангасан байх;	
3.2.2	Карт нь карт хүлээн авах зөвшөөрөл бүхий бүх оролцогчийн ПОС төхөөрөмж дээр уншигдаж худалдан авалт, буцаалт, төрийн үйлчилгээний төлбөр, орон сууцны хэрэглээний төлбөрийн гүйлгээ хийх боломжтой байх;	

3.2.3	Карт нь карт хүлээн авах зөвшөөрөл бүхий бүх оролцогчийн АТМ, ПОБ төхөөрөмж дээр уншигдаж бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ, дансны үлдэгдэл шалгах гүйлгээ хийх боломжтой байх;	
3.2.4	Цахим худалдаа хийх буюу карт ашиглан интернэтээр бараа, ажил үйлчилгээний төлбөр төлөх, худалдан авалт хийх боломжтой байх;	
3.2.5	Карт гаргагч нь хэрэглэгчийн зан төлөв, хэрэглээнд суурилсан сэжигтэй гүйлгээг илрүүлэх чадамж бүхий программ хангамжтай байх;	
3.2.6	Ухаалаг гар утас болон бусад цахим төхөөрөмжид картын мэдээллийг суулгаж гүйлгээ үүсгэх тохиолдолд тухайн мэдээллийг олон улсын стандартын дагуу токенжуулдаг байх;	
3.2.7	₮ картыг Монголбанкнаас баталсан загвар, шаардлагын дагуу гаргах;	
3.2.8	₮ картын загвар дээрх холограмыг зөвхөн Монголбанк хэвлүүлж, карт гаргагч, картын бэлдэц нийлүүлэгч нарт хүргүүлнэ.	
<u>Заалт</u>	<u>Дөрөв. Зөвшөөрөл авах хүсэлт гаргах</u>	<u>Тайлбар</u>
4.1	Хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 11.1.12 болон 11.3.12-т заасан шаардлагын дагуу энэ журмын хавсралт 2-т заасан баримт бичгийг, хавсралт 1-т заасан өргөдлийн хамт Монголбанкны төлбөрийн систем хариуцсан нэгжид албан бичгээр өгнө.	
4.7	Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 33.1-т заасны дагуу хүсэлт гаргагч нь материал өгөхөөс өмнө зөвшөөрлийн материал хүлээж авах, хянах үйлчилгээний хураамжийг төлнө.	

Тайлбар: Төлбөрийн карт хүлээн авах хүсэлт гаргагч нь хууль, энэхүү журмаар тавигдах шаардлагыг хэрхэн хангасан тайлбарыг дараах хүснэгтэд заасан жагсаалтын дагуу зөвшөөрлийн материалын хамт ирүүлнэ. Тайлбар хэсэгт тухайн шаардлагыг өөрийн журам, заавар, холбогдох баримт бичгийн аль хэсэгт, ямар заалтаар хангаж байгааг тодорхой тэмдэглэсэн байна.

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль		
<u>Заалт</u>	<u>12 дугаар зүйл. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагчид тавих шаардлага</u>	<u>Тайлбар</u>
12.1	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч дараахь шаардлагыг хангасан байна:	
12.1.1	Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан;	
12.1.2	Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгө, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангасан;	
12.1.3	Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын зохистой тогтолцоо бүхий төлбөрийн үйлчилгээ үзүүлэх шаардлагыг хангахуйц	

	техникийн болон зохион байгуулалтын чадвартай;	
12.1.4	Хэрэглэгчээс, эсхүл бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээс төлбөр гүйцэтгэхийн тулд хүлээж авсан мөнгөн хөрөнгийг өөр зорилгоор ашиглах, гуравдагч этгээдийн мөнгөн хөрөнгөтэй нийлүүлэх зэргээс хамгаалсан, төлбөрийн чадваргүй болсон үед үйлчилгээ үзүүлэгчийн бусад үүрэг гүйцэтгүүлэгчийн нэхэмжлэлээс тусгаарлах боломж бүхий тогтолцоотой;	
12.1.5	Таван жилийн стратеги болон бизнес төлөвлөгөөтэй;	
12.1.6	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдлэг, туршлага, мэргэжлийн ёс зүй, мэргэшлийн ур чадвар бүхий хүний нөөцтэй;	
12.1.7	Тухайн системд зөвшөөрөгдсөн гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэхэд шаардлагатай төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг баталгаажуулах, зээлийн эрсдэлээс хамгаалсан;	
12.1.8	Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөлийг хангах.	
12.2	Монголбанк энэ хуулийн 12.1.2-т заасан өөрийн хөрөнгийн хэмжээ, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг доор дурдсан хүчин зүйлсийг харгалзан үзэж тогтоох ба зөвшөөрөл авч байгаа этгээдийн зөвшөөрлийн нөхцөлд тодорхой тусгана:	
12.2.1	Үзүүлэх төлбөрийн үйлчилгээний төрөл;	
12.2.2	Төлбөрийн дундаж дүн;	
12.2.3	Холбогдох бусад хүчин зүйлс.	
12.3	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдэд тавих нэмэлт шаардлагыг Монголбанкнаас баталсан журмаар тогтооно.	

Төлбөрийн системийн журам		
<u>Заалт</u>	<u>Хоёр. Зөвшөөрөл авах хүсэлт гаргагчид тавих шаардлага</u>	<u>Тайлбар</u>
2.1	Хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 12 дугаар зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:	
2.1.1	Хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.9-т заасан шууд бус оролцогч байх тохиолдолд төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий нэг банкиг өөрийн төлбөр тооцооны төлөөлөгчөөр сонгосон;	
2.1.2	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь клирингийн, эсхүл төлбөр тооцооны системийн оролцогч болохоос өмнө тухайн системийн оператортай техникийн хамтарсан туршилт хийж, хоёр талаас баталгаажуулсан;	

2.1.3	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь QR код ашиглан гүйлгээ дамжуулах, хүлээн авахдаа Монголбанкнаас баталсан QR кодын цахим мэдээний бүтэц, зааврыг мөрдөж ажилладаг байх;	
2.1.4	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу хэрэглэгчийг таньж мэдэх үйл ажиллагааг тодорхой тусгасан дотоод журам, заавар, хяналтын тогтолцоог бий болгосон;	
2.1.5	Гадаад болон дотоод хүчин зүйлээс шалтгаалж төлбөрийн үйлчилгээ тасалдах, осол, гэмтэл гарах үед үйл ажиллагааны найдвартай, тасралтгүй байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөтэй;	
2.1.6	Хэрэглэгч, мерчантын мөнгөн хөрөнгийг найдвартай хадгалах, хамгаалах, гүйлгээний нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангахуйц энэ журмын 2.3-т заасан шаардлагыг хангасан мэдээллийн технологийн дэд бүтэцтэй;	
2.1.7	Хэрэглэгчийн данснаас зарлагын гүйлгээ хийх бүрд тухайн гүйлгээний мэдээллийг үйлчилгээний төлбөргүйгээр мэдэгдэж байх боломжийг бүрдүүлсэн;	
2.1.8	Хэрэглэгчийн хийсэн аливаа гүйлгээний түүх, гүйлгээний үе шат бүрийн талаарх мэдээллийг гаргах боломж бүхий системтэй байх;	
2.1.9	Төлбөрийн үйлчилгээтэй холбоотойгоор хэрэглэгч, мерчант болон бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс гаргасан гомдол, санал, маргаантай гүйлгээг цаг тухайд нь хүлээн авч шийдвэрлэх, тэдгээрт лавлагаа мэдээлэл өгөх үйл ажиллагааны талаар тусгасан дотоод журам, заавартай байх;	
2.1.10	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос үүдэн төлбөрийн үйлчилгээг зогсоох үед хэрэглэгч, мерчантын авлагыг барагдуулахтай холбоотой авах арга хэмжээний талаар тусгасан журамтай байх;	
2.1.11	Хүсэлт гаргагч нь хэрэглэгчтэй байгуулах гэрээнд дараах зүйлсийг тусгана:	
2.1.11.1	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн мэдээллийг нууцлах, хадгалах, ашиглах тухай;	
2.1.11.2	Хэрэглэгч нь ПИН код буюу гүйлгээг баталгаажуулахад ашиглагдах, зөвхөн тухайн хэрэглэгч мэдэж байх тоо, үсэг, тэмдэгтийн дараалал, түүнтэй адилтгах бусад мэдээллийг нууцлах, түүнийг хаяж үрэгдүүлсэн, гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй гэж үзсэн	

	тохиолдолд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид нэн даруй мэдэгдэх тухай;	
2.1.11.3	Хэрэглэгч нь өөрийн данснаас түүний зөвшөөрөлгүй хийгдсэн аливаа шилжүүлэг болон бүртгэлийн алдаа, зөрчил дутагдлыг илрүүлсэн тохиолдолд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид нэн даруй мэдэгдэх тухай;	
2.1.11.4	Хэрэглэгчийг таньж баталгаажуулах арга, хэрэгсэл болон баталгаажуулсан гэж үзэх нөхцөл;	
2.1.11.5	Хэрэглэгч тухайн гүйлгээг илгээхийг зөвшөөрсөн, баталгаажуулсан гэж үзэх нөхцөл;	
2.1.11.6	Хэрэглэгч гомдол, маргаан үүсгэх нөхцөл, шийдвэрлэх арга зам, хугацаа;	
2.1.11.7	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос үүдэн төлбөрийн үйлчилгээг зогсоох үед хэрэглэгчийн авлагыг барагдуулахтай холбоотой авах арга хэмжээ, эрх, үүрэг.	
2.1.12	Хүсэлт гаргагч нь мерчанттай байгуулах гэрээнд дараах зүйлсийг тусгана:	
2.1.12.1	Монголбанкны зөвшөөрөлтэй төлбөрийн хэрэгслийг бараа, ажил, үйлчилгээний төлбөрт хүлээн авах тухай;	
2.1.12.2	Төрийн үйлчилгээний төлбөр, орон сууцны хэрэглээний төлбөр төлөхөөс бусад картын гүйлгээ хийх тохиолдолд мерчант нь карт эзэмшигчээс шимтгэл авахгүй байх тухай;	
2.1.12.3	Мерчант нь Монгол Улсын нутаг дэвсгэрт төлбөр хүлээн авах тухай;	
2.1.12.4	Мерчантаас гомдол, маргаан үүсгэх нөхцөл, шийдвэрлэх арга зам, хугацаа;	
2.1.12.5	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос үүдэн төлбөрийн үйлчилгээг зогсоох үед мерчантын авлагыг барагдуулахтай холбоотой авах арга хэмжээ, эрх, үүрэг.	
2.1.13	Хүсэлт гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байх;	
2.1.14	Хүсэлт гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өрийн үлдэгдэлгүй, шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй байх;	

2.1.15	Монголбанкнаас тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бүрдүүлсэн байх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгө нь гуравдагч этгээдийн шаардлагаас ангид, тухайн этгээдийн санхүүгийн тайлан, татвар төлөлтийн тайлангаар батлагдсан хууль ёсны үйл ажиллагааны орлого байна.	
<u>Заалт</u>	<u>Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагчийн мэдээллийн аюулгүй байдалд тавигдах нийтлэг шаардлага</u>	<u>Тайлбар</u>
2.3	Хүсэлт гаргагч нь мэдээллийн технологи, тасралтгүй ажиллагаанд дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:	
2.3.1	Дотоод сүлжээ, вэбсайт, сервер, бусад тоног төхөөрөмж рүү гаднаас халдах боломжгүй байх нөхцөлийг бүрдүүлж, байгууллагын мэдээллийн системийг аливаа сэжиг бүхий, эсхүл зөвшөөрөгдөөгүй хандалтаас хамгаалах галт хана суурилуулсан байх бөгөөд энэ нь интернэт болон бусад сүлжээгээр дамжин байгууллагын мэдээллийн системд хандах эрсдэлийг авч үзсэн байх;	
2.3.2	Хэрэглэгчийн болон гүйлгээний мэдээлэлд хандаж байгаа бүх хандалтыг хянаж, бүртгэлжүүлэх тогтолцоог бий болгосон байх;	
2.3.3	Гүйлгээ хийх, нууц мэдээлэл дамжих үед тухайн мэдээллийг дамжуулах эхний цэгээс хүлээн авах эцсийн цэг хүртэл өндөр нууцлалтай шифрлэх, гүйлгээний бүх үе шатанд (шифрлэх, мэдээлэл дамжуулах, хадгалах) хэрэглэгчийн гүйлгээ үүсгэх, дансанд хандахад ашиглагдах нууц үг, түүнтэй адилтгах бусад мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангасан байх;	
2.3.4	Мэдээллийн технологийн үндсэн систем, техник, тоног төхөөрөмж (цаашид үндсэн төв гэх) гэмтэх, аливаа саатал гарах үед үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлэн хэвийн үргэлжлүүлэх хүчин чадал бүхий нөөц систем, мэдээллийн сан, дэд бүтэцтэй байх (цаашид нөөц төв гэх);	
2.3.5	Мэдээллийн технологийн нууцлал аюулгүй байдлын талаар авч хэрэгжүүлэх бодлого, журам, заавартай байх бөгөөд үүнд мэдээллийг шифрлэх, шифрлэсэн нууц мэдээллийг тайлж уншихтай холбогдсон түлхүүр, алгоритмыг зөвшөөрөлгүй этгээд олж мэдэхээс хэрхэн сэргийлэх, үндсэн төв болон нөөц төвийн сервер, серверийн өрөөний аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар тусгасан байх;	
2.3.6	Нөөц төвийг үндсэн систем байршиж байгаа газар нутагт тохиолдож болох эрсдэлийг	

	харгалзан үзэж, ижил эрсдэл зэрэг үүсэхээргүй зайд байршуулсан байх;	
2.3.7	Үндсэн төв болон нөөц төвийг шууд холбосон байх;	
2.3.8	Хүсэлт гаргагчийн үндсэн төвийг операторын үндсэн төвтэй үндсэн ба нөөц шугамаар шууд холбосон байх;	
2.3.9	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч, операторын нөөц төвүүдийг шууд холбосон байх;	
2.3.10	Үндсэн болон нөөц систем байршиж байгаа барилга байгууламжид агаарын чийгшил тохируулагч систем, гал унтраах систем, аваар осол мэдрэгч төхөөрөмж, тог баригч байршуулсан байхаас гадна цахилгааны нэмэлт эх үүсвэртэй холбосон байх;	
2.3.11	Энэ журмын 2.3.10-т заасан цахилгааны нэмэлт эх үүсвэрээр үйл ажиллагааг хамгийн багадаа 24 цаг явуулах боломжтой байх;	
2.3.12	Үндсэн болон нөөц системд хандах эрх бүхий ажилтнуудын тухайн системд хандан хийж болох үйлдэл, хандалтын эрхийн хязгаарлалт, хандалт бүрийг тухайн ажилтан тус бүрээр тодорхойлж, баримтжуулдаг байх;	
2.4	Монголбанкны ажиллуулж байгаа клирингийн систем, Монголбанкнаас систем ажиллуулах зөвшөөрөл авсан этгээд, тэдгээрийн оролцогчдын гэнэтийн саатлын хугацаа нэг сард тухайн системийн нийт ажиллах цагийн 0.1 хувиас илүүгүй, төлөвлөгөөт зогсолтын хугацаа нэг сард 4 цагаас илүүгүй байна.	
2.5	Зайлшгүй шаардлагаар үндсэн болон нөөц төвийн үйл ажиллагааг зэрэг хамарсан программ, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх тохиолдолд энэ журмын 2.4-т заасан төлөвлөгөөт зогсолтын хугацааг Монголбанканд албан бичгээр мэдэгдэж тохиролцсоны үндсэн дээр сунгаж болно.	
2.6	Төлбөрийн системийн үйл ажиллагаа 2 минутаас дээш хугацаагаар, төлөвлөгөөт бусаар хэсэгчлэн болон бүрэн зогсох нь гэнэтийн саатал байна.	
<u>Заалт</u>	<u>Гурав. Хүсэлт гаргагчид тавих нэмэлт шаардлага - Карт хүлээн авах</u>	<u>Тайлбар</u>
3.3	Хүсэлт гаргагч нь энэ журмын 2.1 болон 2.3-2.5-т зааснаас гадна дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:	
3.3.1	ПОС төхөөрөмжөөр карт хүлээн авах тохиолдолд олон улсын “EMV (contact level 1, level 2 type approval) стандарт”-ын сертификат бүхий ПОС төхөөрөмжтэй байх;	

3.3.2	ПОС төхөөрөмжөөр карт хүлээн авах тохиолдолд карт гаргах зөвшөөрөлтэй бүх оролцогчийн гаргасан картыг өөрийн ПОС төхөөрөмж дээр хүлээн авч, худалдан авалт болон буцаалтын гүйлгээ хийх боломжтой байхаас гадна бүх төрлийн баталгаажуулалттай картын гүйлгээг хүлээн авах чадамжтай байх;	
3.3.3	АТМ, ПОБ төхөөрөмжөөр карт хүлээн авах тохиолдолд карт гаргах зөвшөөрөлтэй бүх оролцогчийн гаргасан биет картыг өөрийн АТМ, ПОБ төхөөрөмж дээр хүлээн авч, бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ, дансны үлдэгдэл шалгах гүйлгээ хийх боломжтой байх;	
3.3.4	Цахим худалдааны гүйлгээг хүлээн авах тохиолдолд карт гаргах зөвшөөрөлтэй бүх оролцогчийн картыг хүлээн авч, цахим худалдааны гүйлгээ хийх боломжтой байх;	
3.3.5	АТМ болон хэрэглэгч өөртөө үйлчилж, гүйлгээ үүсгэх боломж бүхий цахим мэдээ үүсгэгч төхөөрөмж байршиж байгаа газарт хэрэглэгчийн нүүр царай харагдахуйц хяналтын камер суурилуулсан байх;	
3.3.6	Картын систем нь ухаалаг гар утас болон бусад цахим төхөөрөмжид суурилсан, олон улсын стандартын дагуу токеноор орлуулсан картын мэдээлэл бүхий гүйлгээг хүлээн авч, дамжуулах боломжтой байх.	
<u>Заалт</u>	<u>Дөрөв. Зөвшөөрөл авах хүсэлт гаргах</u>	<u>Тайлбар</u>
4.1	Хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 11.1.12 болон 11.3.12-т заасан шаардлагын дагуу энэ журмын хавсралт 2-т заасан баримт бичгийг, хавсралт 1-т заасан өргөдлийн хамт Монголбанкны төлбөрийн систем хариуцсан нэгжид албан бичгээр өгнө.	
4.7	Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 33.1-т заасны дагуу хүсэлт гаргагч нь материал өгөхөөс өмнө зөвшөөрлийн материал хүлээж авах, хянах үйлчилгээний хураамжийг төлнө.	

**АУТСОРСИНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН
ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Ирүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Аутсорсингоор гүйцэтгүүлэх үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлбар, хавсралт 1-т заасан өргөдөл	
2	Аутсорсингийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын мэдээлэл (системийн үйл ажиллагаа, нууцлал аюулгүй байдал, хүний нөөцийн танилцуулга, байгууллагын бүтэц зохион байгуулалтын талаарх мэдээлэл)	
3	Аутсорсингийн үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулах гэрээний хувь, эсхүл баталгаажсан загвар	
4	“Зөвшөөрлийн хураамжийн ерөнхий нөхцөл”-д заасан зөвшөөрлийн материал хүлээн авах хураамжийг төлсөн баримт	

Тайлбар: Аутсорсингийн үйлчилгээ авах хүсэлт гаргагч нь хууль, энэхүү журмаар тавигдах шаардлагыг хэрхэн хангасан тайлбарыг дараах хүснэгтэд заасан жагсаалтын дагуу зөвшөөрлийн материалын хамт ирүүлнэ. Тайлбар хэсэгт тухайн шаардлагыг өөрийн журам, заавар, холбогдох баримт бичгийн аль хэсэгт, ямар заалтаар хангаж байгааг тодорхой тэмдэглэсэн байна.

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль		
Заалт	12 дугаар зүйл. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагчид тавих шаардлага	Тайлбар
12.1	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч дараахь шаардлагыг хангасан байна:	
12.1.1	Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан;	
12.1.2	Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгө, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангасан;	
12.1.3	Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын зохистой тогтолцоо бүхий төлбөрийн үйлчилгээ үзүүлэх шаардлагыг хангахуйц техникийн болон зохион байгуулалтын чадвартай;	
12.1.4	Хэрэглэгчээс, эсхүл бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээс төлбөр гүйцэтгэхийн тулд хүлээж авсан мөнгөн хөрөнгийг өөр зорилгоор ашиглах, гуравдагч этгээдийн мөнгөн хөрөнгөтэй нийлүүлэх зэргээс хамгаалсан, төлбөрийн чадваргүй болсон үед үйлчилгээ үзүүлэгчийн бусад үүрэг гүйцэтгүүлэгчийн нэхэмжлэлээс тусгаарлах боломж бүхий тогтолцоотой;	
12.1.5	Таван жилийн стратеги болон бизнес төлөвлөгөөтэй;	

12.1.6	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдлэг, туршлага, мэргэжлийн ёс зүй, мэргэшлийн ур чадвар бүхий хүний нөөцтэй;	
12.1.7	Тухайн системд зөвшөөрөгдсөн гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэхэд шаардлагатай төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг баталгаажуулах, зээлийн эрсдэлээс хамгаалсан;	
12.1.8	Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөлийг хангах.	
12.2	Монголбанк энэ хуулийн 12.1.2-т заасан өөрийн хөрөнгийн хэмжээ, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг доор дурдсан хүчин зүйлсийг харгалзан үзэж тогтоох ба зөвшөөрөл авч байгаа этгээдийн зөвшөөрлийн нөхцөлд тодорхой тусгана:	
12.2.1	Үзүүлэх төлбөрийн үйлчилгээний төрөл;	
12.2.2	Төлбөрийн дундаж дүн;	
12.2.3	Холбогдох бусад хүчин зүйлс.	
12.3	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдэд тавих нэмэлт шаардлагыг Монголбанкнаас баталсан журмаар тогтооно.	
<u>Заалт</u>	<u>21 дүгээр зүйл. Аутсорсингийн үйлчилгээ авах</u>	<u>Тайлбар</u>
21.1	Оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь Монголбанкны зөвшөөрлөөр аутсорсингийн үйлчилгээ авна. Аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа Монголбанкнаас шаардсан тухайн үйлчилгээнд хамаарах мэдээллийг гаргаж өгнө.	
21.2	Монголбанк энэ хуулийн 21.1-д заасан хүсэлт, мэдээллийг хянаж, дараахь үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй гэж үзвэл аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ:	
21.2.1	Оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдийн дотоод хяналт;	
21.2.2	Оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд энэ хуульд заасан шаардлага хангаж байгаа эсэхэд тавих Монголбанкны хяналт;	
21.2.3	Хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай байдал.	
21.3	Оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь онцгой ач холбогдол бүхий үйл ажиллагааны аутсорсингийн үйлчилгээ авах тохиолдолд Монголбанк дараахь шаардлагыг тавина:	
21.3.1	Аутсорсингийн үйлчилгээ авснаар удирдлагын үүрэг, хариуцлага шилжихгүй байх;	
21.3.2	Хэрэглэгчийн өмнө хүлээсэн төлбөрийн хэрэгсэл гаргагчийн үүрэг, хариуцлага, тэдгээрийн хоорондын харилцаанд нөлөөлөхгүй байх;	

21.3.3	Оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд энэ хуульд заасан шаардлагыг тогтмол хангаж ажиллах;	
21.3.4	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, төлбөрийн хэрэгсэл гаргах болон систем ажилуулах зөвшөөрөл олгосон үндэслэл, нөхцөлийг өөрчлөхгүй байх.	
21.4	Доголдол, саатал нь оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч болон төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдийн зөвшөөрлийн нөхцөл, санхүүгийн үзүүлэлт, үйлчилгээний тасралтгүй, найдвартай байдалд тавигдах шалгуур үзүүлэлтэд үлэмж хэмжээгээр нөлөөлөхөөр бол тухайн үйл ажиллагааг онцгой ач холбогдол бүхий гэж тооцно.	

Төлбөрийн системийн журам		
<u>Заалт</u>	<u>Гурав. Хүсэлт гаргагчид тавих нэмэлт шаардлага-Аутсорсингийн үйлчилгээ авах</u>	<u>Тайлбар</u>
3.6	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь гүйлгээ дамжуулах, хүлээн авах, боловсруулах, гүйлгээний нууцлал, аюулгүй байдал, мэдээллийн сангийн үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх буюу аутсорсингийн үйлчилгээ авах тохиолдолд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамтран ажиллана.	
3.7	Оператор нь аутсорсингийн үйлчилгээ авах тохиолдолд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамтран ажиллана.	
3.8	Монголбанк нь тухайн этгээдэд аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэхдээ дараах нөхцөлийг гэрээнд тусгасан байхыг шаардана:	
3.8.1	Хүсэлт гаргагч нь аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээдэд энэ журамд заасан мэдээллийн аюулгүй байдлын холбогдох шаардлагыг тавьж, хэрэгжилтийг хянадаг байх, шаардлагатай мэдээлэлд цаг алдалгүй хандах боломжтой байх тухай;	
3.8.2	Хүсэлт гаргагч болон хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, төлбөрийн үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай байдал алдагдахгүй байх тухай;	
3.8.3	Хүсэлт гаргагчийн удирдлагын үүрэг хариуцлага шилжихгүй байх тухай;	
3.8.4	Хүсэлт гаргагчийн хэрэглэгчийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлага, тэдгээрийн хоорондын харилцаанд нөлөөлөхгүй байх тухай;	
3.9	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, оператор нь аутсорсингийн үйлчилгээ авснаар энэ журмын нөхцөл, шаардлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.	
3.10	Хүсэлт гаргагч нь аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээдийн найдвартай ажиллагаа, мэдээллийн технологийн нууцлал, аюулгүй байдал болон	

аутсорсингоор дамжуулан үзүүлсэн төлбөрийн үйлчилгээний хариуцлагыг хүлээнэ.
--

Хавсралт 3. Аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрөл авах хүсэлт гаргагчийн ирүүлэх баримт бичгийн жагсаалт		
<u>№</u>	<u>Ирүүлэх баримт бичгийн жагсаалт</u>	<u>Хуудасны тоо</u>
1	Аутсорсингоор гүйцэтгүүлэх үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлбар, хавсралт 1-т заасан өргөдөл;	
2	Аутсорсингийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын мэдээлэл (системийн үйл ажиллагаа, нууцлал аюулгүй байдал, хүний нөөцийн танилцуулга, байгууллагын бүтэц зохион байгуулалтын талаарх мэдээлэл);	
3	Аутсорсингийн үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулах гэрээний хувь, эсхүл баталгаажсан загвар	
4	“Монголбанкны үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасан зөвшөөрлийн материал хүлээн авах хураамжийг төлсөн баримт	

Хавсралт 4

ТӨЛБӨР ТООЦООНЫ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

<u>№</u>	<u>Ирүүлэх баримт бичгийн жагсаалт</u>	<u>Хуудасны тоо</u>
1	Энэ журмын хавсралт 1-т заасан өргөдөл	
2	Шууд бус оролцогчтой байгуулах гэрээний загвар	
3	Шууд бус оролцогчийн төлбөр тооцоог дамжуулах үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлбар, схем, зураглал	
4	“Зөвшөөрлийн хураамжийн ерөнхий нөхцөл”-д заасан зөвшөөрлийн материал хүлээн авах хураамжийг төлсөн баримт	

Тайлбар: Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх хүсэлт гаргагч нь хууль, энэхүү журмаар тавигдах шаардлагыг хэрхэн хангасан тайлбарыг дараах хүснэгтэд заасан жагсаалтын дагуу зөвшөөрлийн материалын хамт ирүүлнэ. Тайлбар хэсэгт тухайн шаардлагыг өөрийн журам, заавар, холбогдох баримт бичгийн аль хэсэгт, ямар заалтаар хангаж байгааг тодорхой тэмдэглэсэн байна.

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль		
<u>Заалт</u>	<u>12 дугаар зүйл. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагчид тавих шаардлага</u>	<u>Тайлбар</u>
12.1	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч дараахь шаардлагыг хангасан байна:	

12.1.1	Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан;	
12.1.2	Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгө, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангасан;	
12.1.3	Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын зохистой тогтолцоо бүхий төлбөрийн үйлчилгээ үзүүлэх шаардлагыг хангахуйц техникийн болон зохион байгуулалтын чадвартай;	
12.1.4	Хэрэглэгчээс, эсхүл бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээс төлбөр гүйцэтгэхийн тулд хүлээж авсан мөнгөн хөрөнгийг өөр зорилгоор ашиглах, гуравдагч этгээдийн мөнгөн хөрөнгөтэй нийлүүлэх зэргээс хамгаалсан, төлбөрийн чадваргүй болсон үед үйлчилгээ үзүүлэгчийн бусад үүрэг гүйцэтгүүлэгчийн нэхэмжлэлээс тусгаарлах боломж бүхий тогтолцоотой;	
12.1.5	Таван жилийн стратеги болон бизнес төлөвлөгөөтэй;	-
12.1.6	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдлэг, туршлага, мэргэжлийн ёс зүй, мэргэшлийн ур чадвар бүхий хүний нөөцтэй;	
12.1.7	Тухайн системд зөвшөөрөгдсөн гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэхэд шаардлагатай төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг баталгаажуулах, зээлийн эрсдэлээс хамгаалсан;	
12.1.8	Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөлийг хангах.	
12.2	Монголбанк энэ хуулийн 12.1.2-т заасан өөрийн хөрөнгийн хэмжээ, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг доор дурдсан хүчин зүйлсийг харгалзан үзэж тогтоох ба зөвшөөрөл авч байгаа этгээдийн зөвшөөрлийн нөхцөлд тодорхой тусгана:	
12.2.1	Үзүүлэх төлбөрийн үйлчилгээний төрөл;	
12.2.2	Төлбөрийн дундаж дүн;	
12.2.3	Холбогдох бусад хүчин зүйлс.	
12.3	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдэд тавих нэмэлт шаардлагыг Монголбанкнаас баталсан журмаар тогтооно.	

Төлбөрийн системийн журам		
<u>Заалт</u>	<u>Гурав. Хүсэлт гаргагчид тавих нэмэлт шаардлага- Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх хүсэлт гаргах</u>	<u>Тайлбар</u>
3.1	Төлбөр тооцооны төлөөлөгч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 36.5-т заасны дагуу дараах шаардлагыг хангасан байна:	
3.1.1	Монголбанкнаас олгосон банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх;	

3.1.2	Сүүлийн хоёр жилийн хугацаанд Банксүлжээ систем дэх клирингийн системийн үр дүнгийн төлбөр тооцоог цаг тухайд нь найдвартай гүйцэтгэж, заавал байлгах нөөцийн шаардлагыг бүрэн хангасан байх;	
3.1.3	Шууд бус оролцогчийн төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэх зорилгоор Монголбанкна дахь өөрийн харилцах дансны мөнгөн хөрөнгөөс тодорхой дүнг нөөцлөх буюу тусгаарлахыг зөвшөөрсөн.	

Хавсралт 4. Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрөл авах хүсэлт гаргагчийн ирүүлэх баримт бичгийн жагсаалт		
<u>№</u>	<u>Ирүүлэх баримт бичгийн жагсаалт</u>	<u>Хуудасны тоо</u>
1	Энэ журмын хавсралт 1-т заасан өргөдөл	
2	Шууд бус оролцогчтой байгуулах гэрээний загвар	
3	Шууд бус оролцогчийн төлбөр тооцоог дамжуулах үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлбар, схем, зураглал	
4	“Монголбанкны үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасан зөвшөөрлийн материал хүлээн авах хураамжийг төлсөн баримт	

Хавсралт 5

**ГЭРЭЭТ ТӨЛӨӨЛӨГЧӨӨР ДАМЖУУЛАН ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭХ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ**

<u>№</u>	<u>Ирүүлэх баримт бичгийн жагсаалт</u>	<u>Хуудасны тоо</u>
1	Энэ журмын хавсралт 1-т заасан өргөдөл	
2	Гэрээт төлөөлөгчөөр дамжуулан үзүүлэх төлбөрийн үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээлэл, үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон хүсэлт	
3	Гэрээт төлөөлөгчийн үйл ажиллагааны болон мэдээллийн технологийн нууцлал, аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын баримт бичиг	
4	Гэрээт төлөөлөгчтэй байгуулах гэрээний хувь, эсхүл баталгаажсан загвар	
5	“Зөвшөөрлийн хураамжийн ерөнхий нөхцөл”-д заасан зөвшөөрлийн материал хүлээн авах хураамжийг төлсөн баримт	

Тайлбар: Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх хүсэлт гаргагч нь хууль, энэхүү журмааг тавигдах шаардлагыг хэрхэн хангасан тайлбарыг дараах хүснэгтэд заасан жагсаалтын дагуу зөвшөөрлийн материалын хамт ирүүлнэ. Тайлбар хэсэгт тухайн шаардлагыг өөрийн журам, заавар, холбогдох баримт бичгийн аль хэсэгт, ямар заалтаар хангаж байгааг тодорхой тэмдэглэсэн байна.

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль		
<i>Заалт</i>	<i><u>11 дүгээр зүйл. Зөвшөөрөл авах хүсэлт гаргах</u></i>	<i>Тайлбар</i>
11.1.	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргагч дараахь баримт бичгийг Монголбанканд ирүүлнэ:	
11.1.1	Улсын бүртгэлийн гэрчилгээ, эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл; (Улсын бүртгэлийн гэрчилгээ болон компаний дүрэм нотариатаар батлуулсан байх)	
11.1.2	Үзүүлэх төлбөрийн үйлчилгээний талаархи танилцуулга, холбогдох баримт бичиг;	
11.1.3	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэхэд ашиглах хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр, гарал үүслийг нотлох баримт бичиг;	
11.1.4	Төлбөрийн үйлчилгээг зохистой, найдвартай, тогтвортой үзүүлэхэд шаардлагатай систем, нөөцтэй, тэдгээрийг ашиглах чадвартайг нотолсон баримт бичиг, төлбөрийн үйлчилгээ үзүүлэх эхний таван жилийн бизнес төлөвлөгөө, дүрэм, журам;	
11.1.5	Хэрэглэгчийн мөнгөн хөрөнгийг хамгаалахын тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай баримт бичиг;	
11.1.6	Зохистой засаглал, эрсдэлийн удирдлага, нягтлан бодох бүртгэлийн аргачлал бүхий удирдлага зохион байгуулалт, дотоод хяналт зэргийг зохицуулсан баримт бичиг;	
11.1.7	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын тогтолцоо бүрдүүлснийг нотлох баримт бичиг;	
11.1.8	Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, шаардлагатай тохиолдолд гэрээт төлөөлөгч, аутсорсингийн үйлчилгээ авах тухай шийдвэр, үндэсний, эсхүл олон улсын төлбөрийн системд оролцохтой холбогдох баримт бичиг;	
11.1.9	Хүсэлт гаргагчтай холбогдох этгээдийн мэдээлэл;	
11.1.10	Удирдлагын болон төлбөрийн үйлчилгээг хариуцах нэгжийн удирдах ажилтны мэдээлэл;	
11.1.11	Үйлчилгээний хөлс төлсөн баримт;	
11.1.12	Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл	

<u>Заалт</u>	<u>12 дугаар зүйл. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагчид тавих шаардлага</u>	<u>Тайлбар</u>
12.1	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч дараахь шаардлагыг хангасан байна:	
12.1.1	Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан;	
12.1.2	Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгө, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангасан;	
12.1.3	Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын зохистой тогтолцоо бүхий төлбөрийн үйлчилгээ үзүүлэх шаардлагыг хангахуйц техникийн болон зохион байгуулалтын чадвартай;	
12.1.4	Хэрэглэгчээс, эсхүл бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээс төлбөр гүйцэтгэхийн тулд хүлээж авсан мөнгөн хөрөнгийг өөр зорилгоор ашиглах, гуравдагч этгээдийн мөнгөн хөрөнгөтэй нийлүүлэх зэргээс хамгаалсан, төлбөрийн чадваргүй болсон үед үйлчилгээ үзүүлэгчийн бусад үүрэг гүйцэтгүүлэгчийн нэхэмжлэлээс тусгаарлах боломж бүхий тогтолцоотой;	
12.1.5	Таван жилийн стратеги болон бизнес төлөвлөгөөтэй;	
12.1.6	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдлэг, туршлага, мэргэжлийн ёс зүй, мэргэшлийн ур чадвар бүхий хүний нөөцтэй;	
12.1.7	Тухайн системд зөвшөөрөгдсөн гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэхэд шаардлагатай төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг баталгаажуулах, зээлийн эрсдэлээс хамгаалсан;	
12.1.8	Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөлийг хангах.	
12.2	Монголбанк энэ хуулийн 12.1.2-т заасан өөрийн хөрөнгийн хэмжээ, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг доор дурдсан хүчин зүйлсийг харгалзан үзэж тогтоох ба зөвшөөрөл авч байгаа этгээдийн зөвшөөрлийн нөхцөлд тодорхой тусгана:	
12.2.1	Үзүүлэх төлбөрийн үйлчилгээний төрөл;	
12.2.2	Төлбөрийн дундаж дүн;	
12.2.3	Холбогдох бусад хүчин зүйлс.	
12.3	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдэд тавих нэмэлт шаардлагыг Монголбанкнаас баталсан журмаар тогтооно.	
<u>Заалт</u>	<u>34 дүгээр зүйл. Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлгийн хэрэгжилт, нотолгоо</u>	<u>Тайлбар</u>
34.1	Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлгийн бүртгэлийн бичилтийг холбогдох хууль, Монголбанкнаас баталсан журмын дагуу гүйцэтгэнэ.	
34.2	Монголбанк цахим мэдээний дагуу хийгдсэн мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг, төлбөрийн даалгавартай	

	холбогдох харилцааг зохицуулах журам, заавар баталж, шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	
--	--	--

Төлбөрийн системийн журам		
<u>Заалт</u>	<u>Хоёр. Зөвшөөрөл авах хүсэлт гаргагчид тавих шаардлага</u>	<u>Тайлбар</u>
2.1	Хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 12 дугаар зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:	
2.1.1	Хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.9-т заасан шууд бус оролцогч байх тохиолдолд төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий нэг банкныг өөрийн төлбөр тооцооны төлөөлөгчөөр сонгосон;	
2.1.2	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь клирингийн, эсхүл төлбөр тооцооны системийн оролцогч болохоос өмнө тухайн системийн оператортай техникийн хамтарсан туршилт хийж, хоёр талаас баталгаажуулсан;	
2.1.3	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь QR код ашиглан гүйлгээ дамжуулах, хүлээн авахдаа Монголбанкнаас баталсан QR кодын цахим мэдээний бүтэц, зааврыг мөрдөж ажилладаг байх;	
2.1.4	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу хэрэглэгчийг таньж мэдэх үйл ажиллагааг тодорхой тусгасан дотоод журам, заавар, хяналтын тогтолцоог бий болгосон;	
2.1.5	Гадаад болон дотоод хүчин зүйлээс шалтгаалж төлбөрийн үйлчилгээ тасалдах, осол, гэмтэл гарах үед үйл ажиллагааны найдвартай, тасралтгүй байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөтэй;	
2.1.6	Хэрэглэгч, мерчантын мөнгөн хөрөнгийг найдвартай хадгалах, хамгаалах, гүйлгээний нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангахуйц энэ журмын 2.3-т заасан шаардлагыг хангасан мэдээллийн технологийн дэд бүтэцтэй;	
2.1.7	Хэрэглэгчийн данснаас зарлагын гүйлгээ хийх бүрд тухайн гүйлгээний мэдээллийг үйлчилгээний төлбөргүйгээр мэдэгдэж байх боломжийг бүрдүүлсэн;	
2.1.8	Хэрэглэгчийн хийсэн аливаа гүйлгээний түүх, гүйлгээний үе шат бүрийн талаарх мэдээллийг гаргах боломж бүхий системтэй байх;	
2.1.9	Төлбөрийн үйлчилгээтэй холбоотойгоор хэрэглэгч, мерчант болон бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс гаргасан гомдол, санал, маргаантай гүйлгээг цаг тухайд нь хүлээн авч шийдвэрлэх, тэдгээрт лавлагаа мэдээлэл өгөх үйл ажиллагааны талаар тусгасан дотоод журам, заавартай байх;	

2.1.10	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос үүдэн төлбөрийн үйлчилгээг зогсоох үед хэрэглэгч, мерчантын авлагыг барагдуулахтай холбоотой авах арга хэмжээний талаар тусгасан журамтай байх;	
2.1.11	Хүсэлт гаргагч нь хэрэглэгчтэй байгуулах гэрээнд дараах зүйлсийг тусгана:	
2.1.11.1	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн мэдээллийг нууцлах, хадгалах, ашиглах тухай;	
2.1.11.2	Хэрэглэгч нь ПИН код буюу гүйлгээг баталгаажуулахад ашиглагдах, зөвхөн тухайн хэрэглэгч мэдэж байх тоо, үсэг, тэмдэгтийн дараалал, түүнтэй адилтгах бусад мэдээллийг нууцлах, түүнийг хаяж үрэгдүүлсэн, гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид нэн даруй мэдэгдэх тухай;	
2.1.11.3	Хэрэглэгч нь өөрийн данснаас түүний зөвшөөрөлгүй хийгдсэн аливаа шилжүүлэг болон бүртгэлийн алдаа, зөрчил дутагдлыг илрүүлсэн тохиолдолд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид нэн даруй мэдэгдэх тухай;	
2.1.11.4	Хэрэглэгчийг таньж баталгаажуулах арга, хэрэгсэл болон баталгаажуулсан гэж үзэх нөхцөл;	
2.1.11.5	Хэрэглэгч тухайн гүйлгээг илгээхийг зөвшөөрсөн, баталгаажуулсан гэж үзэх нөхцөл;	
2.1.11.6	Хэрэглэгч гомдол, маргаан үүсгэх нөхцөл, шийдвэрлэх арга зам, хугацаа;	
2.1.11.7	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос үүдэн төлбөрийн үйлчилгээг зогсоох үед хэрэглэгчийн авлагыг барагдуулахтай холбоотой авах арга хэмжээ, эрх, үүрэг.	
2.1.12	Хүсэлт гаргагч нь мерчанттай байгуулах гэрээнд дараах зүйлсийг тусгана:	
2.1.12.1	Монголбанкны зөвшөөрөлтэй төлбөрийн хэрэгслийг бараа, ажил, үйлчилгээний төлбөрт хүлээн авах тухай;	
2.1.12.2	Төрийн үйлчилгээний төлбөр, орон сууцны хэрэглээний төлбөр төлөхөөс бусад картын гүйлгээ хийх тохиолдолд мерчант нь карт эзэмшигчээс шимтгэл авахгүй байх тухай;	
2.1.12.3	Мерчант нь Монгол Улсын нутаг дэвсгэрт төлбөр хүлээн авах тухай;	
2.1.12.4	Мерчантаас гомдол, маргаан үүсгэх нөхцөл, шийдвэрлэх арга зам, хугацаа;	
2.1.12.5	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос үүдэн төлбөрийн үйлчилгээг зогсоох үед мерчантын авлагыг барагдуулахтай холбоотой авах арга хэмжээ, эрх, үүрэг.	

2.1.13	Хүсэлт гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байх;	
2.1.14	Хүсэлт гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өрийн үлдэгдэлгүй, шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй байх;	
2.1.15	Монголбанкнаас тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бүрдүүлсэн байх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгө нь гуравдагч этгээдийн шаардлагаас ангид, тухайн этгээдийн санхүүгийн тайлан, татвар төлөлтийн тайлангаар батлагдсан хууль ёсны үйл ажиллагааны орлого байна.	
<u>Заалт</u>	<u>Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагчийн мэдээллийн аюулгүй байдалд тавигдах нийтлэг шаардлага</u>	<u>Тайлбар</u>
2.3	Хүсэлт гаргагч нь мэдээллийн технологи, тасралтгүй ажиллагаанд дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:	
2.3.1	Дотоод сүлжээ, вэбсайт, сервер, бусад тоног төхөөрөмж рүү гаднаас халдах боломжгүй байх нөхцөлийг бүрдүүлж, байгууллагын мэдээллийн системийг аливаа сэжиг бүхий, эсхүл зөвшөөрөгдөөгүй хандалтаас хамгаалах галт хана суурилуулсан байх бөгөөд энэ нь интернэт болон бусад сүлжээгээр дамжин байгууллагын мэдээллийн системд хандах эрсдэлийг авч үзсэн байх;	
2.3.2	Хэрэглэгчийн болон гүйлгээний мэдээлэлд хандаж байгаа бүх хандалтыг хянаж, бүртгэлжүүлэх тогтолцоог бий болгосон байх;	
2.3.3	Гүйлгээ хийх, нууц мэдээлэл дамжих үед тухайн мэдээллийг дамжуулах эхний цэгээс хүлээн авах эцсийн цэг хүртэл өндөр нууцлалтай шифрлэх, гүйлгээний бүх үе шатанд (шифрлэх, мэдээлэл дамжуулах, хадгалах) хэрэглэгчийн гүйлгээ үүсгэх, дансанд хандахад ашиглагдах нууц үг, түүнтэй адилтгах бусад мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангасан байх;	
2.3.4	Мэдээллийн технологийн үндсэн систем, техник, тоног төхөөрөмж (цаашид үндсэн төв гэх) гэмтэх, аливаа саатал гарах үед үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлэн хэвийн үргэлжлүүлэх хүчин чадал бүхий нөөц систем, мэдээллийн сан, дэд бүтэцтэй байх (цаашид нөөц төв гэх);	

2.3.5	Мэдээллийн технологийн нууцлал аюулгүй байдлын талаар авч хэрэгжүүлэх бодлого, журам, заавартай байх бөгөөд үүнд мэдээллийг шифрлэх, шифрлэсэн нууц мэдээллийг тайлж уншихтай холбогдсон түлхүүр, алгоритмыг зөвшөөрөлгүй этгээд олж мэдэхээс хэрхэн сэргийлэх, үндсэн төв болон нөөц төвийн сервер, серверийн өрөөний аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар тусгасан байх;	
2.3.6	Нөөц төвийг үндсэн систем байршиж байгаа газар нутагт тохиолдож болох эрсдэлийг харгалзан үзэж, ижил эрсдэл зэрэг үүсэхээргүй зайд байршуулсан байх;	
2.3.7	Үндсэн төв болон нөөц төвийг шууд холбосон байх;	
2.3.8	Хүсэлт гаргагчийн үндсэн төвийг операторын үндсэн төвтэй үндсэн ба нөөц шугамаар шууд холбосон байх;	
2.3.9	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч, операторын нөөц төвүүдийг шууд холбосон байх;	
2.3.10	Үндсэн болон нөөц систем байршиж байгаа барилга байгууламжид агаарын чийгшил тохируулагч систем, гал унтраах систем, аваар осол мэдрэгч төхөөрөмж, тог баригч байршуулсан байхаас гадна цахилгааны нэмэлт эх үүсвэртэй холбосон байх;	
2.3.11	Энэ журмын 2.3.10-т заасан цахилгааны нэмэлт эх үүсвэрээр үйл ажиллагааг хамгийн багадаа 24 цаг явуулах боломжтой байх;	
2.3.12	Үндсэн болон нөөц системд хандах эрх бүхий ажилтнуудын тухайн системд хандан хийж болох үйлдэл, хандалтын эрхийн хязгаарлалт, хандалт бүрийг тухайн ажилтан тус бүрээр тодорхойлж, баримтжуулдаг байх;	
2.4	Монголбанкны ажиллуулж байгаа клирингийн систем, Монголбанкнаас систем ажиллуулах зөвшөөрөл авсан этгээд, тэдгээрийн оролцогчдын гэнэтийн саатлын хугацаа нэг сард тухайн системийн нийт ажиллах цагийн 0.1 хувиас илүүгүй, төлөвлөгөөт зогсолтын хугацаа нэг сард 4 цагаас илүүгүй байна.	
2.5	Зайлшгүй шаардлагаар үндсэн болон нөөц төвийн үйл ажиллагааг зэрэг хамарсан программ, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх тохиолдолд энэ журмын 2.4-т заасан төлөвлөгөөт зогсолтын хугацааг Монголбанканд албан бичгээр мэдэгдэж тохиролцсоны үндсэн дээр сунгаж болно.	
2.6	Төлбөрийн системийн үйл ажиллагаа 2 минутаас дээш хугацаагаар, төлөвлөгөөт бусаар хэсэгчлэн болон бүрэн зогсох нь гэнэтийн саатал байна.	
<u>Заалт</u>	<u>Гурав. Хүсэлт гаргагчид тавих нэмэлт шаардлага-Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх</u>	<u>Тайлбар</u>
3.5	Хүсэлт гаргагч нь энэ журмын 2.1 болон 2.3-2.5-т зааснаас гадна дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:	

3.5.1	Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх этгээд нь “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль”-ийн 5.1.5-т заасан харилцах данс нээх эрх бүхий этгээдээс бусад этгээд байх тохиолдолд хэрэглэгчийн мөнгөн хөрөнгийг өөр дээрээ байршуулахгүй байх;	
3.5.2	Энэ журмын 3.5.1-т заасан этгээд нь банк, цахим мөнгө гаргагч дээрх хэрэглэгчийн дансанд хандаж мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх бол тухайн хэрэглэгчээс бусад этгээд дансанд хандах, гүйлгээ үүсгэх боломжгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байх;	
3.5.3	Дараах үйл ажиллагааг тусгасан гэрээ болон бусад баримт бичигтэй байна:	
3.5.3.1	Банк, цахим мөнгө гаргагч, хэрэглэгч, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг, тэдгээрийн хооронд үүсэх маргаан шийдвэрлэх зохицуулалт;	
3.5.3.2	Банк, цахим мөнгө гаргагчтай холбогдон ажиллах мэдээллийн технологийн шийдэл, ажиллах зарчим, мэдээллийн нууцлал, хадгалалт, дамжуулалт, боловсруулалтын талаарх дэлгэрэнгүй зохицуулалт;	
3.5.3.3	Хэрэглэгч тухайн үйлчилгээг авахыг зөвшөөрөх нөхцөл.	
<u>Заалт</u>	<u>Дөрөв.Зөвшөөрөл авах хүсэлт гаргах</u>	<u>Тайлбар</u>
4.1	Хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 11.1.12 болон 11.3.12-т заасан шаардлагын дагуу энэ журмын хавсралт 2-т заасан баримт бичгийг, хавсралт 1-т заасан өргөдлийн хамт Монголбанкны төлбөрийн систем хариуцсан нэгжид албан бичгээр өгнө.	
4.7	Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 33.1-т заасны дагуу хүсэлт гаргагч нь материал өгөхөөс өмнө зөвшөөрлийн материал хүлээж авах, хянах үйлчилгээний хураамжийг төлнө.	

Тайлбар: Цахим мөнгө гаргах хүсэлт гаргагчид тавигдах шаардлагыг дараах хүснэгтэд заасан жагсаалтын дагуу тайлбарын хамт ирүүлнэ. Тайлбар хэсэгт тухайн шаардлагыг өөрийн журам, заавар, холбогдох баримт бичгийн аль хэсэгт, ямар заалтаар хангаж байгааг тодорхой тэмдэглэн ирүүлнэ.

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль		
<u>Заалт</u>	<u>12 дугаар зүйл. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагчид тавих шаардлага</u>	<u>Тайлбар</u>
12.1	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч дараахь шаардлагыг хангасан байна:	
12.1.1	Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан;	

12.1.2	Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгө, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангасан;	
12.1.3	Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын зохистой тогтолцоо бүхий төлбөрийн үйлчилгээ үзүүлэх шаардлагыг хангахуйц техникийн болон зохион байгуулалтын чадвартай;	
12.1.4	Хэрэглэгчээс, эсхүл бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээс төлбөр гүйцэтгэхийн тулд хүлээж авсан мөнгөн хөрөнгийг өөр зорилгоор ашиглах, гуравдагч этгээдийн мөнгөн хөрөнгөтэй нийлүүлэх зэргээс хамгаалсан, төлбөрийн чадваргүй болсон үед үйлчилгээ үзүүлэгчийн бусад үүрэг гүйцэтгүүлэгчийн нэхэмжлэлээс тусгаарлах боломж бүхий тогтолцоотой;	
12.1.5	Таван жилийн стратеги болон бизнес төлөвлөгөөтэй;	
12.1.6	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдлэг, туршлага, мэргэжлийн ёс зүй, мэргэшлийн ур чадвар бүхий хүний нөөцтэй;	
12.1.7	Тухайн системд зөвшөөрөгдсөн гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэхэд шаардлагатай төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг баталгаажуулах, зээлийн эрсдэлээс хамгаалсан;	
12.1.8	Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөлийг хангах.	
12.2	Монголбанк энэ хуулийн 12.1.2-т заасан өөрийн хөрөнгийн хэмжээ, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг доор дурдсан хүчин зүйлсийг харгалзан үзэж тогтоох ба зөвшөөрөл авч байгаа этгээдийн зөвшөөрлийн нөхцөлд тодорхой тусгана:	
12.2.1	Үзүүлэх төлбөрийн үйлчилгээний төрөл;	
12.2.2	Төлбөрийн дундаж дүн;	
12.2.3	Холбогдох бусад хүчин зүйлс.	
12.3	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдэд тавих нэмэлт шаардлагыг Монголбанкнаас баталсан журмаар тогтооно.	
<u>Заалт</u>	<u>35 дугаар зүйл. Цахим мөнгө, цахим мөнгө гаргагчид тавих шаардлага</u>	<u>Тайлбар</u>
35.2	Цахим мөнгө дараахь шинжийг нэгэн зэрэг агуулсан байна:	
35.2.1	Мөнгөн дүн нь цахим хэлбэрээр хадгалагдсан;	
35.2.2	Мөнгөн хөрөнгөөр баталгаажсан;	
35.2.3	Цахим мөнгө гаргагч, түүний харилцагчаас бусад гуравдагч этгээд төлбөрт хүлээн зөвшөөрсөн;	
35.2.4	Цахим мөнгө нь мөнгөн хөрөнгөд, мөнгөн хөрөнгө нь цахим мөнгөнд чөлөөтэй хөрвөх.	
35.4.1	Цахим мөнгө нь зээлийн эх үүсвэр болохгүй;	
35.4.4	Хэрэглэгчийн анхны шаардлагаар цахим мөнгө болон төгрөгийг харилцан хөрвүүлэх үүрэг хүлээнэ.	

Төлбөрийн системийн журам		
<u>Заалт</u>	<u>Хоёр. Зөвшөөрөл авах хүсэлт гаргагчид тавих шаардлага</u>	<u>Тайлбар</u>
2.1	Хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 12 дугаар зүйлд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:	

2.1.1	Хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.9-т заасан шууд бус оролцогч байх тохиолдолд төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий нэг банкныг өөрийн төлбөр тооцооны төлөөлөгчөөр сонгосон;	
2.1.2	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь клирингийн, эсхүл төлбөр тооцооны системийн оролцогч болохоос өмнө тухайн системийн оператортай техникийн хамтарсан туршилт хийж, хоёр талаас баталгаажуулсан;	
2.1.3	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь QR код ашиглан гүйлгээ дамжуулах, хүлээн авахдаа Монголбанкнаас баталсан QR кодын цахим мэдээний бүтэц, зааврыг мөрдөж ажилладаг байх;	
2.1.4	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу хэрэглэгчийг таньж мэдэх үйл ажиллагааг тодорхой тусгасан дотоод журам, заавар, хяналтын тогтолцоог бий болгосон;	
2.1.5	Гадаад болон дотоод хүчин зүйлээс шалтгаалж төлбөрийн үйлчилгээ тасалдах, осол, гэмтэл гарах үед үйл ажиллагааны найдвартай, тасралтгүй байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөтэй;	
2.1.6	Хэрэглэгч, мерчантын мөнгөн хөрөнгийг найдвартай хадгалах, хамгаалах, гүйлгээний нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангахуйц энэ журмын 2.3-т заасан шаардлагыг хангасан мэдээллийн технологийн дэд бүтэцтэй;	
2.1.7	Хэрэглэгчийн данснаас зарлагын гүйлгээ хийх бүрд тухайн гүйлгээний мэдээллийг үйлчилгээний төлбөргүйгээр мэдэгдэж байх боломжийг бүрдүүлсэн;	
2.1.8	Хэрэглэгчийн хийсэн аливаа гүйлгээний түүх, гүйлгээний үе шат бүрийн талаарх мэдээллийг гаргах боломж бүхий системтэй байх;	
2.1.9	Төлбөрийн үйлчилгээтэй холбоотойгоор хэрэглэгч, мерчант болон бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс гаргасан гомдол, санал, маргаантай гүйлгээг цаг тухайд нь хүлээн авч шийдвэрлэх, тэдгээрт лавлагаа мэдээлэл өгөх үйл ажиллагааны талаар тусгасан дотоод журам, заавартай байх;	
2.1.10	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос үүдэн төлбөрийн үйлчилгээг зогсоох үед хэрэглэгч, мерчантын авлагыг барагдуулахтай холбоотой авах арга хэмжээний талаар тусгасан журамтай байх;	
2.1.11	Хүсэлт гаргагч нь хэрэглэгчтэй байгуулах гэрээнд дараах зүйлсийг тусгана:	
2.1.11.1	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн мэдээллийг нууцлах, хадгалах, ашиглах тухай;	
2.1.11.2	Хэрэглэгч нь ПИН код буюу гүйлгээг баталгаажуулахад ашиглагдах, зөвхөн тухайн хэрэглэгч мэдэж байх тоо, үсэг, тэмдэгтийн дараалал, түүнтэй адилтгах бусад мэдээллийг нууцлах, түүнийг хаяж үрэгдүүлсэн, гуравдагч этгээд мэдсэн	

	байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид нэн даруй мэдэгдэх тухай;	
2.1.11.3	Хэрэглэгч нь өөрийн данснаас түүний зөвшөөрөлгүй хийгдсэн аливаа шилжүүлэг болон бүртгэлийн алдаа, зөрчил дутагдлыг илрүүлсэн тохиолдолд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид нэн даруй мэдэгдэх тухай;	
2.1.11.4	Хэрэглэгчийг таньж баталгаажуулах арга, хэрэгсэл болон баталгаажуулсан гэж үзэх нөхцөл;	
2.1.11.5	Хэрэглэгч тухайн гүйлгээг илгээхийг зөвшөөрсөн, баталгаажуулсан гэж үзэх нөхцөл;	
2.1.11.6	Хэрэглэгч гомдол, маргаан үүсгэх нөхцөл, шийдвэрлэх арга зам, хугацаа;	
2.1.11.7	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос үүдэн төлбөрийн үйлчилгээг зогсоох үед хэрэглэгчийн авлагыг барагдуулахтай холбоотой авах арга хэмжээ, эрх, үүрэг.	
2.1.12	Хүсэлт гаргагч нь мерчанттай байгуулах гэрээнд дараах зүйлсийг тусгана:	
2.1.12.1	Монголбанкны зөвшөөрөлтэй төлбөрийн хэрэгслийг бараа, ажил, үйлчилгээний төлбөрт хүлээн авах тухай;	
2.1.12.2	Төрийн үйлчилгээний төлбөр, орон сууцны хэрэглээний төлбөр төлөхөөс бусад картын гүйлгээ хийх тохиолдолд мерчант нь карт эзэмшигчээс шимтгэл авахгүй байх тухай;	
2.1.12.3	Мерчант нь Монгол Улсын нутаг дэвсгэрт төлбөр хүлээн авах тухай;	
2.1.12.4	Мерчантаас гомдол, маргаан үүсгэх нөхцөл, шийдвэрлэх арга зам, хугацаа;	
2.1.12.5	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос үүдэн төлбөрийн үйлчилгээг зогсоох үед мерчантын авлагыг барагдуулахтай холбоотой авах арга хэмжээ, эрх, үүрэг.	
2.1.13	Хүсэлт гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байх;	
2.1.14	Хүсэлт гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өрийн үлдэгдэлгүй, шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй байх;	
2.1.15	Монголбанкнаас тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бүрдүүлсэн байх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгө нь гуравдагч этгээдийн шаардлагаас ангид, тухайн этгээдийн санхүүгийн тайлан, татвар төлөлтийн тайлангаар батлагдсан хууль ёсны үйл ажиллагааны орлого байна.	
<u>Заалт</u>	<u>Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх болон систем ажиллуулах зөвшөөрөл авах хүсэлт гаргагчийн мэдээллийн аюулгүй байдалд тавигдах нийтлэг шаардлага</u>	<u>Тайлбар</u>
2.3	Хүсэлт гаргагч нь мэдээллийн технологи, тасралтгүй ажиллагаанд дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:	

2.3.1	Дотоод сүлжээ, вэбсайт, сервер, бусад тоног төхөөрөмж рүү гаднаас халдах боломжгүй байх нөхцөлийг бүрдүүлж, байгууллагын мэдээллийн системийг аливаа сэжиг бүхий, эсхүл зөвшөөрөгдөөгүй хандалтаас хамгаалах галт хана суурилуулсан байх бөгөөд энэ нь интернэт болон бусад сүлжээгээр дамжин байгууллагын мэдээллийн системд хандах эрсдэлийг авч үзсэн байх;	
2.3.2	Хэрэглэгчийн болон гүйлгээний мэдээлэлд хандаж байгаа бүх хандалтыг хянаж, бүртгэлжүүлэх тогтолцоог бий болгосон байх;	
2.3.3	Гүйлгээ хийх, нууц мэдээлэл дамжих үед тухайн мэдээллийг дамжуулах эхний цэгээс хүлээн авах эцсийн цэг хүртэл өндөр нууцлалтай шифрлэх, гүйлгээний бүх үе шатанд (шифрлэх, мэдээлэл дамжуулах, хадгалах) хэрэглэгчийн гүйлгээ үүсгэх, дансанд хандахад ашиглагдах нууц үг, түүнтэй адилтгах бусад мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангасан байх;	
2.3.4	Мэдээллийн технологийн үндсэн систем, техник, тоног төхөөрөмж (цаашид үндсэн төв гэх) гэмтэх, аливаа саатал гарах үед үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлэн хэвийн үргэлжлүүлэх хүчин чадал бүхий нөөц систем, мэдээллийн сан, дэд бүтэцтэй байх (цаашид нөөц төв гэх);	
2.3.5	Мэдээллийн технологийн нууцлал аюулгүй байдлын талаар авч хэрэгжүүлэх бодлого, журам, заавартай байх бөгөөд үүнд мэдээллийг шифрлэх, шифрлэсэн нууц мэдээллийг тайлж уншихтай холбогдсон түлхүүр, алгоритмыг зөвшөөрөлгүй этгээд олж мэдэхээс хэрхэн сэргийлэх, үндсэн төв болон нөөц төвийн сервер, серверийн өрөөний аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар тусгасан байх;	
2.3.6	Нөөц төвийг үндсэн систем байршиж байгаа газар нутагт тохиолдож болох эрсдэлийг харгалзан үзэж, ижил эрсдэл зэрэг үүсэхээргүй зайд байршуулсан байх;	
2.3.7	Үндсэн төв болон нөөц төвийг шууд холбосон байх;	
2.3.8	Хүсэлт гаргагчийн үндсэн төвийг операторын үндсэн төвтэй үндсэн ба нөөц шугамаар шууд холбосон байх;	
2.3.9	Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч, операторын нөөц төвүүдийг шууд холбосон байх;	
2.3.10	Үндсэн болон нөөц систем байршиж байгаа барилга байгууламжид агаарын чийгшил тохируулагч систем, гал унтраах систем, аваар осол мэдрэгч төхөөрөмж, тог баригч байршуулсан байхаас гадна цахилгааны нэмэлт эх үүсвэртэй холбосон байх;	
2.3.11	Энэ журмын 2.3.10-т заасан цахилгааны нэмэлт эх үүсвэрээр үйл ажиллагааг хамгийн багадаа 24 цаг явуулах боломжтой байх;	
2.3.12	Үндсэн болон нөөц системд хандах эрх бүхий ажилтнуудын тухайн системд хандан хийж болох үйлдэл, хандалтын эрхийн хязгаарлалт, хандалт бүрийг тухайн ажилтан тус бүрээр тодорхойлж, баримтжуулдаг байх;	

2.4	Монголбанкны ажиллуулж байгаа клирингийн систем, Монголбанкнаас систем ажиллуулах зөвшөөрөл авсан этгээд, тэдгээрийн оролцогчдын гэнэтийн саатлын хугацаа нэг сард тухайн системийн нийт ажиллах цагийн 0.1 хувиас илүүгүй, төлөвлөгөөт зогсолтын хугацаа нэг сард 4 цагаас илүүгүй байна.	
2.5	Зайлшгүй шаардлагаар үндсэн болон нөөц төвийн үйл ажиллагааг зэрэг хамарсан программ, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх тохиолдолд энэ журмын 2.4-т заасан төлөвлөгөөт зогсолтын хугацааг Монголбанканд албан бичгээр мэдэгдэж тохиролцсоны үндсэн дээр сунгаж болно.	
2.6	Төлбөрийн системийн үйл ажиллагаа 2 минутаас дээш хугацаагаар, төлөвлөгөөт бусаар хэсэгчлэн болон бүрэн зогсох нь гэнэтийн саатал байна.	
<u>Заалт</u>	<u>Гурав. Хүсэлт гаргагчид тавих нэмэлт шаардлага- Цахим мөнгө гаргах</u>	<u>Тайлбар</u>
3.4	Хүсэлт гаргагч нь энэ журмын 2.1 болон 2.3-2.5-т зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:	
3.4.1	Банкнаас бусад цахим мөнгө гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 2,500,000,000 (хоёр тэрбум таван зуун сая) төгрөгөөс доошгүй байх;	
3.4.2	Цахим мөнгө нь мөнгөн хөрөнгөөр баталгаажиж, мөнгөн дүн нь цахим хэлбэрээр хадгалагддаг байх;	
3.4.3	Цахим мөнгөний үйлчилгээ нь бусдаас ялгарах өөрийн гэсэн оноосон нэртэй байх;	
3.4.4	Цахим мөнгө нь мөнгөн хөрөнгөнд, мөнгөн хөрөнгө нь цахим мөнгөнд чөлөөтэй хөрвөдөг байх;	
3.4.5	Цахим мөнгө гаргах, түүнийг мөнгөн хөрөнгөнд хөрвүүлэх, гүйлгээ хийх болон төлбөр төлөх үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журамтай байх;	
3.4.6	Хэрэглэгчийн болон дансны бүрэн мэдээллийг агуулсан, нарийвчилж хөтлөх боломж бүхий бүртгэлийн системтэй байх бөгөөд тус систем нь:	
3.4.6.1	Цахим мөнгөний хөдөлгөөнийг хянах;	
3.4.6.2	Нийт цахим мөнгө болон хэрэглэгчийн данс дахь цахим мөнгөний тоо хэмжээг хянах;	
3.4.6.3	Хэрэглэгчийн зөвшөөрсөн хэмжээнээс илүү гүйлгээ хийх, данс андуурсан зэрэг санамсаргүй үйлдэл, луйврын болон сэжигтэй гүйлгээг илрүүлэх, гүйлгээг зогсоох, буцаах, түүнээс үүсэх маргааныг шийдвэрлэх боломжтой байх.	
3.4.7	Хүсэлт гаргагч нь өөрийн гаргах цахим мөнгөнд баталгаа болгож мөнгөн хөрөнгө байршуулах зорилгоор баталгааны данс нээсэн байх;	
3.4.8	Цахим мөнгө гаргагч нь банк бол баталгааны дансыг Монголбанканд, банкнаас бусад хуулийн этгээд бол Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг сүүлийн дөрвөн улирлын турш тогтмол хангаж ажилласан банканд байршуулах;	

3.4.9	Хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 35.4-т заасан нөхцөлийг хангасан байх;	
3.4.10	Бүртгэлгүй хэрэглэгч нь цахим мөнгө гаргагчтай гэрээ байгуулахгүйгээр цахим мөнгөний үйлчилгээ авах иргэн, хуулийн этгээд байх.	
<i>Заалт</i>	<i>Дөрөв.Зөвшөөрөл авах хүсэлт гаргах</i>	<i>Тайлбар</i>
4.1	Хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 11.1.12 болон 11.3.12-т заасан шаардлагын дагуу энэ журмын хавсралт 2-т заасан баримт бичгийг, хавсралт 1-т заасан өргөдлийн хамт Монголбанкны төлбөрийн систем хариуцсан нэгжид албан бичгээр өгнө.	
4.7	Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 33.1-т заасны дагуу хүсэлт гаргагч нь материал өгөхөөс өмнө зөвшөөрлийн материал хүлээж авах, хянах үйлчилгээний хураамжийг төлнө.	

**ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ХАЯГ, БАЙРШИЛ, НЭРИЙН
ӨӨРЧЛӨЛТ БҮРТГЭХ МАЯГТ**

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргасан хуулийн этгээдийн нэр						
Регистрийн дугаар						
Өөрчлөгдөх мэдээллийн төрлийг сонгоно уу.						
☐ Гүйцэтгэх удирдлага, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн өөрчлөлт ☐ Хаяг, байршилын өөрчлөлт ☐ Хуулийн этгээдийн нэр/үйлчилгээний нэрийн өөрчлөлт						
Гүйцэтгэх удирдлагад өөрчлөлт оруулах						
Өөрчлөлт орсон албан тушаал	Овог	Нэр	Харьяалал	РД	Утасны дугаар	Мэргэжил
Хаяг, байриилд өөрчлөлт оруулах						
Шинэчлэгдсэн хаяг байриил	Аймаг/Хот					
	Сум/Дүүрэг					
	Баг/Хороо					
	Гудамж/байр					
	Тоот					
	Холбоо барих утас					
	Цахим хуудас					
	Цахим хаяг					

**ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ ӨӨРЧЛӨГДӨХӨД
БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ**

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Гүйцэтгэх удирдлагыг өөрчлөх, томилох тухай шийдвэр	
2	Шинээр томилогдсон гүйцэтгэх удирдлагын иргэний үнэмлэхний цахим лавлагаа, мэргэжлийн дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	
3	Хувьцаа эзэмшигчийн иргэний үнэмлэхний цахим лавлагаа	
4	Гүйцэтгэх удирдлага нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авилга, хээл хахууль, эдийн засгийн эсрэг эрүүгийн хариуцлага хүлээгээгүй болохыг нотлох холбогдох байгууллагын тодорхойлолт	
5	Гүйцэтгэх удирдлага нь зээл, батлан даалт, гааль, татвар, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өрийн үлдэгдэлгүй, шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй болохыг нотлох холбогдох байгууллагын тодорхойлолт	

**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НЭР ӨӨРЧЛӨХ ӨРГӨДӨЛД
ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Хуулийн этгээдийн нэр, үйлчилгээний нэр өөрчлөх тухай хурлын тэмдэглэл, шийдвэр	
2	Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас авсан хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын хуудас	
3	Дүрэмд орсон өөрчлөлт	

БАТАЛГААНЫ МАЯГТ

Тайланг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай

Дугаар

... он сар өдөр

/Хуулийн этгээдийн нэр/

/Салбар, нэгжсийн нэр/

/Албан тушаал/

/тайлангийн системийн холбоос, тайлангийн системд бүртгэгдсэн цахим шуудангийн хаяг/

Төлбөрийн системийн тайлан гаргах зааврын хүснэгтийг сонгож тэмдэглэнэ үү.

Хүснэгт 1, 2, 3, 4, 6

Хүснэгт 5, 7, 8, 9, 10

Хүснэгт 11, 12, 13, 14

Хүснэгт 15, 16

Хүснэгт 18, 19

Хүснэгт 20, 21

Цахим системд тайланг үүсгэсэн огноо: 0000-сс-00

Тайлангийн баталгааны маягтыг хүлээн авч, цахим системд баталгаажуулсан огноо:
0000-сс-00 цц.мм.сс

..... /эцэг, эх-ийн нэр/ /нэр/ миний бие
Монголбанкнаас баталсан “Төлбөрийн системийн журам”-ын 8 дугаар бүлэгт заасны
дагуу хуудас бүхий тайланг Монголбанкны тайлангийн системд бүрэн гүйцэд, үнэн зөв
мэдүүлснээ баталж байна. Тайлан мэдүүлэхтэй холбоотой үүргээ зөрчвөл хууль,
тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

Баталгаа гаргасан:

/Овог, нэр/

/Гарын үсэг/

**ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ОРОЛЦОГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ГАЗАР ДЭЭР НЬ ХИЙХ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ**

..... оны дугаар сарын
.....-ны өдөр

Улаанбаатар
хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Монголбанкны ТТГ-аас төлбөрийн системийн оператор/оролцогчийн үйл ажиллагаанд газар дээр нь хийх шалгалтыг энэхүү удирдамжийн дагуу хийж гүйцэтгэнэ.

1.2 Шалгалтын зорилго нь (цаашид “оператор/оролцогч” гэх)-ны төлбөрийн системтэй холбоотой үйл ажиллагаа нь холбогдох хууль, тогтоомж, Монголбанкнаас баталсан журам, заавартай нийцэж байгаа эсэхийг газар дээр нь баримтад үндэслэн шалган тогтоож, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч, хариуцлага ногдуулах замаар төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг баталгаажуулахад оршино.

1.3 Шалгалтын хэлбэр:

- Иж бүрэн;
- Хэсэгчилсэн.

1.4 Шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

- Ажлын хэсгийн ахлагч;
- Ажлын хэсгийн гишүүд.

1.5 Оператор/оролцогч нь шаардлагатай тайлан мэдээ, төлбөр тооцооны баримт, материалыг ажлын хэсэгт шаардсан хугацаанд нь саадгүй гаргаж өгөх, бүртгэлийн болон бусад холбогдох программ хангамжид нэвтрэн шалгалт хийх нөхцөл бололцоогоор бүрэн хангана.

1.6 Ажлын хэсгийг ахлагч нь шалгалтыг тогтоосон хугацаанд үр дүнтэй хийж гүйцэтгэхэд ажлын хэсгийг зохион байгуулж ажиллахын зэрэгцээ шалгалтын явц, дүнгийн талаар болон шаардлагатай гэж үзсэн тохиолдолд шалгалтын удирдамжид өөрчлөлт оруулах талаар саналаа Монголбанкны удирдлагад танилцуулж шийдвэрлүүлнэ.

ХОЁР. ШАЛГАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 “Төлбөрийн системийн журам”-ын 8 дугаар бүлэгт заасан хамрах хүрээ, чиглэлээр тодорхойлогдоно.

ГУРАВ. ШАЛГАЛТЫН ДҮНГ ГАРГАХ

- 3.1 Шалгалтын явцад Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн дагуу ажлын хэсгийн гишүүд бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж, зөрчил, дутагдлыг залруулах арга хэмжээ авч ажиллана.*
- 3.2 Ажлын хэсгийн ахлагч удирдамжийн дагуу шалгалт хийсэн тухай тайлан, материал бэлтгэж, шалгалтын дүгнэлт, авсан арга хэмжээний талаар шалгалт хийж дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор Монголбанкны удирдлагад танилцуулна.*
- 3.3 Шалгалтын тайланг удирдлагад танилцуулснаас хойш ажлын өдрийн дотор оператор/оролцогч бүрт тухайн оператор/оролцогчид хамаарах шалгалтын үр дүнгийн талаар мэдэгдэнэ.*

_____оОо_____